

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-67
1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тайлан	13-25
2.“Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	25-42 59-60
3.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	42-43
4.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	43-44 60-61
5.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	44-59 62-67

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 34 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Р.Сэддорж, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;
Тасалсан: Ч.Лодойсамбуу, З.Мэндсайхан, О.Цогтгэрэл.

Нэг.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч Э.Анар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилох тухай саналыг Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт нар танилцуулав.

Тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Г.Очирбат, М.Мандхай нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч Э.Анар, Байнгын хорооны дарга Б.Заяабал нар хариулж, тайлбар хийв.

Б.Заяабал: Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 6

Бүгд: 24
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Заяабал “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга С.Цэрэнжамц, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ, мөн хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Заяабал тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, А.Ундраа, Н.Батсүмбэрэл, С.Цэнгүүн, Ч.Анар, Х.Булгантуяа, Б.Уянга, П.Батчимэг, Р.Батболд, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, Байнгын хорооны дарга Б.Заяабал, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:23/

Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран, мөн газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Заяабал хуулийн төслийн эцсийн хувилбарыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Х.Сүрэнхорол, С.Тэнгис, Г.Жавхлантөгс, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:23/

Тав.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн газрын Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Пүрэвжал, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, мөн газрын шинжээч Б.Баярсайхан, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Байнгын хорооны хуралдаан 13 цаг 24 минутаас 16 цаг 15 минутад түр завсарлав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, О.Батнайрамдал, Г.Очирбат, Б.Жаргалан, Б.Мөнхсоёл, С.Эрдэнэбат, Ш.Бямбасүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:01/

“Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг горимын санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга

Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга С.Цэрэнжамц, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ, мөн хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар “Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 10

Бүгд: 25

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Уг асуудлыг 17 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн/-ийн нэгтгэсэн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Х.Сүрэнхорол, С.Тэнгис, Г.Жавхлантөгс, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг

асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу хураалгах санал:

Б.Заяабал:1.Төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу хураалгах санал:

Б.Заяабал: 1.Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийн “**ХАРИУЦЛАГА**” гэснийг “**ГОМДОЛ ГАРГАХ,**” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг 7 дугаар зүйлтэй нэгтгэн, 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

5.1.Бизнес эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх, бизнес эрхлэгчид учирсан хохирлыг хуульд заасны дагуу нөхөн төлөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 6
Бүгд: 25
76.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “үндэслэлгүй хяналт шалгалт хийх,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 5
Бүгд: 25
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн газрын Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Пүрэвжал, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Өнөрнасан, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, мөн газрын шинжээч Б.Баярсайхан, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Кадастрын хэлтсийн дарга М.Энхтулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу хураалгах санал:

1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Заяабал: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.38.“маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардлагатай хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэх Монгол Улсын иргэнд олгох эрхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	6
Бүгд:	26

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29¹ дүгээр зүйл, 29² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29¹ дүгээр зүйл.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

29¹.1.Ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн олборлож байгаа эсэхэд хяналт тавих, нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг тодорхойлох, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатны төлөвлөлтөд хяналт тавих, уурхайн хажуу болон хаягдал овоолгын чулуулгийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29¹.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

29² дугаар зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа

29².1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

29².1.1.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолгын хэмжээ, уулын ажилд хамрагдсан талбай, ил болон далд уурхайн төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

29².1.2.ашигт малтмалын ордын нөөцийг хэрхэн ашиглаж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргах;

29².1.3.энэ хуулийн 29².1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно;

29².1.4.энэ хуулийн 29².1.1-д заасан хөндлөнгийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцах;

29².1.5.энэ хуулийн 29².1.1-д заасан үйл ажиллагааг хөндлөнгийн хараат бусаар хэрэгжүүлэх.

29².2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах заавар, шаардлагыг төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	6
Бүгд:	26

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	7
Бүгд:	26

73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нартай зөвшилцсөнөөр хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан үг хэлэв.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	8
Бүгд:	26

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу хураалгах санал:

Б.Заяабал: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64¹ дүгээр зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглоно” гэснийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох” гэж өөрчилж, 64¹ дүгээр зүйлийн 64¹.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 5
Бүгд: 26
80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Б.Заяабал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Бат-Эрдэнэ, Б.Мөнхсоёл Л.Соронзонболд, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Г.Уянгахишиг, С.Эрдэнэбат нарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 13
Бүгд: 26
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу хураалгах санал:

Б.Заяабал: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 6

Бүгд: 26
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 5
Бүгд: 26
80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 5
Бүгд: 26
80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрээс “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 5
Бүгд: 26
80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 02 минут үргэлжилж, 32 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 81.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
11 цаг 34 минут.*

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Заяабал: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдааны ирц 59.4 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 26 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг та бүхэнд бас танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралд одоогийн байдлаар Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Шинэбаярын Бямбасүрэн, Болдын Жавхлан, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Баатаржавын Мөнхсоёл, Эрдэнэбилэгийн Одбаяр, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хороонд ирцэд орсон эрхэм гишүүдийг Байнгын хорооныхоо хуралд хүрэлцэн ирэхийг бас урья.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд бас танилцуулъя.

1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэхээр байгаа.

2.“Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

3.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

4.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

5.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахаар байна.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудлын дарааллаар хэлэлцээд явъя.

Хэлэлцэх асуудлын Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцэнэ.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн уншиж танилцуулна. Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төв банк Монголбанкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монголбанкны ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк санхүү, удирдлагын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо, цаашид Байнгын хороог явуулна гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

Монголбанкны Ерөнхийлөгч Наранцогтоос 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хурлын даргад Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилуулах санал өргөн мэдүүлэх тухай албан бичиг ирүүлсэн.

Мөн нэр дэвшигч Э.Анар Байнгын хорооны 2024 оны 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн.

2026 оны 06 дугаар сарын 09, 29-ний өдрүүдийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3, 121.4, 122 дугаар зүйлийн 122.1, 130 дугаар зүйлийн 130.1, 130.4, 130.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай 04, 07 дугаар дахь тогтоолыг баталж, 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг сонгосон.

Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигч Анарын мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан. Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх сонсголын зарыг 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 23-ны өдөр хүртэл Улсын Их Хурлын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байршуулж, сонсгол, оролцогчдын бүртгэл, асуултыг олон нийтэд нээлттэй хүлээн авсан.

Сонсголын заруудын дагуу сонсголд оролцохоор 13 оролцогч 3 ажиглагч цахим хаягаар бүртгүүлж, асуултаа урьдчилан ирүүлсэн болно.

Сонсголд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэж сонсгол эхлэх бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн сонсгол Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээс Улсын Их Хурлын гишүүн Анар, Батсүмбэрэл, Бямбасүрэн, Золжаргал, Мэндсайхан, Пунсалмаа, Уянга, Эрдэнэбат, Баатархүү, Батчимэг, Жавхлан, Лувсанжамц, Мөнхсоёл, Соронзонболд, Цэнгүүн,

Үүрийнтуяа, Батболд, Булгантуяа, Заяабал, Мандхай, Одбаяр, Ундраа, Энх-Амгалан, Батнайрамдал нар хүрэлцэн ирж, ирц 75 хувь байсан болно.

Нэр дэвшигч Анар нь тухайн албан тушаалд нэр дэвшсэн үндэслэл, томилогдсон тохиолдолд хийх ажил, боловсролын ажлын туршлага нь тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан сонсголд оролцогч Лхагвасүрэнгийн Амар, Доржпүрэвийн Баасандорж, Өнөрбаярын Галцог, Бямбацогтын Зоригтбаяр, Мөнхбатын Бүдбазар, Гомбосэдийн Хонгор, Гомбодоржийн Эрдэнэмөнх нар асуулт асууж, хариулт авсан бөгөөд оролцогчдын асуулт, саналыг агуулгаар нэгтгэн тойм томилбол

Нэгдүгээрт, үндэсний төлбөрийн системийн хөгжлийн бодлогыг шинэ шатад гаргах. Цахим төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн системийн хөгжлийг дараагийн түвшинд хүргэх урт хугацааны бодлого, зорилтыг тодорхойлох, санхүүгийн салбарын инновац, финтекийн хөгжлийг дэмжих, зээлийн мэдээллийн сангийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах, шинэчлэлийг эрчимжүүлэх.

2.Цахим шилжилт, дижитал санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх, Монголбанкны удирдан хэрэгжүүлсэн цахим шилжилтийн ажлуудын үр дүнг бататгаж, төлбөр тооцооны үйлчилгээний хурд, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх цахим санхүүгийн үйлчилгээг тасралтгүй сайжруулах.

3.Эрх зүйн орчин, засаглал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нарийвчилсан журам, зохицуулалтыг боловсронгуй болгох, журам боловсруулах, шинэчлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлэх. Монголбанкны газар, нэгжүүдийн уялдаа холбоо, чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулж, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид тавих хяналт, зохицуулалтыг хараат бус, шударга, ашиг сонирхлын зөрчилгүй хэрэгжүүлэх.

4.Санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний бодлогын үндэслэлийг бэхжүүлэх, Монголбанкны санхүүгийн тайлан өөрийн хөрөнгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлох. Гадаад валютын зах зээлийн либералчлал ханшийн бодлоготой холбоотой шийдвэрүүдийг эдийн засгийн суурь судалгаа, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлэх. Экспортын орлогын төвлөрөл болон үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг нягтлан үнэлэх.

Тавдугаарт, олон улсын төлбөр, тооцооны эрсдэлийг бууруулах, геополитикийн нөхцөл байдал, олон улсын хориг арга хэмжээний улмаас үүсэж буй төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, олон улсын төлбөрийн сувгийн найдвартай ажиллагааг хангах чиглэлд бодлого зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгааг тус тус онцолж байлаа.

Мөн нэр дэвшигчээс Улсын Их Хурлын 14 гишүүн асуулт асууж, хариулт авсан. 3 гишүүн санал хэлсэн. Сонсголд оролцсон Эдийн засгийн байнгын хорооны гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулсны дараа хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг та бүхэнд цаасаар хүргүүлсэн.

Нэр дэвшигчээс ирүүлсэн материал, сонсголын үр дүнд үндэслэн нэр дэвшигчийгээ Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид тавигдах шаардлагыг хангасан гэж үзэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилуулахыг дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Сонсголын дүнг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Заяабал: Соронзонболд гишүүнд баярлалаа. Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн талаараа Монголбанкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт танилцуулна. Индрийн микрофоныг нээе. Наранцогт Ерөнхийлөгчийг урьж байна.

С.Наранцогт: Эрхэм Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилуулах санал өргөн мэдүүлэх тухай.

Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлж байна.

Анар нь 1984 онд Улаанбаатар хотод төрсөн 1992-2001 онд Нийслэлийн 10 жилийн 1 дүгээр дүгээр дунд сургууль, 2001-2004 онд Япон Улсын Хакуо ахлах сургууль, 2004-2008 онд Япон Улсын Хакуо Их Сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн бөгөөд 2007-2008 онд Америкийн Нэгдсэн Улсын Индианагийн их сургууль, 2014-өөс 15 онд Америкийн Нэгдсэн Улсын Колумбын их сургуульд тус тус суралцаж, Эдийн засгийн бодлогын удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Англи, Япон хэлтэй.

Анар нь 2011-2013 онд Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Гадаад валютын нөөцийн хэлтсийн нөөцийн мэргэжилтэн, 2013-2016 онд Монголбанкны Хяналт шалгалтын газрын Зайнаас хяналт тавих хэлтсийн хянан шалгагч, 2016-2017 онд Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газры захирал 2017-2026 онд Монголбанкны Төлбөр, тооцооны газрын захирлаар ажилласан туршлагатай бөгөөд 2026 оноос Монголбанкны Төлбөрийн систем, технологийн газрын захирлаар ажиллаж байна.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Э.Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлэхдээ түүний эдийн засаг, банк санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын дадлага зуршлыг харгалзан үзсэн болно.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа. Баярлалаа.

Б.Заяабал: Одоо Дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 4-д заасны дагуу гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Мандхай гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг олгоё.

Да.Цогтбаатар: Баярлалаа та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монголбанкны Ерөнхийлөгчөөс зарчмын хувьд нэг асуулт асуух гэсэн юм. Тэргүүн дэд ерөнхийлөгчийн орон тоо хоосон байгаа, дэд ерөнхийлөгчийнх нь хугацаа дуусчихсан байгаа. Тэгээд 2 дэд ерөнхийлөгчийн асуудал байхад та яагаад нэгийг нь оруулж ирж байгаа юм бэ? Явах эхнэрт үнээ, тугал нийлэх хамаагүй гэж төлбөр тооцоо хариуцаж үлдэж байгаа дэд ерөнхийлөгчийн чинь хугацаа нь дуусчихсан, хийх ажил нь тодорхойгүй болчихсон байхад энийг ингээд хугацааг нь дуусгаад шинэ хүнтэйгээ цуг 2 дэд ерөнхийлөгчөө оруулж ирээд энэ инфляцтайгаа, энэ төгрөгийнхөө ханштай эртхэн шиг зодолдож байсан бол танд хэрэгтэй биш үү гэж нэг ийм асуулт байгаа юм.

Хоёрт нь Эдийн засгийн байнгын хорооны даргаас бас асуух гэж байгаа юм. Ийм томилгоог хийхээд инфляц чинь буурахгүй, төгрөгийн ханш чинь чангарахгүй бол бид нар хэндээ ямар хариуцлага тооцох юм? Жишээлэхэд Эдийн засгийн байнгын хорооны дарга энэ дээр ямар хариуцлага хүлээх юм гэж.

Тэгээд нэр дэвшигчээс асуух хэд хэдэн асуулт байна. Тэгээд ер нь эцэг эхэд бол буруу алгаа зайлуул. Үхтэл үр харам гэж үрийнхээ төлөө явах байх. Гэхдээ та одоо хийж байгаа ажлаа маш сайн хийгээд маш сайн байна. Тэгээд энэндээ байгаад би одоо ийм зарчим ийм юу гэдэг юм ёс зүй гаргаад нэрээ татаж байна гээд нэрээ татчихаж чадах уу гэж. Тэгээд нэрээ татахгүй ээ энэ чигээрээ ингээд зүтгээд ормоор байна гээд үнэхээр хүсээд байгаа юм бол ямар хугацааны дотор ямар үр дүн гаргах юм гэдгээ бас тодорхой хэлээд өгөөч ээ.

Жишээлэх юм бол энэ ар 12 банкнаас чинь 2 банк нөгөө тавигдаж байгаа шаардлагаа хангаж чадахгүй, дампууруулж чадахгүй Монгол Ардын намынхны хайртай хөрөнгө оруулагч нар нь учраас өнөөдрийг болтол зүв зүгээр явж байгаа. Төрийн мөнгө тэнд бас хүүгүй, эрсдэлтэй нөхцөлд хэвтэж байгаа энэхүү байдлууд дээр та ямар арга хэмжээ авах юм бэ?

Хоёрт нь И банк гэдэг юмыг болиулж өгөөч ээ гээд маш олон хүнээс хүсэлт ирж байгаа. Энэ ажил гэхэд хэцүү юм. Энэ хүнд гай болсон ажлаа болиулах ажил хийх үү?

Гуравд нь Зээлийн мэдээллийн сан гээд энэ тодор сайжруулаад л яваад байгаа л даа. Тэгэхдээ энийгээ өшөө сайжруулаад ямар ч шалтгаанаар хүн хар жагсаалтад орсон, бүртгэгдсэн байж болоод байгаа юм. Нэг гар утас авсан, өөр энэ чинь сүүлийн үед бол СӨХ-ны төлбөрөө төлөөгүй үед хүртэл оруулчхаад байгаа юм. Тэгэхээр иргэдээс ирж байгаа 1 хүсэлт нь удаагийн энэ хар жагсаалтаас гаргах ажлыг хийж өгөөч ээ гэж байна. Энэ дээр та ямар байр суурьтай байх вэ? Ямар ажил хийх вэ гэж байгаа юм.

Тэгээд цаашид хийх ажил чинь бол байгаа энэ төлбөр тооцоотой холбоотой ажлуудаа л нэлээн сайн хийнэ. Эсвэл яг энэ чиглэлийнхээ мөрөөдлийг нэлээн бичиж байж таны чиг үүрэгт харьяалах ажил чинь бол энэ арилжааны хэдэн банк, тэдгээрийн хэдэн даварчихсан эзэдтэй үзэх ажил байгаа шүү дээ. Энэ дээр яаж

дорвитой үр дүн гаргаж ажиллаж чадах юм бэ гэдэг ийм хэдэн асуултад хариулт авъя.

Б.Заяабал: Эхлээд Байнгын хорооноос асуусан асуултад хариулъя. Тэгэхлээр Төв банкны тухай хуулийн 26.2-оор Их Хурлаас сонгодог албан тушаалтныг нэр дэвшүүлэх эрх нь Төв банкны Ерөнхийлөгчид байгаа. Энэ журмын дагуу Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хуралд орж ирсний дагуу Дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу бид нар хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулж явуулах ийм Улсын Их Хурлын хуралдааны дэгтэй.

Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3.7-д Улсын Их Хурлаас томилдог албан тушаалтныг томилох, чөлөөлөх, огцруулах, эргүүлэн татах асуудлаар санал, дүгнэлт гаргах эрх манай Байнгын хороонд бас байгаа гэдгийг бас хариулт болгож хэлье.

Ингээд саяын гишүүний асуусан хариултад Монголбанкны Ерөнхийлөгч Наранцогт, дараа нь нэр дэвшигч хариулъя.

С.Наранцогт: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Таны зөв өө манай дэд ерөнхийлөгчийн хугацаа манай хүмүүсийн өгсөн мэдээллээр бол саяхан дуусаад хэд хонож байгаа. Тэгээд яг энэ бичгийг өргөн барих үед бол дэд Ерөнхийлөгчийн асуудлаа тогтож ингээд явуулах боломж гарсангүй. Би эний асуудлыг удахгүй хуулийн дагуу оруулж ирнэ.

Б.Заяабал: Нэр нэр дэвшигч индрийн микрофон.

Э.Анар: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт мэдээж Монголбанкны дунд хугацааны стратеги гэж бид нар шинээр баталсан байгаа. Энэ стратегийн хүрээнд бол үндсэн 3 төв банкны үндсэн хийх 3 ажлыг бол тодорхойлсон байгаа. Энэ нь цаашаа 15, 6 ажил болж хуваагдаад явж байгаа. Энэ стратеги, дунд хугацааны стратегийг хийх үндсэн ажлыг бол хийхээр бид нар төлөвлөж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ маань ингээд шинэ бүрэлдэхүүн, багтайгаа хамтраад энэ ажлыг бол цааш нь үргэлжлүүлээд явна.

Банкны эрүүл мэнд энэ талаар асууж байна. Та бүхэн мэдэж байгаа бас 2 банкны эрүүл мэндийн асуудал бас тийм таатай биш байгаа. Хамгийн сүүлийн байдлаар бол 19 байна уу, 20 онд хамгийн сүүлд шалгалт хийсэн. Тэрнээс хойш яг банкин дээрх иж бүрэн шалгалт хийгдээгүй. Яг одоогийн цаг хугацаанд бол шалгалт дахиад хийгдэж байгаа. Тэгэхээр энэ шалгалтын дүн гарахаар эргээд гишүүдэд албан байдлаар танилцуулъя. IBAN талаар бас асууж байна. IBAN-ыг 2020 оноос хойш ингээд хэрэгжүүлээд Монгол Улсын стандарт болгоод тэгээд төлбөр тооцоонд бол ашиглаад явж байгаа. Мэдээж нууцлал, аюулгүй байдлыг бол тухайн үед бол хангах зорилгоор бид нар энэ ажлыг эхлүүлээд явсан.

Иргэдийн хувьд бол тооны юу гэдэг юм цифрийн тоо ихэссэн гэдэг бас тийм асуултууд, асуудлууд гарч байгаа. Тэгэхдээ бид нар энийг банкны аппликэйшн дээр илүү хялбар байдлаар шийдэх, дээрээс нь иргэд өөрсдөө утасны дугаар, банкныхан данстай ингээд хамт уячих юм бол зөвхөн утасны дугаараараа, эсвэл и-мэйлээр хаягаар төлбөр тооцоо дансных нь мэдээллийг аваад төлбөр тооцоо хийх боломжийг бол ингээд цааш нь бүрдүүлээд явна.

Зээлийн мэдээллийн сантай холбоотой асуулт асуулаа. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг бол төв банкин дээрээс гэхээс илүүтэйгээр хувийн 2 байгууллагад бол ингээд тусгай зөвшөөрлийг өгөөд үйл ажиллагааг нь явуулж байгаа. Иргэдийн зээлийн мэдээлэл, зээлийн scoring хийх зорилгоор энэ байгууллагууд бол мэдээллүүдийг цуглуулаад явж байгаа.

Мэдээж хар жагсаалтад орсон, санхүүгийн хариуцлага гэх юм уу алдагдсан иргэдийн гомдол, санал бол мэдээж нэлээн их байдаг. Тэгэхдээ энэ бол яг хуулийн хугацаатай, хуулийн хугацааны дууссаны дараа цэвэрлэгддэг ийм зохицуулалттай байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ дээрээ бол бас Төв банкны зүгээс аль болох.../минут дуусав./

Б.Заяабал: Индрийн микрофон олгоё.

Э.Анар: Журам, заавар зүйлээ бол эргэж дахиж харж, дахиж боломж олгох байдлаар бол хийх боломжууд байна уу гэдэг дээр бол судалж үзье гэсэн бодолтой байна. Баярлалаа.

Б.Заяабал: Даваагийн Цогтбаатар гишүүн нэмэлт тодруулга.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын харьяа байгууллагуудад тавигдаж байгаа энэ томилгоонуудад Улсын Их Хурлаас тавьж байгаа энэ босго, цензур үнэхээр жоохон бас багасаад байна уу даа л гэж бодож байна. Тэгээд ер нь бол Заяабал гишүүнийг бас маш сайн зарчимтай гэж бодож байгаа. Гэхдээ эрхтэн дархтны өмнө бас битгий гудайгаасай л гэж бодож байна. Энэ и юу гэдэг юм Байнгын хорооны даргын асуудал ч биш инфляц гэдэг чинь Монгол Улсын асуудал. Төгрөгийн ханш чанга, сайн байх гэдэг нь бас Монгол Улсын нийт 3 сая 700 мянган иргэний асуудал. Тэгэхээр энэ дээрээ бид нар маш сайн зарчимтай хандахгүй бол ингээд дээрээс орж ирж байна даргын хүүхэд ингээд бид нар томилж явуулаад байвал иргэддээ хэлэх үг маань л цөөрөх байх шүү гэдгийг маш сайн бодоосой л гэж бодож байна.

Наранцогт даргад бас хандаж захиас л юм даа. 2 банк дампуураад явж байхад. Нэмэлт минут авч болох уу дарга аа?

Б.Заяабал: Тэгэхлээр Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтны хувьд нэр дэвшүүлэх асуудал байгаа. Тэгээд хуулиар бол Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг Төв банкны тухай хуулийн 26.2-т заасны дагуу нэр дэвшүүлэх бүрэн эрх нь Монголбанкны Ерөнхийлөгчид байгаа. Энэ зарчмаар Улсын Их Хуралд нэр дэвшүүлэх эрх бүхий субъект нь албан бичгээ ирүүлсэн.

Энэний дагуу Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу 5 хоногийн дотор сонсголоо зарлах, товоо тогтоох ийм дэгтэй. Энэ дэгийн дагуу тов тогтоогдоод ингээд хуулийнх дагуу ингээд Их Хурал хэлэлцээд явж байна. Ингээд Дэгийн тухай хуулийн хэд билээ? Энэ 30 хоногийн дотор бас Их Хурал 130.5-д заасны дагуу, Дэгийн тухай хуулийн 130.5-д заасны дагуу 30 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэх ийм дэгтэй. Энэ дэгийнхээ дагуу Улсын Их Хурал хэлэлцүүлгээ хийгээд явж байгаа гэсэн ийм хариултыг бас гишүүнд өгье.

Даваагийн Цогтбаатар гишүүний нэмэлт минутыг олгоё.

Да.Цогтбаатар: Асуухаа болилоо зүгээр захиас хэлчихье. Наранцогт даргыг бас томилогдоод явж байхад нь хэлж байсан үгээ давтъя. Тэгэхдээ арай шинэлэг байдлаар. Жишээлэхэд энэ 2 банк дампуурчихсан байж байхад газар дээрх хяналт шалгалт 20 оноос хойш хийгдээгүй 6 жил, та томилогдоод 6 сар болчихсон. Тийм. Тэгэхээр энэ дээрээ маш сайн анхааралтай ажиллахгүй бол бид нар хэн нэгэн даргын танил талын банк нь дампуурч өгдөггүй, бусад нь бол яах вэ дампуурчихдаг байдлаар яваад байгаа гэдгийг бас онцгой анхаараарай.

Манай нэр дэвшигч бол жоохон өөрөө санаачилгатай, зорилготой ажиллахгүй юм бол дүрэм журмыг би ч уншиж чадна. Хэн ч уншиж чадна. Иргэддээ яавал ийм үр ашиг, тусыг нь хүртээх вэ гэдэг талаас нь бодохгүй бол угаас бодлого, журам дээр ийм байгаа, хууль, дүрэм дээр ийм байгаа гээд мулайгаад хэвтээд байвал бүгдээрээ чадна шүү дээ. Тэгэхээр яавал иргэддээ 1 удаа энэ чинь СӨХ-ны мөнгө хүн цалин хугацаандаа тавигдаагүй байхад л 1 удаа хоцрох боломж гарч байгаа байхгүй гэх мэтчилэнгээр санаачилгатай ажиллахгүй та нар нөхцөл байдал нь ийм юм ингээд л хатуу дүрэм журам гээд суугаад байвал суугаад л байна.

Б.Заяабал: Цогтбаатар гишүүн үг хэллээ. Очирбат гишүүний микрофон олгоё.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ уул нь 80 хэдэн оны л залуу мерит зарчмаар явж байгаа л харагдаад байгаа юм. Гэхдээ яах вэ сүүлийн үед гаргасан бүх шийдвэр дээр бас та энэ Монголбанканд ажил хийж байсан байна л даа. Тэгээд Монголбанкны барьж байгаа бодлого бол өнөөдөр бодлогын хүүгээ чангалах. чангалдаг л ганц л ажилтай болсон. Тэр нь иргэд, аж ахуйн нэгжийн хосыг шувталж байгаа. Арилжааны банкнуудыг хөдөлгөөнд оруулж чадахгүй байгаад байгаа. Тэгээд энэ мөнгөний бодлогоо ер нь цаашдаа яаж барих ёстой юм? Тэр дээр нь ямар бодолтой явдаг хүн юм? Нэгт.

Хоёрт гэх юм бол Монголбанк баахан Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч гээд чиг үүргийн ажил, албан тушаал, чиг үүргийн давхцал асар ихтэй болчихсон. Тэгээд яг Тэргүүн дэд ерөнхийлөгч гэхээр яг юу хийх вэ? Таны энэ мөрийн хөтөлбөрийг чинь сайхан уншиж л байна л даа. Их л сайхан бараг л Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа юм шиг л юмнууд биччихсэн байна. Яг ажил албан тушаалын тодорхойлолтын дагуу үндсэн 5 чиг үүргээ та хэлээд өгчхөөрэй. Тэгээд тэр дээр чинь холбоотой тодруулж асууна.

Тэгээд цаашдаа энэ энэ инфляц чинь ингээд макро эдийн засгийн хувьд эдийн засаг өсөөд байна гээд байгаа боловч инфляц нь давхар өсөөд байдаг. Энэ чинь эдийн засаг өсөж байвал нөгөө талдаа инфляц чинь суларч байх ёстой биз дээ? Тэгэхгүй яг одоогийн манай энэ эдийн засгийн нөхцөл байдал юу болчихоод байгааг эдийн засагч нар өөрсдөө ч ойлгохгүй байна шүү дээ. Макро орчинд өсөөд байна. Тэгсэн мөртөө иргэд мөнгөгүй байгаад байна. Инфляц 2 оронтойдоо даваад гараад явчихсан. Цаашдаа яаж өсөх нь таамаглах бололцоогүй гэсэн ийм сонин нөхцөл байдалтай байгаад байдаг. Тэгэхээр энэ эдийн засгаа хэзээ яаж солонгоруулж, төрөлжүүлэх юм? Тэр дээр Монголбанкны бодлогыг ер нь яаж цаашдаа авч явах ёстой юм бэ? Нэг юм яриад л өчигдөр гэхэд л ганц сайхан бараг л бараг дэлхий дээр байхгүй гэрээ хийчихлээ гээд л орон даяар юм ярих юм. Үгүй ээ энэ хүүг л бууруулаа биз дээ? Менежментийн төлбөрийг нь л бууруулаа биз дээ. Тэгээд нэг их бүр дэлхий дээр байхгүй юм л хийчихсэн юм шиг л юм болох юм. Гайхаад байна. Тэгээд энэ Монголбанк энэ дээр бас юу гэж бодож байгаа

юм? Цаашдаа энэ эдийн засгаа яг энэ уул уурхайгаас хамааралтай байлгаад байгаа юм уу, байлгах юм уу? Байлгахгүй солонгоруулах юм уу? Солонгоруулах юм бол яг яаж солонгоруулах гээд байгаа юм? Та хэд энэ Шинэ хоршоо гээд л баахан зээл Монголбанкнаас өгсөн. Тэгээд үр дүн байхгүй. Ямар үр дүн гарч байгаа юм? Өшөө Монголбанкнаас тэр баахан хөтөлбөрүүд хөрөнгө оруулалт хийгээд л хүүг нь татаасыг нь өгөөд л явсан. Тэд нарын үр дүн гэж байхгүй zero. Тэгээд ийм 3 асуулт асууя. Тэгээд тайлбар, мэдээллээ сонсчихоод тодруулъя даа.

Б.Заяабал: Монголбанкны Ерөнхийлөгч болон нэр дэвшигч хоёулангаас нь гэсэн учраас Монголбанкны Ерөнхийлөгчийг индэрт урья. Индрийн микрофон олгоё.

С.Наранцогт: Очирбат гишүүний асуултад хариулъя. Таны ажиглаж байгаа энэ эдийн макро эдийн засгийн асуудлын хувьд бол санал нэг байгаа. Тэгэхээр ийм учраас бид нар бол бодлого, дунд хугацааны стратеги, дунд хугацаанд макро орчныг тогтвортой түвшинд аваачих ийм төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлж эхлээд ажиллаж байна. Тэгэхээр нэр дэвшигч өөрөө хариулах байх.

Дэд ерөнхийлөгчийн үүргийг бол Төв банкны Ерөнхийлөгчийн тушаалаар тодорхойлж өгдөг. Тэгэхээр би ажил аваад 19 газрыг 10 газар болгосон. Одоо манайх харьцангуй чиг үүрэг бол тодорхой болж байгаа. Ер нь зүгээр нэг хүн нэг Ерөнхийлөгчийг тусад нь ингээд тусдаа институц юм шиг тодорхой газрууд хариуцаад ажиллуулдаг байсан юм билээ. Би бол тэгж ажиллахгүй гэдгийг яг багийн зарчмаар ажиллах ёстой. Өнөөдөр бол Монголбанк шийдвэрийг яг багийн зарчмаар мэргэжлийн чадвартай залуучууд доод түвшиндээ хүртэл эхэлж хэлэлцүүлдэг ийм механизмуудыг бий болгож ингэж ажиллаж байна. Тийм учраас бол бас Дэд Ерөнхийлөгчид маань хийх тодорхой ажлуудтай энэ Монголбанкны үйл ажиллагааг сайжруулахад бол бас чухал хувь нэмэр оруулах ийм байдалтай бол ажиллах юм.

Макро нөхцөлийн хувьд бол бид яах ёстой вэ гэхээр таны түрүүний хэлсэн олон хөтөлбөр хэрэгжүүлээд манай эдийн засгийн өсөлтийг бид нар энэ бий болж байгаа өсөлтөө юу руу шингээх вэ гэдэг дэд бүтэц дээр л анхаарах ёстой. Яагаад инфляц өсөж байна вэ гэхээр энэ өнөө энэ он экспорт нэмэгдээд зах зээл дээр яах вэ экспортоор баталгаажсан эрүүл мэнд бий болохоор энийг хаашаа шингээж авах вэ гэдэг асуудал. Хөрөнгийн зах зээл ирээдүйд баялаг бий болгох тэр яг зөв төсөл, хөтөлбөрүүд, бусад энэ мөнгө санхүүгийн зах зээл, энэ дэд бүтцүүдээ хөгжүүлээгүй зүгээр Төв банк л аргаа ядаад өөрийнхөө үнэт цаасаар шингээж авдаг ганцхан ийм хэрэгсэлтэй. Бусад мөнгө нь яаж байна вэ гэхлээр манайх шиг ийм таны хэлж байгаа солонгороогүй эдийн засгийн үед хэрэглээ рүү орчхож байгаа юм.

Хэрэглээ рүү ороод ирэхээрээ инфляцыг хөөрөгдөөд, импортыг хөөрөгдөөд ийм байдлаар явж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бол Засгийн газар, Төв банк бол хамтарч бодлогын хувьд Төв банк бол мэдээж энэ солонгоруулах гардах ажилд орохгүй. Мөнгөний бодлогын хэрэгсэл болоод бусад макро зохистой бодлогын хэрэгслээр аль секторын яг тодорхой эдийн засгийн өсөлтийг ирээдүйн өсөлтийг бий болгох чиглэл рүү хөшүүрэгдэж өгөх энэ ажлыг хийх ёстой. Тэгэхээр энэ бодлогыг бол тодорхойлоод саналыг бол бас хүргүүлж ажиллаж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Б.Заяабал: Нэр дэвшигч индрийн микрофон дээр. Индрийн микрофон нээе.

Э.Анар: Оюу толгой Очирбат гишүүний асуултад хариулъя. Сая Монголбанкны Ерөнхийлөгч ерөнхийдөө эдийн засагтай холбоотой асуултуудыг нь л хариулчих шиг боллоо. Чиг үүргийн хувьд бол яг Ерөнхийлөгчийн саяын хэлсэнчлэн хуульд бол яг тухайн дэд ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч нь чиг үүргийг нь бол заагаагүй байдаг. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд Ерөнхийлөгч хэн ямар Ерөнхийлөгчид ямар чиг үүргийн ажлыг хариуцуулах вэ нь ерөнхийдөө ингээд чиглүүлээд явдаг.

Монголбанкны яг үндсэн чиг үүрэгт бол хуульд бол 8 үндсэн чиг үүргийн ажлыг бол хийхээр заасан байдаг. Энэ нь мэдээж мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, зохицуулах, мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн зуучлалын чиг үүргийг гүйцэтгэх, банк болон хуульд тусгайлсан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, үндэсний мөн төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гадаад валютын улсын нөөцийн эзэмших, удирдах, мөн банкны харилцагч, хадгаламжийн эзэмшигчдийн эрх, зүй ёс, эрх зүйн сонирхлыг хамгаалах, мөн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх гэсэн үндсэн 8 чиг үүргээр Төв банк үйл ажиллагааг хуульд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Баярлалаа.

Б.Заяабал: Очирбат гишүүний микрофон.

Г.Очирбат: Энэ ажил албан тушаалын, таны ажил албан тушаалын чиг үүргийг л асууж байгаа юм. Монголбанкны чиг үүргийг бол сайт руу нь ороод бүгдээрээ харчхаж байгаа шүү дээ. Тэгэхээр та ер нь Тэргүүн дэд ерөнхийлөгч болоод ажил, албан тушаалын чинь тодорхойлолт гараад тэр дээр чиг үүргүүд чинь маш тодорхой байх ёстой. Тэрийгээ л хэлэх ёстой байсан. Тэгээд тэрийгээ хэлэхгүй ингээд төөрөөд явчих юм.

Дахиад 2 асуулт асууя. Одоо Барилга, хот байгуулалтын яамнаас энэ орон сууцжуулалт юу билээ орон сууцжуулалтын банк билүү тийм шинэ банк байгуулна гээд яваад байгаа юм. Монголбанкны Ерөнхийлөгч, манай Тэргүүн дэд ерөнхийлөгч ингээд томилогдох байлгүй аягүй бол. Та 2 яг энэ Ерөнхийлөгч нарын хувьд юу гэж бодож байгаа юм? Цаашдаа ингээд төр өөрөө банк байгуулаад яваад байх нь зөв юм уу буруу юм уу? Одоогийн байгаа банкны тогтолцоо чинь зөв явж байгаа юм уу, буруу яваад байгаа юм уу? Буруу болоод та нар төр ингээд төрөлжсөн банк байгуулъя гэж оруулж ирж байгааг нь дэмжиж байгаа юм уу яаж байгаа юм? Энэ дээр хариулт авчихъя. Би 2 тодруулна тээ?

Б.Заяабал: Монголбанкны Ерөнхийлөгч. Индрийн микрофон нээе.

С.Наранцогт: Та Ипотекийн банк, төрөлжсөн банкныг асуулаа. Тэгэхээр манайх ипотека 140 гаруй зээлдэгчийг зөвхөн төрийн татаастай хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн нь өөрөө өнөөдөр 47 мянган хэрэглэгчийг үүсгээд, хэрэгцээг бий болгоод. Тэгэхээр бид нар энэ олон төрлийн бүтээгдэхүүн гаргах, зах зээлийн зарчмаар явах, зөвхөн төрөөс, тэр тусмаа Монголбанкнаас ингэж санхүүжүүлдэг хөтөлбөрийг зогсооно гэдэг агуулгаар энэ банкныг бол дэмжиж байгаа. Харин зүгээр төрийн эзэмшлийн хувьд бол бид нар санал өгч, төрийн эзэмшил давамгайл байвал энэ засаглалын хувьд асуудал үүснэ ээ гэдэг ийм зарчмын байр суурьтай байгаа.

Б.Заяабал: Нэр дэвшигч нэмж хариулах уу? Саяын юун дээр. Очирбат гишүүний нэмэлт тодруулга.

Г.Очирбат: Ингээд маш буруу бодлогоор явж байгаа шүү. Одоо та хэд орон сууцжуулалтын банк барина. Дараа нь аягүй бол тусдаа Хүнс, хөдөө аж ахуйн банк барина. Дараа нь аж үйлдвэрийг дэмжих банк барина. Дараа нь магадгүй зам, тээвэр, дэд бүтцийг дэмжих банк барина. Ингээд төр өөрөө энэ банкнуудыг бүгдийг нь авах гээд байгаа шүү. Та нар сүүлийн 30 жилийн энэ хугацаанд санхүүгийн тогтолцоог арай чүү нэг юм ингээд хөл дээр нь босгох гээд зөв, буруутай, алдаатай, оноотой явж байгаа юмыг төр өөрөө унагаах гэж байгаа. Энийг нь Монголбанкны Ерөнхийлөгч нь өөрөө дэмжээд байж байна шүү дээ. Ийм байдалтай байж болохгүй шүү цаашдаа. Мэдээж яах вэ та нар Монгол Ардын намынхан олонхоороо эрх барьж байна. Түрээд та нар ингээд хүнээ томилуулаад ажлаа хийгээд явах байх. Тэгэхдээ энэ гаргаж байгаа буруу шийдвэрийн чинь үр дүн иргэд нуруун дээрээ ачаа болгож авна шүү. Татвар төлөгч нар, аж ахуйн нэгжүүдэд авна шүү. Арилжааны банкнуудаа та нар удахгүй татан буулгана. Бүх энэ санхүүгийн систем устах гэж байгаа шүү. Тэгэхээр Монголбанк наад бодлогоо сайн хараарай.

Б.Заяабал: Очирбат гишүүн үг хэллээ. Мандхай гишүүний микрофон олгоё.

М.Мандхай: Ер нь Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаал өөрөө нэгдүгээрт энэ байгууллагын удирдах тушаал гэхээсээ илүүтэй. Би үг хэлчихье тэгэх үү чимээгүй байж бай л даа. Макро эдийн засгийн тогтвортой байдал, энэ банк санхүүгийн системийн найдвартай ажиллагаанаас гадна иргэд, бизнесийн энэ санхүүгийн итгэлцлийг бол хангах ийм өндөр хариуцлагатай албан тушаал. Тэгээд энэ албан тушаалд аль нэг Ерөнхийлөгч томилогдоод бүх мэргэжлийн салбартаа, банкандаа хүлээн зөвшөөрөгдчихсөн меритийн зарчмаар өсөж, хөгжиж байгаа хүмүүсийг ташраар нь өөрчилж сольдог. Ингээд нөгөө институцийн ой санамж, чадавх гэдэг юм өөрөө алдагддаг. Энэ тэнцвэргүй байдлыг бий болгохын эсрэг, эсрэгээрээ салбартаа доороос нь эхлээд мерит зарчмаар өсөж дэвшиж явж байгаа, хамгийн багадаа энэ чинь 15 жил ажилласан туршлагатай, салбарынхаа газар, нэгжүүд дээр бас ажилласан ийм ой санамжтай ийм хүнийг Тэргүүн дэдээр дэвшүүлж оруулах нь зүйтэй гэж би бол харж байгаа юм.

Тэгэхлээр хэрэгжээд байгаа өнгөрсөн хугацааны алдаа, оноо, цаашид хөгжүүлэх шаардлагатай ажлууд дээр туршлагатай ийм хүн томилогдох нь өөрөө маш зүйтэй юм. Тэрнээс биш гадаадад сургууль соёл төгссөн, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байсан ийм хүмүүсийг шууд ингээд салбарын ямар ч туршлагагүй, дотоодынхоо зах зээлийг мэддэггүй ийм хүмүүсийг ингээд Тэргүүн дэдээр томилоод явах юм бол дахиад нөгөө салбарын чинь ой санамж байхгүй, түүх алдагдсан, нөгөө хараат бус байдалд чинь нөлөөлөх ийм эрсдэлтэй юм аа.

Тийм учраас энэ 15 жил болсон туршлагатай, мерит зарчмаар явж байгаа, ой санамжтай, салбартаа болон энэ банкныхаа ажилтныхаа дунд хүлээн зөвшөөрөгдсөн ийм чадвартай хүнийг бол томилох нь зүйтэй гэж харж байгаа.

Ингээд би энэтэй холбоотой Тэргүүн дэд болж байгаа учраас би нэг зүйлийг асууя. Та туршлагатай хүн учраас одоо энэ салбар дотор чинь маш олон солилцоо, холилцоо явагдаж байгаа. Тэгээд ингээд салбарын бус, салбартаа ажиллаж байгаагүй энд тэндээс орж ирсэн нөхдийг ингээд дарга цэргээр

солигдоод байгаа асуудлуудыг та ер нь ямар арга хэмжээ авч ажиллана гэж бодож байгаа юм бэ? Ер нь энэ салбартаа удаан тогтвортой ажиллаж байгаа мэргэжлийн энэ хүмүүс чинь үргэж дүрвээд дууслаа гэдэг ийм гомдлууд маш олон ирж байна. Тэгээд энэтэй холбоотойгоор таны хувьд ямар арга хэмжээ, яг өөрийнхөө хараат бус байдлаар өөрийнхөө туршлага дээр үндэслээд авч хэрэгжүүлэх вэ гэдгийг би тодруулж асууя.

Хоёрдугаарт энэ арилжааны банкнуудын энэ олон салбар руу орж ажилладаг. Жишээлбэл, даатгалын салбарт ажиллаж байгаа ийм банкны.../минут дуусав./

Б.Заяабал: Мандхай гишүүний микрофон нээе. 1 минут.

М.Мандхай: Арилжааны банкны гол хувьцаа эзэмшигч, эцсийн эзэмшигч өөрөө даатгалын салбарт орж, хөрөнгө оруулалт хийгээд ингээд даатгалын бизнесийг хийгээд явдаг. Гэтэл энэ 2 салбар чинь олон улсын жишгээр хоёулаа тусдаа байх салбар. Тэгэхээр энэ дээр энэ санхүүгийн энэ тогтвортой байдлыг хангах, хянан шалгах энэ ажлын хүрээнд та энэ даатгалын салбарыг ер нь энэ эрсдэл байгаа гэж харж байгаа юу? Энэ дээр ямар зохицуулалт хийж, тусдаа хөгжих энэ салбар болгоход яаж Монголбанк, Төв банкны зүгээс анхаарч ажиллая гэж бодож байгаа вэ гэдэг хоёр асуултыг асууя.

Б.Заяабал: Нэр дэвшигч индрийн микрофон дээр очъё. Индрийн микрофоныг нээе.

Э.Анар: Мандхай гишүүний асуултад хариулъя. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилогдсон тохиолдолд хүний нөөцтэй холбоотой асуудлаар та ямар байр суурь, бодлого баримтлах вэ гэж асууж байна. Тэгэхээр зэрэг мэдээж миний өчигдрийн ч гэсэн сонсголын үеэр ч бас дурдсан Монголбанкны хамгийн чухал үнэт зүйл нь юу вэ гэхээр зэрэг хүний нөөц дээрээ, боловсрол эзэмшсэн залуучууд, энэ туршлагатай энэ ажилтан, албан хаагчидтай байдаг учраас бид нар хүний нөөц дээрээ бол анхаарч, ялангуяа энэ мерит зарчмаар газар, мэргэжилтэн, ахлах, газар, хэлтсийн захирлуудыг бол ерөнхийдөө ингээд мэдээж шаардлага хангасан энэ ажилтнуудыг бол үргэлжлүүлэн ажиллуулж, хамтарч ажиллах тал дээр бол зорилт тавьж ажиллана.

Хоёрдугаар асуултын хувьд бол банкны салбартай хамтарч, хамт энэ олон төрлийн бизнес хийгддэг гэдэг энэ асуултыг хөндөж байна. Мэдээж даатгалын салбар, банкны салбар бол санхүүгийн тогтвортой байдлын гол хоёр салбаруудын нэг. Монгол Улсад бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэж зөвлөл бий. Энэ зөвлөл дотор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорац бол ингэж шийдвэрээ гаргаж явдаг. Тэгэхээр санхүүгийн салбар дээр болж байгаа асуудлуудыг энэ хороогоороо бид нар шийддэг. Тэгэхээр яг даатгалын салбарын хувьд болохоор зэрэг Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа явуулдаг. Төв, банк яг даатгал хоёр бол яг нэг доороо биш зүгээр зэргэлдээ гэх юм уу ингээд холдинг компани дотроо ингэж байхад бол хууль, эрх зүй, өнөөдрийн Монгол улсад хэрэгжиж байгаа хууль хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн хувьд бол боломжтой байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ хоёр салбар бол мэдээж бие биедээ харилцан дэмжлэг үзүүлж бие биеийгээ ингэж дэмжиж явдаг ийм салбар. Тэгэхээр энэ салбарын зохицуулалтыг бол яг ингээд одоогийн байдлаар бол энэ тусдаа байх нь зөв. Тэгэхдээ ер нь бол нэг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ

бол ингээд энэ асуудлууд нь шийдэгдээд тухайн хяналт шалгалт, үйл ажиллагаанд нь тавигдах хяналтууд нь бол тавигдаад явна аа гэсэн бодолтой байна. Баярлалаа.

Б.Заяабал: Мандхай гишүүний тодруулга.

М.Мандхай: Тэгэхээр би дахиад юм тодруулъя. Энэ даатгалын компанийг мэдээж Санхүүгийн зохицуулах хороо зохицуулдаг, зохицуулах ёстой. Гэхдээ даатгалын энэ ялангуяа нөхөн төлбөрийг, нөхөн олговрыг, орж ирж байгаа мөнгийг банк өөрөө тодорхой эрсдэлтэй үедээ эргээд нөгөө зарцуулах ийм эрсдэл байгаад байгаа. Тэгэхээр хамаарал бүхий этгээдийн компаниуд руугаа олж ирсэн орлогоо дунд нь шилжүүлэх ийм эрсдэлүүд бол гардаг.

Тэгэхлээр тийм учраас арилжааны банкнууд төлбөр төлөх чадвар, тэгээд энэ нь өөрийн нөгөө санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Монголбанк, Төв банкнаас тавьж байгаа шаардлага, Олон улсын валютын сангаас тавьж байгаа шаардлага хангах үүднээс үүсэж байгаа энэ эрсдэлүүдийг хаах үүднээс энэ даатгалын салбар өөрөө тусдаа байх ёстой учраас арилжааны банк өөрөө даатгалын компанийг, хувьцааг, арилжааны банкны хувьцаа эзэмшигч, даатгалын компанийн хувьцааг эзэмших, хөрөнгө оруулахад.../минут дуусав./

Б.Заяабал: Нэр дэвшигч. Анар нэр дэвшигч индрийн микрофон дээр. Индрийн микрофоныг нээе.

Э.Анар: Мандхай гишүүн тодруулж асууж байна. Мэдээж даатгалын компанийн хувьд, үйл ажиллагааны хувьд бол арай өөр. Яг тавьж байгаа хоёр, Төв банкнаас тавьж байгаа, банканд тавьж байгаа шаардлага Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компанид тавьж байгаа шаардлагууд, хяналт, зохицуулалтууд бол ерөнхийдөө бол хяналт, тус тусынхаараа бол ингээд явагддаг гэж бодож байна.

Ер нь хувьцаа эзэмшлийн хувьд бол мэдээж яг хувьцаа эзэмшигчийг яг энэ компани яг энэ салбарт хувьцаа эзэмшиж болно, болохгүй гэдгийг бол бас яг шууд хэлэхэд бас жоохон хүндрэлтэй. Тэгэхдээ даатгалын салбар дээр бид нар яг тийм зохицуулалт бол байхгүй байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр ер нь бид нар бас сайн судалгаа хийж эргэж харах ёстой болов уу гэж бодож байна.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Тэгээд дараа нь саналын томъёоллыг уншъя.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд.

75 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хоёр дахь асуудал руугаа оръё. Болоогүй юм уу. Болоогүй юм байна.

Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай, Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 8 дахь хэсгийн Монгол Улсын Их Хурлын чуулганы 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Энхболдын Анарыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл гишүүн танилцуулах уу? Маргааш уу, өнөөдөр үү? Батсүмбэрэл гишүүн уншиж танилцуулна.

12.16 цаг.

Хоёр дахь асуудал руугаа оръё. Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан боловсруулсан “Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгөхийг хүсье. Ундраа гишүүнээр тасаллаа.

Энд гишүүдэд мэдээллийн чанартай бас мэдээлэл өгөхөд уг тогтоолын төслийг өмнөх Байнгын хорооны хурал дээр бид нар хэлэлцүүлж хойшлуулах ийм гишүүд хүсэлт гаргаж дэмжигдсэн. Ингээд өнгөрсөн нэг дэх өдрийн 12 цагт Эрчим хүчний яамны сайдыг байлцуулан Байнгын хорооны гишүүдэд нээлттэй мэдээлэл өгсөн. Зарим манай Байнгын хорооны гишүү д бас бичгээр саналаа ирүүлсэн байгаа. Ингээд гишүүд бүгдээрээ хуралд өнгөрсөн нэг дэх өдрийн 12 цагт хуралдаж энэ тогтоолын төслийг боловсруулсан гэсэн ийм мэдээллийг бас өгье.

Ингээд ирцийн дагуу Соронзонболд гишүүнээс эхэлье. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Энэ 4 дүгээр асуудал дээр байгаа энэ эрчим хүчний салбарт үүссэн, хуримтлагдсан өр авлагыг бууруулах гээд. Тэгээд гол нь дамжуулан зээлж ингээд цахилгаан станцууд дандаа гадаад валютын зээлтэй байгаад байгаа. Тэгээд тэр гадаад валютын зээл нь бол ханш өссөнөөс болоод байнгын алдагдалтай, эрчим хүчний өртөг өсөхөд чинь энэ гадаад валютаас болоод, ханшийн өсөлтөөс болоод үүсэж байгаа алдагдал нь хэд

юм бэ гэдэг асуултыг бол Эрчим хүчний зохицуулах хорооноос асуумаар байгаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл, өнөөдрийн манай эрчим хүчний станцуудын үйлдвэрлэж байгаа өртгийн хэдэн хувьд нь энэ гадаад валютаар авсан зээлийн ханшийн өсөлтөөс болж үүсэж байгаа алдагдал үүсээд байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байгаа юм. Тийм учраас энэ 4 дүгээр заалт бол маш чухал заалт байна гэж харж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийг бас танилцуулъя. Өнөөдрийн бас манай манай Байнгын хорооноос гаргаж байгаа тогтоол дээр дэмжин туслах зорилгоор Энхтүвшин Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга хүрэлцэн ирсэн байгаа. Эрдэнэбулган эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга хүрэлцэн ирсэн байгаа. Гишүүний асуултад ажлын хэсгийн, дэд ажлын хэсгийн гишүүн Эрдэнэбулган. Индрийн микрофон дээр хариулт өгөх үү? Индрийн микрофон.

Б.Эрдэнэбулган: Эрчим хүчний зохицуулах хороо Эрдэнэбулган Асуултад хариулъя. Эрчим хүчний салбарт төрийн өмчит компаниуд нийтдээ 2 их наяд төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй байгаа 12 сарын 31-ний байдлаар. Эдгээрээс 800 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл нь 2010 оноос хойш авсан, валютаар авсан зээлийн үлдэгдлүүд байгаа. Эдгээрийн ханшны зөрүү бол үлдэгдлээрээ тооцох юм бол 100 орчим тэрбум, жилд төлөх үндсэн болон хүүгийн төлбөрийн зөрүү нь бол 11 орчим тэрбум төгрөгийн ханшны зөрүүгийн алдагдал жилийн эрчим хүчний өртөг дээр нөлөөлж байгаа гэсэн үг. 11 тэрбум.

Б.Заяабал: Баярлалаа. Ундраа гишүүн.

А.Ундраа: Энэ тогтоолын төслийн 1 дүгээр заалт дээр эрчим хүчний салбарын эрх зүйн орчин, санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, цаашлаад тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх гэж байгаа юм л даа. Тэгэхээр бид бол яах вэ энэ санхүү, эдийн засгийн асуудлыг, бас техникийн асуудлыг бол энэ дээр тодорхой хэмжээнд авч үзсэн, зөв зүйтэй авч үзсэн байна. Гэхдээ энэ бүх ажил маань мэдээж хүндээр тогтдог. Бид хүнээ бодох ёстой байгаа юм. Тэгээд эрчим хүчний салбарын ялангуяа өвлийн ид ачааллын үеэр дулааны эх үүсвэрээр хангах, цахилгааны найдвартай тасралтгүй эх үүсвэрээр хангах чиглэлээр манай эрчим хүчний салбарын инженер, техникийн ажилтнууд, бусад ажилтнууд бол маш их ачаалалтай ажилладаг.

Тэгээд энэ зарим үед бол бараг ослын горимоор ажиллаж байж энэ эрчим хүчний найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг бол өвлийн эд ачааллын үеэр авч гарч байгаа. Тэгэхээрээ эрчим хүчний олон байгууллагуудаар явж уулзалт хийж, фокус бүлгийн ярилцлага хийж, 1000 гаруйг эрчим хүчний салбарын ажиллагсадтай ингэж уулзалт зохион байгуулсан өнгөрсөн 1, 2 жилийн хугацаанд. Тэгэхээр энэ судалгааны дүнгүүдээс харж байхад бол эрчим хүчний салбарын ажиллагсдын дунд нэгдүгээрт цалин, орлоготой холбоотой.

Хоёрдугаарт тэр ажлын хэт их ачаалалтай уялдаатайгаар тийм хагас цэрэгжсэн байдалтай ч гэж хэлдэг шүү дээ. Энэ маш ийм онцгой нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд сэтгэл зүйн хувьд бол бас нэлээд их дарамттай нөхцөл байдал үүссэн байгаа. Тэгэхээр бид нар нөгөө хүнээ бодох, хүмүүстээ хандсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ялангуяа өвлийн ид ачааллын дараа амрах, сэтгэл зүйн

хувьд тайвшрах боломж бололцоо олгох нэн шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ байгууллагууд Эрчим хүчний зохицуулах хорооны зүгээс юм уу, эсвэл Эрчим хүчний яаман дээр хүний нөөцийн асуудал дээр энэ сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг Англиар “burnout” гэж хэлдэг шүү дээ. Эндээс урьдчилан сэргийлэх асуудал дээр энэ тогтоолын төсөл дээр ямар нэгэн юм тусгагдаагүй харагдаад байна. Тэгэхээр энэ дээр ямар ажлууд хийгдэж байгаа вэ? Ямар ажил хийх шаардлагатай гэж та бүхэн үзэж үзэж байгаа вэ? Нэг бүрчлэн ингээд тогтоол дээр задалж оруулахад хэцүү байх л даа.

Тэгэхээр тэр болзошгүй эрсдэл гэдэг дотор бол би энэ хүний хүчин зүйлтэй холбоотой зүйлс бас байна гэж харж байгаа. Тэгэхээр эндээс болж маш олон ажиллагсад, ялангуяа залуу инженер, техникийн ажилчид, ажиллагсад ажлаа орхиж хувийн сектор руу эсвэл гадаад улс орон руу явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ салбар маань хүндээрээ тогтох учраас тэр хүнээ хайрлах, хамгаалах, дэмжих чиглэлээр яг ямар бодлого энэ дээр тусгах нь зүйтэй гэж харж байна? Тэрийг нь бас төсөв, хөрөнгөтэйгөө уялдуулах ёстой байх аа. Ийм асуулт байна.

Б.Заяабал: Хүний нөөцийн бодлогын асуудал. Манай дэмжих чиг үүрэгтэй ажлын хэсгийн гишүүд индрийн микрофон дээр оччихъё. Индрийн микрофоныг нээе.

Г.Энхтүвшин: Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны зүгээс бол эрчим хүчний салбарт ажиллаж байгаа нийт 17800 ажилчны сургах, давтан сургах, мэргэшүүлэх, дээрээс нь бас энэ өндөр ачаалалд ажиллаж байгаатай холбогдуулаад бас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бол хүний нөөцийн бодлогын баримт бичгийг бол боловсруулж байгаа. Ойрын хугацаанд бол баталж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Бодлогын баримт бичгийн хүрээнд бол бас эдгээр арга хэмжээг бид бас олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд бас тодорхой арга хэмжээнүүдийг бол авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа. Хариулж дууслаа.

Б.Заяабал: Ундраа гишүүн тодруулна.

А.Ундраа: Судалгаанаас анзаарагдсан зүйл ер нь ажлын байрны хэт их ачаалалтай улбаатайгаар сэтгэл зүйн хувьд хямрах, “burnout” гэж хэлдэг тэр бол мэдээж амралт хэрэгтэй. Тэгэхдээ амрах боломжоор хангая гэхээр хүний нөөцийн дутагдалтай байгаа учраас энэ чинь нөгөө манайхан ээлжид гараад тулаа хийнэ гэж хэлдэг эдгээр асуудлууд дээр бид нар бас онцгой анхаарал хандуулж, бүүр хямраад болохгүй байгаа бол тэн дээр нь мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөө, тусламж үзүүлэх хэрэгтэй юм байна лээ.

Хоёрдугаарт бол нөгөө ажлын байран дээр янз бүрийн албан тушаалтай холбоотой ч юм уу, эсвэл ажлын байрны бэлгийн дарамтын юм бас нэлээд өндөр байна гэж харагдсан. Тэгэхээр энэ ombudsman-ий системийг нэвтрүүлж, дарга, удирдлагаас үл хамаарсан байдлаар өөрт байгаа тулгамдаж байгаа асуудлаа ажиллагсад илэрхийлэх тийм орчин үеийн шинэлэг хандлагуудыг тусгаж ажиллах нь зүйтэй гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр бас тусгаж ажиллаарай гэж хүсмээр байна.

Б.Заяабал: Ундраа гишүүн санал хэллээ. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ эрчим хүчтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолыг дэмжиж байгаа юм. Ер нь энэ эрчим хүчний салбар өөрөө их хүнд байдалтай байгаад байгаа талаар мэдээллүүд их явж байгаа. Зарим нэг дунд нь ажилладаг хүмүүс холбогдож байна лээ. Хөөрхий эрчим хүчний салбарынхан өдөр шөнөгүй ажилладаг, хүнд хэцүү ажилладаг, сэтгэл санааны хувьд ч бас барагтайхан байдаг гэдгийг сая салбарынх нь Ундраа гишүүн хэллээ. Тэгээд Ерөнхий сайд энэ салбараа их сайн анхаармаар байгаа юм. Нөгөө хөөрхий Чойжилсүрэн сайд байхдаа хүнд загнуулаад л ингээд сууж байдаг байсан. Одоо байгаа сайд нь хэн ч билээ дээ алга болчихсон Найдалсүрэн сайд нь байхгүй байх шиг байна тийм ээ. Чойжилсүрэн сайд ч уг нь их сууж байдаг байсан. Энэ ХҮН гэж намын авсан салбар ерөөсөө дандаа нүх болж байна. Боловсролын салбар нүх болсон. 2, 3 жилээр боловсролын салбар тэр чигээрээ унасан. Багш нарын нийгмийн асуудал, цалингийн асуудал мухардалд орсон. Нөгөө Ардын намын сайд очиж байж боловсролын салбараа нэг юм аварлаа. Одоо тэр өвчтөний орон дээр байгаа юм шиг байна лээ. Одоо тэгээд боловсролын салбар гайгүй болох байлгүй гэж бодож байна. Зүв зүгээр явж байсан эрүүл мэндийн салбар одоо нүх болж байна. Энэ салбарыг бас энэ Эдийн засгийн байнгын хороо харьяалах салбарынхаа хүрээнд анхаарах хэрэгтэй. Онцгой анхаарах хэрэгтэй. Ерөнхий сайд ч анхаарах хэрэгтэй. Энэ тэгээд ХҮН намын нөхөд хоёр, гурван юм хэлмээр байгаа юм. Тэр салбарын хүмүүсийг дуудаад намдаа элс барь гэж шахдаг юм гэж байгаа. Энийгээ зогсоох ёстой нэгдүгээрт.

Хоёрдугаарт элдэв янзын томилгоо хийж улс төржүүлдэг гэж байгаа. Энийгээ зогсоох ёстой. Энэ чинь мэргэжлийн салбар шүү дээ. Дээрээс нь тэр элдэв янзын тендер наймаа ярьж явдаг гэж байгаа. Намаа санхүүжүүлдэг юм уу юугаа санхүүжүүлдэг юм бүү мэд. Энэ байдлууд дээр ер нь анхаарах хэрэгтэй.

Ер нь энэ эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол дээр заалт оруулдаг юм уу, эс үгүй бол шинэ тогтоол гаргадаг юм уу. Энэ салбарыг Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж, Заяабал даргаа би, миний үгийг хэлээдэхье. Байнгын хяналтдаа анхааралдаа авч байхгүй бол болохгүй шүү. Намар хэдүүлээ лаа бариад сууж байх вий. Боловсролын салбар 2, 3 жилээр ухарсан шиг нөгөө ХҮН намдаа өгчихсөн салбар маань хар нүх болчих вий. Би энийг маш эртхэн хэлье. Эртхэн хэлье. Энийг тогтоолын хувьд дэмжиж байгаа. Тэгээд улс төржүүлж, намд элсүүлэхийг шаарддаг ийм байдалтай тэр байдлыг бол анхаарах ёстой шүү. Анхаарах ёстой юм байгаа. Маш их халаа, сэлгээ явж байна гэж байгаа. Маш их улс төржсөн үйлдэл явж байна гэж байгаа. Тэгээд тэр Чойжилсүрэн сайд хурал дээр суудаг шиг Найдалсүрэн сайд энэ хуралд ирж суумаар байгаа юм.

Б.Заяабал: Яг одоо бас Засгийн газрын хурал хуралдаж байгаатай холбоотойгоор манай Байнгын хорооноос боловсруулж байгаа энэ тогтоол дэмжих чиг үүрэгтэй ажлын хэсэг бас хүрэлцэн ирж ажиллаж байгаа гэдгийгээ бас хэлье. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий орж ирж байна. Хүрэлцэн ирсэн байна. Нөгөө хоёр нь хэн билээ? Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн. Эрчим хүчний яамны Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлын газрын дарга Цэрэнжамц гэсэн дарга нар бас хүрэлцэн ирсэн байна гэдгийг танилцуулъя.

Цэнгүүн гишүүний.

С.Цэнгүүн: Энэ эрчим хүчний салбарын, би юугаа ярьчих уу? Энэ Улсын Их Хурлын тогтоолыг бол дэмжиж байгаа. Эрчим хүчний салбарт хэрэгжих арга хэмжээний жагсаалтыг ерөнхийдөө бол гаргаж байгаа. Тэгээд энэ дээр болохоороо ер нь энэ Эрчим хүчний хуулийн шинэчилсэн найруулга дээр 2 жил ажиллаад тэгээд үндсэндээ бол өмнөх сайд нь, хуучин сайд нь ерөөсөө саналуудаа өгөхгүй, санал дээрээ ерөөсөө нэгдэж чадахгүй байсан болохоор энэ хуулийн шинэчлэлийн хамгийн гол чухал ажил нь өөрөө зогсонги байдалд бол шилжчихсэн байдаг. Энхцэцэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ч гэсэн тодорхой үр дүнд хүрч чадахгүйгээр ингээд гацаанд орсон. Тэгээд Найдалаа сайд очоод ер нь бол энэ эрчим хүчний эрх зүйн байдлын тухай асуудлыг энийг цэгцэлье ээ гээд явж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр тэр цэгцлэх ажилд нь энэхүү тогтоол гарснаар бол нэлээн шахалт болж өгөх ёстой гэж бол миний хувьд бол хараад байгаа юм л даа. Дан ялангуяа Эрчим хүчний зохицуулах хорооны бие даасан байдлыг бид нар хангахгүй бол өнөөдөр бид нар чинь өрсөлдөөнт аукцион зарлаад нээлттэй сонгон шалгаруулалтаар хувийн хэвшил бол өрсөлдөх боломж нь ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр энэхүү зохицуулалтуудыг хангадаг байхад Эрчим хүчний зохицуулах хорооны бие даасан байдал маш чухал байгаа юм.

Тэгэхээр энэ тогтоол дээр үндсэндээ бол бичээд ороод ирсэн байгаа нь маш зөв байгаа юм. Гэхдээ байнгын хороон дээр гарах санал маань болохоороо тодорхой хугацаа заагаад өгчихмөөр санагдаж байна. 2026 оны намар гэхэд энэхүү төслөө оруулж ир ээ гэдэг байдлаар байхгүй бол бас ахиад л ингээд 2 жил алдчихсан байж байх вий дээ гэдэг ийм саналтай байгаа. Тэгэхээр энэхүү тогтоолынхоо хэрэгжилт дээр бид нар хугацаа зааж өгөх шаардлагатай юм болов уу гэж бол харж байна.

Б.Заяабал: Асуулт биш санал хэллээ тээ. Өнөөдөр энэ энэ эрчим хүчинтэй холбоотой энэ Байнгын хорооноос боловсруулж байгаа төсөл, Их Хурлын тогтоол бол манай Байнгын хорооноос гарч байгаа учраас Байнгын хорооны гишүүд маань одоо бас саналаа гаргаад явах эрх нь нээлттэй байгаа. Тэгэхлээр Цэнгүүн гишүүн саяын зарчмын зөрүүтэй санал дээрээ албан ёсоор томъёолоод бас та өөрчлөлт байвал өгөөрэй. Таныг санал хэллээ гэж ойлголоо.

Эрдэнэбат гишүүний микрофон олгоё. Эрдэнэбат гишүүн байхгүй байна. Анар гишүүн.

Ч.Анар: Өдрийн мэнд ээ. Энэ Эрчим хүчний яамнаас асуухад энэ өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжих энэ хуулийн төслийг Энхцэцэг гишүүн ахлаад хийж байсан. Тэрэнтэй хамтарсан ажлын хэсгээрээ хуулийн төсөл оруулж ирэх үү нэгдүгээрт?

Хоёрдугаарт 26 оны 4 сард оруулж ирэхэд үнэ, тарифыг нэмэх гэж байна. Салбарт хуримтлагдсан өр төлбөрийг төгрөгт шилжүүлж тооцох гэж байна. Энэ бол аягүй том тооцооллууд байдаг. Амжих уу? Та нар бэлтгэл ажил хангасан байгаа юу? Нөгөө талаасаа Байнгын хорооны даргаас асуух гээд байгаа зүйл нь яг сая Цэнгүүн гишүүнтэй саналтай адилхан байна л даа. Их Хурлын тогтоол маань шинэ дэгийн тухай хуулиар дандаа Ки Пи Ай-тай хавсралттай болсон. Энэ дээр Ки Пи Ай-д яг хугацаа заасан, үр дүн заасан хавсралтыг нь бид нар бас үзэж байж баталмаар байна. Хавсралт боловсрогдож байгаа юу? Ажлын хэсгээс асууя. Тэгэхгүй бол Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын Их Хурлын тавьсан тогтоолын хэрэгжилт ерөөсөө маш бага хувьтай, биелүүлдэггүй, заасан хугацаанд

хариуцсан үүргийг биелүүлдэггүй асуудлууд байгаад байгаа. Тэгэхээр Эрчим хүчний яам ажлын хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны даргаас 3 асуулт асуулаа.

Б.Заяабал: Эрчим хүчний яамнаас асуултад хариулъя. Индрийн микрофон дээр очъё Эрчим хүчний яам. Өөрийгөө танилцуулаад асуултад хариулъя.

Б.Ерэн-Өлзий: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий. Анар гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбарыг өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зах зээлийн загварыг хууль, эрх зүйн хүрээнд шинэчлэл тогтоох ажил байгаа юм. Энэ дээр бол яг гол зах зээлийн загвар нь юун дээр гарч ирж байгаа бол гэхээр цахилгаан эрчим хүчин дээр гарч ирдэг. Энхцэцэг гишүүнээр ахалсан ажлын хэсэгт бол яам дэмжлэг үзүүлээд ингээд хамтраад өнгөрсөн хугацаанд явсан. Энхцэцэг гишүүний зүгээс Дулаан хангамжийн хуулийг. Одоогийн Эрчим хүчний хуулийг ер нь бол цахилгаан, дулааны гээд 2 хууль байх юм байна.

Тэгээд дулаан хангамжийн хуулийн төслийг нь бол боловсруулаад бас Засгийн газарт танилцуулаад ингээд процесс явж байгаа Энхцэцэг гишүүний зүгээс. Цахилгаан хангамжтай холбоотой хууль нь бол цэвэр яг зах зээлийн загвар, өрсөлдөөн үүсэхтэй холбоотой асуудал байгаа юм. Энэ дээр бол бид нар энэ хуулийн өөрчлөлтөө цахилгааны хууль гэдэг, одоогийн Эрчим хүчний хуулиа Цахилгаан эрчим хүчний хууль гэж нэмэлт томъёолох маягаар бас ингээд ажлын хэсгийг гаргаад ажиллаж байгаа. Энхцэцэг гишүүнээр ахалсан ажлын хэсэг, Энхцэцэг гишүүний ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нь байсан улсууд бас бид нартай яг ингээд хамтраад ажиллаж байгаа. Энэ тогтоолын шалгуур үзүүлэлт дээр бид нар бол тодорхой хэмжээний шалгуур үзүүлэлтүүд бол ингээд ажлын хэсэгт саналаа ингээд өгөөд явна.

Гол энэ эрчим хүчний салбарт үүссэн хуримтлагдсан өр авлагыг бууруулах асуудал нь бодит нөхцөл байдал дээр юу болоод байна вэ гэхээр тухайлбал Тайшир, Дөргөний усан цахилгаа, станцууд 2010 орчим онд баригдсан ийм станцууд байдаг. Тэгээд энэ станцуудын тариф тогтоож байгаа байдал нь бол зээлийн эргэн төлөлтөө хангах бол ямар ч боломжгүй, өөрсдийн борлуулалтын орлогоор зээлийн эргэн төлөлтөө хангах боломжгүй. Тэгээд зээлээ төлж чадахгүй. Тийм болохоор Сангийн яамтай зээлийн эргэн төлөлтийн гэрээгээ тохирч чадахгүй ингээд урт хугацаанд ингээд яваад байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр ийм салбар өөрөө тарифаараа төлөх боломжгүй байгаа энэ өмнө нь хэрэгжсэн томоохон энэ төслүүдийн зээлийн өр, авлагыг юу гэдэг юм ядаж төгрөг шилжүүлэх заримыг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтад бас тооцох ийм ажлыг хийх бодит шаардлага бол байгаа.

Б.Заяабал: Анар гишүүний Байнгын хороотой холбоотой асуултад хариулахад нэгдүгээрт энэ бол манай Байнгын хорооноос санаачилж оруулж ирж байгаа тогтоолын төсөл. Тийм учраас гишүүн болгон энэ дээр саналаа өгөх ийм боломж нь бол нээлттэй байгаа. Энэтэй холбоотой Байнгын хороо нь өнгөрсөн 7 хоногт хэлэлцүүлээд бид Байнгын хорооныхоо гишүүдийн саналыг авч тусгая гэдэг үүднээс 1 долоо хоногоор хойшлуулсан. Ингээд өнгөрсөн дэх өдрийн 12 цагт Байнгын хорооны гишүүд болон холбогдох яам, агентлагуудын төлөөллийг байлцуулж энэ тогтоолын төслийг бас боловсруулсан байгаа гэдгийг хэлье.

Таны асуусан Ки Пи Ай-тай холбоотой асуудлыг бол энэ тогтоолын 2 дахь заалт дээр тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийн явцыг заалт тус бүрээр гаргаж 26 оны 4 дүгээр улиралд багтаан Их Хуралд ирүүлэхийг бас үүрэг болгосон ийм заалтыг бас оруулж өгсөн байгаа гэдгийг бас хэлье.

Анар гишүүн тодруулга.

Ч.Анар: Байнгын хорооны даргаа би 2 долоо хоног орон нутгийн томилолттой явсан болохоор яг энэ хэсэг дээр нь орхичихъя. Одоо бол Их Хурал руу орж ирж байгаа тогтоол маань заавал хавсралттай ордог болчихсон гэж ойлгоод байгаа. Нөгөө Эдийн засгийн байнгын хорооны Мягмарсүрэн даргаас асууя. Тэгээд тэр хавсралтыг л энэ тогтоолоо дагаж оруулж ирэх үү гэж асуугаад байгаа юм.

Б.Заяабал: Байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн тодорхой хариулт өгнө үү.

Д.Мягмарцэрэн: Гишүүдийн өнөөдрийн мэндийг хүргэе. Анар гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн. Энэ тогтоол дээр бол Ки Пи Ай боловсруулна гээд тэгэхээр дахиад нөгөө ажлын хэсэг байгуулагдаж ажиллаад тэгээд Ки Пи Ай боловсруулна энэ тэр гээд явж байгаа. Сая 29-нд 1 дэхэд 12 цагаас уул нь гишүүд ингээд цуглаад ярилцаад тэгээд яг тэр Ки Пи Ай-ын талаар тодорхой яачихдаг одоо дахиад ингээд Ки Пи Ай боловсруулна гэхээр энэ дараагийн долоо хоног руу шилжих ч юм уу, бүүр ингээд цаг хугацааны хувьд бол тиймэрхүү болчихоод байгаа.

Б.Заяабал: Та яах нэмэлт тодруулга авах уу? Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Би үүнийг бол яах вэ зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ ингэж бодоод байгаа юм Байнгын хорооны даргаа. Нэгдүгээрт бид нар чинь сая жилийн төлөвлөгөөгөө баталчихсан. Ирэх жил юу юуг санхүүжүүлэх вэ, ямар ажил Засгийн газар хийх вэ гэдгээ баталчихсан. Ингээд тэрүүн дээр чинь ер нь 27 оны төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд бол ер нь бараг улсын төсвийн хөрөнгө оруулалтыг бүүр жижиглээд жиргэчихсэн юм шиг юм болсон юм шүү дээ. Соёлын төвийн бараг хөгжим, тоног төхөөрөмж ч гэл үү, дотуур байрны юу юу гээд ингээд бүүр маш их жижиглэсэн. Бид нар мега төсөл буруу гэж ярьснаа өмнө нь болохоороо ийм жижигхэн арай ч юм байж болохгүй гэснээ одоо бараг л подъездны засвар гэж бичих нь холгүй юм болсон. Тэгээд одоо эрчим хүчний салбар маш хүнд байгаа нь үнэн.

Тэгэхээр ирэх жил уг нь бол ингэнэ ээ гэвэл ялангуяа жилийн төлөвлөгөөндөө, жилийн төлөвлөгөө батлахаас өмнө Эдийн засгийн байнгын хороон дээр үүнийгээ оруулаад үүнтэй холбоотой төсөв санхүүжилт хамаг юмнуудаа маш сайн гаргаж ирж танилцуулаад ингээд жилийн төлөвлөгөөнд суулгасан бол үүн дээр төсөв тавихад Төсвийн тухай хууль болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль гээд бүх хуультайгаа илүү их нэгдүгээрт нийцэх байжээ гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт энэ тогтоолын төслийн 6 дугаар, 1.6 дээр Байнгын хорооны даргаа энэ Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ гэж тавьж болохгүй. Энэ Тусгай сангийн тухай хуулиа зөрчих гээд байгаа байхгүй юу. Энэ чинь Засгийн

газрын нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна гээд энэ хуулийн 11.5 дээр байдаг. Энэ дээр Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшиг, аюулт, үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулахад тархалтыг хязгаарлахад гэж байгаа юм.

Үйлдвэрлэлийн осол горим зөрчигдсөнөөс барилга байгууламж эвдэрсэн, бүүр сүйрэхээс үүдсэн ийм тохиолдолд, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас, эс үгүй бол олон улсын шүүхийн шийдвэр гарсан, олон улсын гэрээ зөрчсөн ийм ийм, эс үгүй бол ээлжит бус, дахин сонгууль, нөхөн сонгуультай холбоотой гэхээр одоо хэдүүлээ төсөв нь ч ороогүй байна. Энэ бүгд дээрээ нэг Засгийн газрын Улсын Их Хурлын нэг тогтоол нь Улсын Их Хурлаар баталсан нэг хуулиар зөрчсөн ийм тогтоол гаргаж болохгүй учраас Засгийн газар хэрэгжүүлэх боломжгүй ийм тогтоолыг бид нар зүйл, заалт оруулж бол болохгүй гэж бодож байна. Тийм учраас Засгийн газрын нөөц сан гэдгийг нь бол хасах нь зүйтэй байх.

Харин хаанаасаа санхүүжүүлэх юм, жинхэнэ би бол үүн дээр үнэнийг хэлэхэд Хөгжлийн банкаа уг нь оруулах ёстой гэж бодож байна. Хөгжлийн банк чинь мега төсөл гээд ийм юмыг жинхэнэ санхүүжүүлнэ гээд байсан одоо тэгээд яг юу хийж байгаа юм бол Хөгжлийн банк? Хэчнээн хүнтэй яаж, ямар ажил хийж байгаа юм бол. Ер нь энэ Эдийн засгийн байнгын хороон дээр Энэ хөгжлийн сангийн банкны үйл ажиллагааны тухай сонсвол яасан юм гэж би бас бодож байна. Тэгээд энэ бол улсын төсвөөс санхүүжүүлэхэд үнэнийг хэлэхэд эрчим хүчний эх үүсвэрүүд бол бас хэцүү.../минут дуусав./

Б.Заяабал: Нэмэлт Булгантуяа гишүүний нэмэлт минут өгье.

Х.Булгантуяа: Тэгэхээр эрчим хүчний эх үүсвэрүүд бол үнэхээр том дүнтэй. Тэгэхээр үүнийг бол улсын төсвөөс дандаа санхүүжүүлэх ч байдаг юм уу, Засгийн газрын нөөцөөс энэ тэр санхүүжүүлэх бол хэцүү. Хөгжлийн банк бол үүн дээр уг нь бол хамгийн зөв хэрэгслийн нэг. Дараа нь орлогоороо буцаад зарлагаа нөхөөд ингээд явахад бол бүрэн боломжтой тооцооллыг та бүхэн маань хийгээд ингээд явж болох байх. Тэгэхээр үүнийг нэг сонсох нь бол зүйтэй болов уу. Эх үүсвэрийг нь арай өөр байдлаар заах нь зүйтэй болов уу.

Манай Энхцэцэг гишүүний Дулааны хуулийн санал та бүхэн ирүүлсэн үү? Зарим хуулиудыг ингээд явуулах гээд энд Их Хурлын гишүүд ажиллаад Цэнгүүн гишүүн ажилласан байх нэлээн том ажлын хэсэг ажиллаад явуулахаар ингээд та бүхэн маань таг дараад суучих юм. Бид нар л хийвэл ажил бусад нь хийвэл ажил биш гэж бас болохгүй шүү дээ энэ чинь. Эрх зүйн байдлыг чинь сайжруулъя гэж байгаа бол энэ чинь азны юм гээд ингээд дэмжээд явах ёстой юм биш үү. Тэгэхээр бүхэл бүтэн эрчим хүчний доктор хүн Их Хурлын гишүүн болоод.../минут дуусав./

Б.Заяабал: Булгантуяа гишүүний асуултад индрийн микрофон Эрчим хүчний яам. Яг тэр 1.6 дугаар заалттай холбоотой энэ яг энэ тоног төхөөрөмж шаардлагатай санхүүжилтийн дутагдал гэсэн асуудал яригдаад байна шүү дээ. Энэ дээр тодорхой мэдээлэл өгөөдөх.

Б.Ерэн-Өлзий: Жил болгон төрийн өмчит 27 компаниудаас өвөлжилтийн бэлтгэлдээ зориулаад засвар, шинэчлэлийн ажлын санал компаниудад нь ирүүлдэг. Тэр бол ойролцоогоор 500-600 тэрбум төгрөгийн санал ирдэг юм. Энийг нь төлөөлөн удирдах зөвлөл, бодит тарифаар тогтоосон тухайн компанийн орлогод нь нийцүүлээд 200 гаруй тэрбум төгрөг баталж өгч байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө яг компаниуд бол яг төлөвлөсөн засварынхаа бол яг бодитоор бол 50 хувийг л хийх байдалтай ингээд яваад байгаа юм. Тэгээд аль болохоор нөгөө үндсэн асуудлаар нь засаж шийдвэрлэх гэхээсээ илүү зарим тоноглолыг бол аргацаах маягтай. Тэгэхээр энэ дээр үүсээд байгаа бас хүндрэлийг Засгийн газрын бас тодорхой санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэвэл бас уг нь бол салбарт ямар өвлийн оргил ачааллын үед тасралт, сааталтгүй найдвартай байдлаа хангаж ажиллахад бас нэлээн дэмжлэгтэй байгаа юм.

Хөгжлийн банканд бол бид нар бол томоохон төслүүдээ санхүүжүүлэе гэдэг хүсэлт хүргүүлж байгаа. Тэгээд өмнө нь бол Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр Амгалангийн станцаа өргөтгөсөн. ТЭЦ-IV-ийн турбины шинэчлэлтүүдээ хийсэн байгаа. Тэгээд эдгээр төслүүдийн бас Дорнодын станцын 50 мега шинэ станцыг барьсан. Эдгээр бас төслүүд дээр зарим дээр нь бол энэ зээлийн эргэн төлөлтөө хангаад явахад одоогийн тариф хүндрэл учруулж байгаа. Дорнод бол яаж ийж байгаад бас зээлээ төлөөд яваад байг. ТЭЦ-IV бол яг тарифын бодит орлоготойгоо уялдаад зээлээ төлж чадахгүй байгаа гээд ингээд хүндрэлтэй асуудлууд байгаа. Хөгжлийн банкны зүгээс шинээр эрчим хүчний салбар төсөл хэрэгжүүлэе гэхээр өмнө авсан төслүүдийнхээ зээлийн эргэн төлөлтийг хэвийн болгох гэдэг л шаардлагыг тавиад байгаа.

Дулаан хангамжийн тухай хууль дээр Эрчим хүчний яам саналаа тусгаад Хууль зүйн яаманд хүргүүлсэн байгаа.

Б.Заяабал: Булгантуяа гишүүн нэмэлт тодруулга.

Х.Булгантуяа: Ерэн-Өлзий дарга. Тэгэхдээ тэгээд Засгийн газрын нөөц сангаас жилд 200 тэрбумыг төрийн өмчит компаниуд дээрээ тавихаар нийт шаардлагатай засвар үйлчилгээнийхээ 50 хувийг хийдэг ээ гэж байна. Засгийн газрын нөөц сан ч өөрөө 200 тэрбум биш шүү дээ. Тэгэхээр үлдсэн 50 хувиа та нар яая гэж бодож байгаа юм. Тэгээд Засгийн газрын нөөц сангаас хийе гэдэг энэ тогтоолыг Улсын Их Хурлын батлах нь та Төрийн нарийн бичгийн даргын хувьд энэ нь эрх зүйн хувьд зөв үү? Эрх зүйн хувьд ийм манай Хууль зүйн байнгын хорооны бас зөвлөхүүд бас юу яагаарай. Тэгэхээр ийм эрх зүйн хувьд алдаатай тогтоол Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хороо баталж бас болохгүй. Тэгэхээр энэ нь бас болох юм уу?

Тариф, үүнтэй холбоотой юмнуудаа та бүхэн маань тэгээд л энэ нөгөө санхүүжилтийн эх үүсвэрүүдээ аваад л эдийн засгийн хувьд аль болохоор бие даасан байдлаа хангахын төлөө ажиллахаас өөр аргагүй. Одоо ямар шинээр барих биш засвар үйлчилгээний л санхүүжилт байгаад байгаа шүү дээ.

Б.Заяабал: Индрийн микрофон дээр. Индрийн микрофон олгоё

Б.Ерэн-Өлзий: Хөгжлийн банкны зээлээр бол голцуу тухайн ажиллаж байгаа төрийн өмчит компани, үйлдвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлийн төслүүдийг шинэ зуух барих, шинэ станц барих, шинэ турбин суурилуулах гэх маягаар явж байгаа. Энэ онд бол Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр өвөлжилтийн бэлтгэлд зориулж бас 5 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тийм тэгээд ер нь бол Хөгжлийн банкны зээл бол тодорхой яг өргөтгөлийн төслүүдэд бол санхүүжүүлж явж байгаа. Цаашид ер нь бол эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын

тарифын энэ тогтолцоо дээр бас шинэчлэлт хийх, тодорхой энэ төрийн өмчит компаниуд тодорхой хувийг хувийн хэвшилд шилжүүлж, хувьчилж, хөрөнгө оруулалт татаж үүгээрээ бас энэ дутагдаад байгаа засвар, шинэчлэлээ хийх ийм шаардлага бол бодлого бол бид нарт байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Уянга гишүүн.

Б.Уянга: Эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний гээд энэ Улсын Их Хурлын тогтоолын агуулгыг уншихаар та хэдийн заавал ер нь бол хийх ёстой ажлуудыг л бүгдийг нь дараалуулаад биччихсэн байгаад байх шиг байх юм. Яг ийм Улсын Их Хурлын тогтоол яг ямар учраас хэрэгтэй байгаа юм бэ гэдгийг нь хариулаад өгөөч. Эрчим хүчний тухай хуулиа шинэчлээд найруул аа, Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн байдал хараат бус байдлыг сайжруулах тухай хуулийн төслийг боловсруулаад Их Хуралд өргөн мэдүүл ээ гэж ээ. Угаасаа та хэдийн хийх ажил биз дээ? Эрчим хүчний тогтвортой шилжилтийн стратеги боловсруул аа, угаасаа боловсруулах ёстой биз дээ? Ингэснээ эрчим хүчний үнэ, тарифыг хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх, санхүүжилтийн арга механизмыг судалж шийдвэрлэ ээ гэнэ. Эсвэл энэ нь бас зайлшгүй тогтоол дээр тусаж байж хийгдэх юм уу? Эрчим хүчний салбарт үүссэн хуримтлагдсан өр, авлагыг бууруулах, урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг барагдуулах асуудлыг судлах хийх ёстой ажил шүү.

Тэгээд сүүлд нь бас ингэжээ сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой, түгээх болон дамжуулах сүлжээнд нийлүүлэх эрх зүйн орчин, техникийн шаардлага, төлбөр тооцооны механизмыг боловсронгуй болгох. Саяхан та хэд чинь сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хэрвээ айлууд үйлдвэрлээд илүүгээ өгье гэх юм бол худалдаж авах тийм журам нь гараад байсан юм биш үү? Энхцэцэг гишүүн бүх аймгаар яваад л энийг тайлбарлаад л танай яамнаас зарим аймагт нь яваад байсан. Тэгээд миний үндсэн асуулт нь болохоороо яг энэ тогтоол байхгүй бол хийж чадахгүй байгаа зүйл нь юу юм бэ?

Хоёрдугаарт эрчим хүчний салбарынхан ажил хаяна гээд байгаа тээ? 22 цагийн өмнө “Эрчим хүч” гэсэн сэтгүүл дээр гарсан мэдээллээр 48 цагаар түр хойшлуулсан гэнэ. Эрчим хүчний салбарын ажилтнуудын цалинг 2026, 2027 онд үе шаттайгаар нийт 30 хувиар нэмэгдүүлэх тодорхой санал ирүүлж, талуудын хооронд хэлэлцээ эхлүүлэх боломж бүрдсэн тул гээд тэгээд 48 цагаар. Тэгээд магадгүй энэ тогтоол нь тэрэнд хэрэгтэй юм болов уу гээд уншихаар ямар ч агуулга нь байхгүй. Тэгэхээр эхний асуулт нь тогтоолын үндсэн шаардлага нь юу юм? Хоёр дахь нь энэ ажил хаялттай холбоотой яг танай салбарт юу болоод байгаа юм бэ гэдгийг хариулаад өгнө үү.

Б.Заяабал: Индрийн микрофон.

Б.Ерэн-Өлзий: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ дээр тогтоолын зүйл, заалт дээр туссан асуудлууд дээр бас одоо эрчим хүчний салбар, Эрчим хүчний яаман дээр ажил зохион байгуулаад явж байгаа ажлууд бол байгаа. Ерөнхийдөө энийг бол Улсын Их Хурлаас Засгийн газар Эрчим хүчний яаманд өгч байгаа үүрэг, даалгавар гэж бид нар ойлгож энэ бас төслүүд дээр нь санал өгсөн.

Тухайлбал, Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл бэлтгэх ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Тогтвортой шилжилтийн стратегийн төслийг боловсруулаад ингээд явж байгаа. Тэгээд гол

асуудал дээр нь Улсын Их Хурлаас бас дэмжлэг өгч байгаа гол заалт бол энэ эрчим хүчний үнэ, тарифыг зах зээлийн зарчим өртөгтэй уялдуулан эдийн засгийн өсөлт, эрчим хүчний салбарын өрсөлдөх чадварыг хангах, хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн тэнцвэртэй түвшинд нь ингэж үнэ тарифын бодлогыг явуулах үүрэг даалгавар бас өгч байгаа нь энэ бол гол ач холбогдолтой заалт байгаа гэж бид нар үзэж байгаа.

Салбарын, Эрчим хүчний салбарт 2 үйлдвэрчний эвлэлийн холбоо байгаад байгаа юм. Нэг нь болохоор үндсэн Монголын үйлдвэрчний эвлэлийн хорооны дэргэдэх Монголын геологи, эрчим хүч, уул уурхай үйлдвэрчний эвлэлийн холбоо байгаа. Нөгөөдөх нь бол дараа нь шинээр байгуулагдсан Дулаан, цахилгаан үйлдвэрлэгч, түгээгчдийн үйлдвэрчний эвлэлийн холбоо гээд ийм 2 холбоо маань тусдаа үйл ажиллагаа явуулаад байгаа бас нэлээн хүндрэлтэй асуудал байгаа. Эдгээр холбоодоос 06 сарын 30 болон 07 сарын 02-нд ажил хаяна гэдэг мэдэгдлээ бол ирүүлсэн. Бид нар бол Монголын геологи, эрчим хүч, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоотой болон эдгээр холбоотойгоо удаа дараагийн хэлцэл хийгээд зарим нь бол тохиролцоонд хүрээд ажил хаялтыг бол хойшлуулчихсан байгаа. 06 сарын 30-ны ажил хаялт бол хойшилсон.

Өнөөдөр 2 холбоотойгоо сая 12 цагт уулзаж зар хүргээд ярилцсан. Монголын геологи, эрчим хүч, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо бол ер нь бол харилцан зөвшилцлийг бол хүлээн зөвшөөрч тэдний зүгээс бол ажил хаялтаа зогсоож байгаа талаар бол өнөөдөр 1:30-аас хэвлэлийн хурал хийнэ ээ гэдгээ бид нарт бол мэдээлсэн байгаа.

Нөгөө үйлдвэрчний эвлэлийн холбоотой бол бид нар аль болохоор ойлголцье, зөвшилцье, нэгдсэн ойлголцолд хүрье гэдэг байдлаар ингээд уулзалт хийгээд явж байгаа.

Б.Заяабал: Уянга гишүүн.

Б.Уянга: Харин тийм. Яг энэ тогтоолын төсөл хэрэгтэй байгаа хэсэг нь хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн тэнцвэртэй түвшинд хүргэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Тэгээд зөвхөн энэ л гэж ойлгогдоод байх юм таны хариултаас. Та хэд маань уул нь төрийн албан хаагчдын хувьд хэрэгтэй зүйлээ хийгээд ингээд аягүй аятайхан хууль, эрх зүйн орчин дээрээ өнөөдрийн энэ сууж байгаа бүх цагаа зарцуулах ёстой байтал нээх шаардлагагүй тогтоол гаргаж ирчхээд бид нарыг хүртэл ажлаар уях юм. Тэнцвэртэй байдлаар л тэгээд л хамаг юмаа хийх ёстой биз дээ уг нь. Яг үнэндээ яг бодитой яг тийм оносон хариулт гэж би харахгүй байна. Тэгээд хэлэлцүүлгийн үеэр өөр нэмэлт шаардлагууд гарч ирэх эсэхийг нь харъя.

Б.Заяабал: Уянгаа гишүүн санал хэллээ. Батчимэг гишүүний микрофон болгоё.

П.Батчимэг: Манай Эдийн засгийн байнгын хорооны гишүүд жоохон анхаарлаа хандуулах уу? Ер нь эрхэм Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд бол энэ Улсын Их Хурлын тогтоол гарах гэж байгаа, энэ батлуулах гэж байгаа Их Хуралд оруулж байгаа, Улсын Их Хурлын тогтоолын талаар маш сайн уншиж ойлгочихсон байгаа гэж би бодож байна. Тэгэхээр гишүүд маань юуны түрүүнд эхлээд энэ Засгийн газрын бүрэн эрхийн асуудалд Улсын Их Хурал тогтоол гаргах замаар оролцох нь зөв эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай

юм шиг харагдаж байгаа юм. Яагаад гэхээр эрчим хүчний тухай хуулийн 4.1 дээр Улсын Их Хурал эрчим хүчний талаарх төрийн бодлогыг тодорхойлно оо гээд.

Мөн энэ Эрчим хүчний тухай хуулийн 5.1.1 дээр Засгийн газар эрчим хүчний талаарх төрийн бодлого, Эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах гэж байгаа юм. Тэгэхээр Улсын Их Хурал Засгийн газрынхаа бүрэн эрх рүү ингэж орж энэ тогтоол батлуулах хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юу гэдгийг зөв үү буруу юу гэдгийг дүгнэх хэрэгтэй болчихоод байгаа юм.

Энэ тогтоолын төслөөр ингээд харахаар 6 дээр тэр өвлийн их ачааллын үед үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх хүрээнд гээд энэ ер нь Засгийн газрыг энэ тогтоолын төсөл, энэ тогтоолоороо бид нар хууль зөрчихийг дэмжээд байгаа юм уу, эсвэл зөвшөөрөөд байгаа юм уу? Ийм агуулгатай заалтууд ороод ирсэн. Дулааны цахилгаан станц, цахилгаан дамжуулах түгээх станц энэ бүх тоног төхөөрөмжийн засварт шаардлагатай санхүүжилтийн дутагдлыг гээд байгаа шүү дээ. Энийг яах юм? Засгийн газрын нөөц сангаас, тэгээд холбогдох эх үүсвэр гээд. Холбогдох эх үүсвэр гэж ямар эх үүсвэрийг хэлээд байгаа юм? Энэ тодорхой бус, энэ чинь бүүр хуулиас гадуур санхүүжилт бий болгох гээд байна аа гэсэн ийм нөхцөл байдал үүсээд байна.

Бас тогтоолын төсөл дээр тендерийн асуудал. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиас гадуур бас тендер зохион байгуулах ийм заалтууд бас ороод ирчхэж. Энэний өнгө аяс харагдаад байна. Тэгэхээр өнөөдөр эрчим хүчний салбарын нөхцөл байдал хүнд байна уу? Хүнд байна. Асуудалтай байна уу? Асуудалтай байна. Ажилчид нь өнөөдөр ажил хаялт зарлах гээд ингээд юугаа хойшлуулаад цаг цагаар хойшлуулаад явж байгаа. ХҮН намаас сонгогдсон энэ эрхэлсэн захирал Найдал, энэ Найдалаа захирал ер нь сонгогдож оччихоод эрчим хүчний салбарт эрчтэй хүчтэй орж байгаа юм шиг тийм харагдаад байгаа боловч начин дээрээ үнэхээрийн энэ ажил энэ эрчим хүчний салбарын ажил явахгүй байна шүү дээ. Улсын Их Хурал арга ядахдаа тогтоолын төсөл боловсруулж өвөлжилтийн байдал, өнөөдөр цахилгаантай өвөлжих үү үгүй юу, тог тасрах уу үгүй юу гэдэг дээр санаа зовж энэ нийслэлийн ард иргэдийн төлөө санаа зовсондоо энэ тогтоолын төслийг оруулж ирж байна аа гэж.

Б.Заяабал: Батчимэг гишүүний микрофон олгоё.

П.Батчимэг: Эрчим хүчний салбарын энэ алдагдалтай ажиллаж байгаа олон олон төрийн өмчит компаниуд үйлдвэрүүд, өнөөдөр ажилчдынхаа цалинг 10 хувиар нэмнэ ээ, өөр төсөв байхгүй ээ. Тоосонд дарагдсан танк гээд нэрлэгдсэн салбар аа. Тоосоо арчиж байж өнөөдөр энэ салбар амьд ийм явах ийм дүр зургийг сайд өөрөө хэлээд зогсож байгаа шүү дээ.

Нэгдүгээрт сайдын ярьж байгаагаар эрчим хүчний салбарын ажилчдын цалинг нэмнэ гэдэг бол нэгдүгээр асуудал биш. Бидэнд хийх ажил зөндөө байна гээд. Сэргээгдэх эрчим хүчний аукцион гээд ингээд зарлаад эхэлчихсэн. Баахан олон тендерүүдийн асуудал шуурхайлах ажлууд нь эхэнд нь тавигдчихсан. Хүний асуудал, ажиллах хүчний асуудал бүр сүүлд хаягдчихсан. Ийм учраас салбарын ажилчид өнөөдөр арга ядахдаа өнөөдөр тэмцэж цалингаа 30 хувиар нэмүүлнэ ээ гээд ингээд байж байгаа. Үнэхээрийн хүндрэлтэй асуудал гарч байгаа. Энэ эрхэлсэн сайд юу бодож явдаг юм бүү мэд.

Б.Заяабал: Батчимэг гишүүн санал хэллээ. Батболд гишүүн.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Би бас энэ Уянга гишүүнтэй бас санал нэг байсан юм. Заавал энэ уншаад үзэхээр яг л нөгөө хийгдэх ёстой ажлууд л байгаад байсан юм. Тэгээд тэр 5 дугаар зүйлтэй холбоотойгоор бас хардах гэх юм уу ийм асуудал байгаад байна. Юу гэхээр энэ өвлийн их ачааллын үед иргэн, аж ахуйн нэгжийн хувийн хэрэгцээний зориулалтаар суурилуулсан 1500квт-аас дээш гэж байгаа юм. Тэгэхээр хувийн хэрэгцээ чинь өөрөө хэдэн киловатт байдаг юм? Тэгээд 1500квт-аас дээш гэдэг чинь ер нь аль зэрэг өөрөө эрчим хүч юм? Ер нь бол яах вэ сэргээгдэх эрчим хүчийг би дэмжээд байгаа. Энийг уул нь хөгжүүлээд бид нар өөрсдөө өөрсдийнхөө хэрэглээг хангах ёстой гэсэн байдлаар ханддаг.

Гэтэл бид нар одоо хувийн хэрэглээндээ болохоор хямдхан үнээр төвийн системээс эрчим хүчээ хэрэглэхээд тэгээд сэргээгдэх нь эргүүлээд нийлүүлэхээрээ үнэтэй нийлүүлээд байдаг. Тэгээд алдагдал нь хаанаа тооцогдоод яваад байгаа юм энэ чинь. Одоохондоо яах вэ мөнгө төлөөгүй байгаа байх.

Тэгэхдээ баахан өр үүсчихсэн яваад байдаг. Тэгээд энэ дээр ер нь энэ Эрчим хүчний яамныхан өөрсдөө яг юу гэж бодож байгаа юм? Энэ 1500квт-аас дээш ингээд хувийн хэрэглээний сэргээгдэх эрчим хүчийг дамжуулах сүлжээнд нийлүүлээд байж болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Үнэ, төлбөрийнх нь хувьд ер нь юу ямар бодолтой байдаг юм? Энэ дээр асуулт асуумаар байна.

Хоёрдугаарт гэх юм бол тэр Батсүмбэрэл гишүүний хэлээд байгаа бас үнэн байгаад байгаа юм. Энэ ХҮН намын очсон салбар дээр л дандаа байнгын ийм боловсон хүчний хөдөлгөөн наашаа, цаашаа халсан барьсан энээ тэрээ гэсэн асуудлууд зөндөө гараад байдаг. Наранбаяр сайдын хувьд бол би мэдэхгүй юм. Мэддэггүй болохоор дуугардаггүй байсан юм. Найдалаа сайдын үед эрчим хүчний салбар дээр энэ асуудал нь зүгээр манай гэрийн хаалгыг өшиглөөд гэрт ороод ирчихсэн явж байгаа. Түгээх сүлжээний мэргэжилтний түвшинд оччихоод нааш нь цааш нь сольдог, хөдөлгөдөг ийм асуудал явж байна. Тэгэхээр яамныхан энэ дээр та нар энэ шинэ сайдыг очсоноос хойш хэдэн хувь гэдэг юм уу, хэчнээн хэмжээний хэд ажилчдыг ингээд мэргэжилтнүүдийг хооронд нь хольж солиод ингээд хөдөлгөөн хийчхэв? Хэдэн хувийг нь дарга нараа ингээд өөрчилчхөв? Энийгээ бас хэлээд өгөөч. Тэгээд тодруулъя даа.

Б.Заяабал: Индрийн микрофонд нээе.

Б.Ерэн-Өлзий: Батболд гишүүний асуултад хариулъя. Сэргээгдэх эрчим хүчний одоогийн хуулийн зохицуулалтаар бол хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс илүүдлийг нь худалдаж авч болно. Энэ талаар журам баталж гаргана гэсэн ийм зохицуулалт бол байгаа юм. Өнгөрсөн хугацаанд энэ журам бол мөрдөгдөөд явсан. Хэрэглэгчид илүү өөрсдийнхөө хэрэгцээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр дэмжих талаас нь бол гол явсан механизм нь болохоор айл өрх дээр бол тодорхой тариф тогтоод, өөрийн хэрэгцээнээс илүү гарсан сүлжээнд нийлүүлж байгаа тариф, цахилгааныг нь бол зохицуулах хороо бол тодорхой тариф батлаад ингээд дэмжээд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нь урамшуулах дэмжих маягаар ингээд одоо бол явж байгаа. 280, 85 нь болохоор өдрийн цагаар.

Оройн оргил ачааллын үед 300 төгрөг. Хэрэглэгчид нийлүүлж байгаа. Тийм ахуйн эрхлэгч бол 210 орчим. Тэгээд томоохон басаж ахуйн нэгжүүдэд өөрсдийн хэрэгцээндээ бас сэргээгдэх эрчим хүч ашиглаж байна. Тэгээд аж ахуйн нэгжүүдэд нь зарим үед нөгөө үйлдвэрлэл нь зогсдог, эсвэл хэрэглээ байхгүй үедээ бид нар энэ өөрийн хэрэгцээнд зориулсан юм юмандаа бас сүлжээнд нийлүүлж баймаар байна гэдэг ийм хүсэлтүүд ирж байгаа. Энэтэй нь уялдуулаад бас ба бид нар энэ хууль дээрх журамдаа бас холбогдох өөрчлөлтийг оруулъя гээд ингээд төсөл санаачлаад явж байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Боловсон хүчний асуудал дээр.

Б.Ерэн-Өлзий: Одоом Эрчим хүчний яаман дээр ямар тийм өөрчлөлт, хөдөлгөөн их орсон зүйл байхгүй байгаа.

Б.Заяабал: Батболд гишүүн нэмэлт тодруулга.

Р.Батболд: Тэгэхээр саяын хариултаас тодорхой болж байгаа байх тийм ээ. Бид нар хэрэглэгчдэдээ нийлүүлэхдээ эрчим хүч маань өөрөө 210 төгрөгөөр нийлүүлчхээд буцаагаад авахдаа 280-аар юм уу 300 төгрөгөөр авна гээд байгаа юм. Тэгээд энэ хооронд чинь алдагдал гардаггүй юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт эд ачааллын үедээ яг хэн аль нийлүүлэгч нь хэдий хэмжээний хэдэн киловатт цахилгаан эрчим хүч нийлүүлээд байна гэдгээ тооцоолох тийм та нарт боломж нь, чадвар нь байгаа юм уу? Боломж нь байгаа юм уу? Сүлжээндээ шууд тооцох боломж нь байгаа юм уу гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Сэргээгдэхийг бол би дэмжээд байгаа юм. Тэгэхдээ өөрийгөө хангах түвшинд явъя гэдэг дээр дэмжээд байгаа юм. Түүнээс биш ингээд та нар чинь дараа нь ингээд дамжуулах, түгээх энэ сүлжээнийхээ тогтвортой ажиллагаа горимыг нь ер нь яаж хангах гээд байгаа юм? Дуртай айл нь 10, 15квт-аас юм уу, одоо энэ чинь 1500квт-аас дээш тавих нь л дээ янз нь. Тэгэхээр энэнийхээ юуг нь зохицуулалтыг нь.../минут дуусав./

Б.Заяабал: Байнгын хорооны туслах чиг үүрэгтэй ажлын хэсгээс хэн хариулах вэ? Индрийн микрофон дээр очъё. Индрийн микрофоныг нээе.

Б.Ерэн-Өлзий: Одоо айл өрхөөс түгээх сүлжээнд нийлүүлж байгаа нийлбэр нарны панелын хүчин чадал 5мвт-ыг орчим байгаа. Улаанбаатар хотын тухайд аваад үзэхээр энэ тоог бол 50мвт хүртэл нэмэгдүүлэх бол бас боломж байна гэсэн тооцоо бол гарсан.

Тэгэхдээ үүний зэрэгцээ бид нар тухайн нарны панелууд баригдаж байгаа гудам, хорооны түгээх сүлжээн дээр бас хүчин чадлыг өргөтгөх ажлуудыг давхар хийгээд ингээд явах бол шаардлагатай бол байгаа. Ер нь цаашид эрчим хүчний тухай хуульд салбарын шинэ зах зээлийн загвар тогтох, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх гол энэ хууль, эрх зүйн өөрчлөлт орно. Энэ орсноор бол энэ Зохицуулах хороо тогтоогоод явж байгаа тарифаар хэрэглэгчдийн энэ илүүдлийг авах биш эсрэгээрээ хэрэглэгчид энэ зах зээлийн өрсөлдөөнд ороод өрсөлдөөний үнээр өрсөлдөхүйц үнээр үнээ сан.../минут дуусав./

Б.Заяабал: Гүйцээж хариулъя. Индрийн микрофон.

Б.Ерэн-Өлзий: Илүүдэл эрчим хүчээ ингэж худалдах ийм зохицуулалт бол хуулиар орно оо гэж би түрүүн л төсөөлж байгаа.

Б.Заяабал: Болчихсон уу? Нэмэлт тодруулга Батболд гишүүн.

Р.Батболд: Бас л гоё хөгжилтэй тайлбар хэлж байна шүү тээ. Яана гэнэ ээ нөгөө дахиад нөгөө окшн шигээ юм хийх юм уу тээ? Бодвол энэ хувийн хэрэглэж байгаа айлуудынхаа дунд нь та нар хэдээр нийлүүлэх юм бэ гэдэг юм зарлах гэж байгаа юм уу, эс үгүй бол айл болгон та нартай очиж бид нар тэд гэж доош нь шийдэх юм уу яг ямар тайлбар хэлчхэв ээ гэдгийг нь би сайн ойлгосонгүй сая бол. Энэ авч байгаа үнээсээ мэдээж багаар нийлүүлж байвал болж байна л даа. Болж байна. Түгээхээс өөрсдөө хэрэглэж байгаа үнээсээ бага нийлүүлье гэвэл болж байна.

Тэгэхдээ тэрийгээ яаж тогтоох гээд байгаа юм гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ горимын зохицуулалтаа ер нь яаж хийх гээд байгаа юм. Яаж тогтворжуулах гээд байгаа юм бэ гэдэг л асуудал байгаа юм. Одоо 5мвт-ыг авч байна. 50 болгоно гэж байна. Энэ чинь дандаа эд ачааллын үед нийлүүлж чадахгүй шүү дээ. Хувийн хэрэглэгчид бол. Тэгэхээр 1500 гэж ингэж тогтоолоор заавал ч үгүй ингэж авчирч тавьчихаад та нар ямар нэгэн юм нээх гээд байна уу? Ямар учиртай ингэж оруулаад байгаа юм?

Б.Заяабал: Найдалаа сайдын микрофоныг олгоё. Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Батболд гишүүний асуултыг би бас нөгөө хоцорч орж ирсэн болохоор сайн ойлгосонгүй. Тодруулсан ч гэсэн бас сайн ойлгосонгүй. Яг юунд санаа зовж байгаа юм сайн ойлгосонгүй. Ер нь бол байна шүү дээ энэ салбар чинь удаан жилийн түүхтэй. Тэр горимын тохируулга болон тэр техникийн ажлуудыг сайн хийгээд ирсэн болохоор энэ эрчим хүчний систем тогтож байгаа юм. Энэ жоохон алдах л юм бол угаасаа болдоггүй зүйл байгаа юм. Тэгэхээр та тэрэнд битгий санаа зовоорой. Энэ дээр тэгээд тохируулалтай холбоотой манай Амарсанаа захирал дахиад хэлчих биз. Батарей хураагууруудыг бас нэмж байгаа. Энэ бүгдийг яг үүргээр нь ашиглаж эхэлнэ гэж бодож байгаа. Тэгээд Амарсанаа захирал товчхон хэлэх үү? Саяын тохируулга гээд энэ тийм товчхон та энгийн үгээр хэлчих үү?

Б.Заяабал: Индэрийн микрофоныг олгоё.

Ч.Амарсанаа: Улсын эрчим хүчний систем бол чадал, хүчдэл, давтамжийн тохируулгуудыг тогтмол барьж явдаг. Энэ сэргээгдэх эрчим хүчний. Диспетчерийн үндэсний төвийн захирал Амарсанаа байна уучлаарай. Давтамжийн хүчдэлийн, чадлын тохируулгууд бол тогтмол хийгдэж явдаг. Сэргээгдэхүүдэд ингээд айл өрхүүд орж ирээд ихээхэн хэмжээний чадал систем рүү орж ирэх гэж байгаа тохиолдолд бид нар энийг оператор компаниуд буюу бүлэглээд тэгээд ер нь хэсэгчилсэн байдлаар энэ тохируулгуудыг хийж ажиллана. Энийг бол бид нар хийсвэр цахилгаан станцын горим буюу virtual power plant гэдэг зарчмаар тохируулгынхаа системтэй уяж ажиллуулна. Энэ дээр бол техникийн шийдлүүд гараад ажиллаж байгаа.

Б.Заяабал: Баярлалаа. Эрдэнэбат гишүүний микрофон олгоё.

С.Эрдэнэбат: Эрчим хүчний талаар бас чухал тогтоолын төсөл орж байна. Тэгэхдээ түрүүний бас гишүүд асуулаа. Тулгамдаж байгаа эрсдэлтэй асуудлаа шийдэхэд өнөөдөр яг тулчихсан байгаа асуудал энэ салбарын чинь авч явж байгаа, нуруундаа авч барьж байгаа энэ ажилчдынхаа цалин хөлсний асуудал дээр энэ юу болж байна? Ажил хаялтын асуудал нь бараг 2 хоног хойшиллоо л гэдэг сүүлийн мэдээтэй бол байна. Ер нь бол 30 орчим хувиар цалингаа нэмүүлээч ээ гэдэг ийм санал тавьсан юм байна.

Тэгэхээр эрчим хүчний салбарын цалин хөлсний өрсөлдөх чадвар улсын дундажтай харьцуулахад бол дээгүүр байгаа хэдий ч гэсэн бусад салбар, уул уурхайн салбар руу шилжчихдэг бусад өөр салбарууд руу шилжчихдэг ийм эрс онцлогтой. Тэр утгаараа хүнд нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд бол 3 сая төгрөгийн дундаж цалинтай байна гэдэг бол тийм өндөр цалиндаа бол би бол орохгүй. Тийм учраас гарц гаргалгаа нь юу байна вэ? Одоо бид нар энэ дээр тэр яамыг болон Засгийн газрыг шийдэж өгөхөд магадгүй төсвийн асуудал тэгээд энэ тал дээрээ оруулахгүй юм уу? Тухайлбал, энэ ажиллах хүчнийхээ цалин хөлс, өрсөлдөх чадварыг тавихгүй бол баахан станц бариад л байдаг, баахан эрчим хүчний зүйл л шийддэг дотор нь ажиллах хүн байхгүй болчих вий дээ гэдэг дээр бол би бол санаа зовж байна.

Сүүлд 3 дугаар станц дээр осол гарахад бол очсон. Яг ний нуугүй хэлэхэд бол металлын илжрэлд орчихсон ихэнх техникүүд нь. Эрүүл ахуйн асуудал бол яг ний нуугүй хэлэхэд зардал хөрөнгө ч тавьж чадахаа больчихсон. Тэгээд дээрээс нь ажилчид бол сэтгүүл зүйн хувьд болон ер нь бол эрчим хүчний салбарт 3 сая төгрөгийн цалин авч байсны оронд Солонгос яваад 15 сая төгрөгийн цалин авчихъя, эс үгүй бол уул уурхайн компани руу яваад ажиллачихъя гэдэг ийм сэтгэлгээ нь давамгайлж байгаа юм байна лээ. Тийм учраас энэ асуудал дээр бол нэлээн сайн нухацтай авч үзээд ер нь бол эрчим хүчний салбарын цалинг ийм үе шаттай ингэж ингэж нэмэгдүүлнэ ээ гэдэг ийм тодорхой бодлогыг гаргаж ирж шийдэх ёстой.

Тийм учраас би салбарын сайдаас энэ талаар бол тодруулж асуумаар байна. Яг энэ ажилчидтай холбоотой асуудал гэнэт гараад байсан асуудал биш өмнөх өмнөх сайдууд дээр ингээд л яригдаад л 5, 10 хувиар аргалаад л ингээд яваад байдаг. Тийм учраас эрчим хүчний салбарт байж байгаа хүмүүсийг зөвхөн зөвхөн цалин гэлтгүй орон сууцын асуудал, сургалт хөгжлийнх нь асуудал, мөн бусад энэ асуудлууд дээр цогц байдлаар нь тавиад шийдэх талаар энэ тогтоолынхоо төсөл дээр оруулахгүй юм уу? Би яг ийм зүйл орж ирэх болов уу гэж бодсон. Яг хүнээ хаячихсан байна.

Хоёрдугаар асуудал нь энэ 1500квт-ын-аас дээш 5 дугаар дээр байж байгаа эрх зүйн орчныг нь боловсронгуй болгоё гэчихсэн байх юм. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага гээд. Тэгэхээр энэнээс доош нь байгаа нь бол тодорхой болчихсон юм уу гэдгийг асуумаар байна. Тухайлбал, иргэд чинь 20квт-ын нарны панел тавиад эрчим хүчиндээ нийлүүлье гэдэг байдлаар Ерөнхий сайдын энэ эрчим хүчний реформ шинэчлэлийн хүрээнд бол тавиад байгаа. Хамгийн гол бодлого иргэд бол нэлээн хүлээлттэй байгаа. Энэ талаар тодруулж асууя.

Б.Заяабал: Найдалаа сайд. Найдалаа сайдын микрофон олгоё.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ бол Байнгын хорооны биш Улсын Их Хурлын тогтоолын төсөл бид нар хэлэлцэж

байгаа. Тэгэхээр яг Улсын Их Хурал бол хууль тогтоох байгууллага төрийн эрх барих дээд байгууллага яг хүний нөөцийн бодлого бол яамны хэмжээний салбарын хэмжээний яг компанийн хэмжээний нарийн ширийн бодох ёстой, тусгах ёстой хэрэгжүүлэх ёстой ажил юм. Тэгэхээр яг компанийн хэмжээний нарийн ширийн бодлогыг Их Хурлын түвшинд яриад тогтоогоод цалинг тэд эд гэж ярих нь угаасаа байж болохгүй зүйл. Тийм болохоор энэ оруулаагүй юм.

Зүгээр би энэ талаар мэдээлэл өгье. Салбарт хамгийн чухалд үзэж байгаа ажил хүний нөөцийн бодлого гэж байгаа. Энэ салбарт ажиллаж байгаа 17800 хүний хөдөлмөрийн хичээл, зүтгэлийн үнэ цэнийг өсөх нь энэ салбарын бодлогын эцсийн, ерөөсөө бараг эцсийн зорилго нь энэ юм байгаа юм.

Одоогийн байдлаар Монгол Улсад дундаж цалин 2 сая 898 мянган төгрөг байдаг. Эрчим хүчний салбарын дундаж цалин 3 сая 747 мянган төгрөг. Тэгээд дунджийн хувьд бол уул уурхайн салбарын араас орж байгаа. Тийм бага биш. Гэхдээ бид нар ямар бодлого барьж байна вэ гэхээр энд шударга хуваарилагдаж байна уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Хэн нь өндөр аваад, хэн нь бага авч байгаа юм? Яг ачаалал авч байгаа хэсэг нь хөдөлмөртэйгөө дүйцэхүйц цалин авч байна уу? Энэ бол бид нарын энэ цалин нэмэх болон цаашдаа энэ хүний нөөцийн бодлогын гол цөм нь байх юм.

Тэгэхээр би өмнө нь бас зарлаж байсан. Одоо үйлдвэрчний эвлэлтэй ярьж тохирсон зүйлс бол одоогийн байдлаар 10 хувийн цалингийн санг нэмэгдүүлнэ. Бүгдийг нь хавтгайруулан нэмэхгүй, яг ачаалал үүрч байгаа, ажил дээр тогтоох хэрэгтэй байгаа, дэмжих хэрэгтэй байгаа тэр залуу мэргэжилтнүүд, цөөхөн жил ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд нэмэх талын бодлого баримтална.

Цаашдаа бол цалингийн асуудал бол зөвхөн цалин биш ээ бид нар зөвхөн цалин яриад маргалдаад тал талд гараад ажил хаяна, хаяхгүй гэж ярих нь биш үйлдвэрчний эвлэлтэй бид нар энийг ярьж байгаа. Хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэх, тогтолцоо, системийг нь шударга болгох. Цалингаас гадна тэр нийгмийн асуудал байна. Чөлөөт цагийн асуудал байна. Хөдөлмөр, аюулгүй байдлын асуудал байна. Ер нь хүн талаас нь жигдхэн бодно. Зөвхөн цалин нэмэх, нэмэхгүй тухай ярих нь бол өрөөсгөл гэж үзэж байгаа. Тэгэхээр цаашдаа бид нар 30 байтугай хувь нэмэх нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэхийн тулд бид өөрсдөө компаниуд маань ашигтай байх ёстой, үр ашигтай байх ёстой, тэр системийг нь иж бүрнээр өөрчлөхгүй бол зөвхөн цалин яриад, цалингийн дүн тавиад байх юм бол бид нар бусад ажлаа алдаад эцсийн дүндээ энэ салбарын үр дүнд нөлөөлөөд байгаа юм.

Тийм болохоор өнөөдөр бас энэ асуудлыг хэлэлцэж байгаад маш баяртай байна. Их Хурлын түвшинд ч гэсэндээ эрчим хүчний салбарын асуудлыг анхаарч байгаад маш баяртай байгаа. Тэгээд та бүхэн бас энэ дээр дэмжээд, бодлогын хувьд дэмжээд өнөөдөр болон цаашид оруулж ирж байгаа асуудлуудыг шийдээд өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүний микрофон.

Д.Эрдэнэбат: Үгүй ээ энэ мэргэжлийн Байнгын хорооны хувьд орж байгаа учраас Байнгын хорооны асуудал гэж би бол ойлгож байгаа. Би бол бүрэн эрхийнхээ дагуу энэ олон асуудал дунд чинь зарим нь бол хийгээд л явж байх ёстой уул нь л асуудлууд байна. Гэхдээ нэгэнт шуурхай ийм тогтоол гаргах гээд байгаа бол энэ цалин хөлсний, би зөвхөн цалинг 50 хувь, 30 хувь гэж нэм гэж энэ

дээр тавья гэж яриагүй. Ер нь энэ салбарынхаа цалин хөлсний өрсөлдөх чадварыг сайжруул аа, энийгээ бусад бодлогуудтай уяад яв аа, тогтвор, суурьшилтай ажиллах гэдэг асуудал дээр нь анхаарал тавиа гэдэг дээр энэ нэмэлт заалт тавьчихвал танд хэрэггүй юу л, хэрэгтэй л болов уу гэдэг үүднээс нь тавьж байгаа юм.

Тэгэхгүй бол ингээд олон тогтоол, шийдвэрүүдийг харж байхад яг хүнээ л хаяад байдаг байхгүй юу. Тэгж тэгж хуримтлагдаж хуримтлагдаж байгаад одоо магадгүй яг таны үед хүрч ирээд л тэсрэх юм руу л орж эхэлж байна л даа. Энэ магадгүй сайд хэн байхаас үл хамаараад энэ яригдаж л байсан асуудал. Аргалаад л яваад байсан. Тийм учраас энэ салбарынхаа цалин, хөлснийхөө бодлогыг ер нь эрчим хүчний салбарын цалинг тэд хавьцаа болгоно оо гэх юм бол магадгүй өнөөдөр гарах гэж байгаа ажилтан чинь тогтвор суурьшилтай үлдэнэ ээ гэдэг энэ үүднээс нь санал хэлж байгаа шүү.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн санал хэллээ. Үг, санал хамтдаа шүү дээ. Одоо би хэлээдэхье. Байж бай би хэлээдэхье.

Улсын Их Хурлын тогтоолыг Эдийн засгийн байнгын хорооноос эрчим хүчтэй холбоотой, эрчим хүчний салбартай холбоотой тогтоолын төслийг боловсруулж бид хэлэлцэж байгаа. Өнгөрсөн Байнгын хорооны, өнгөрсөн долоо хоногийн Байнгын хорооны хурлаар бид нар хэлэлцэж хойшлуулах санал гаргаж хойшлуулсан. Ингээд энэ хойшлуулсны дагуу бид 29-ний 12 цагт Байнгын хорооныхоо гишүүдийг урьж бас энэ тогтоолын төслийг боловсруулахад саналаа өгөхийг бас урьсан. Энд 5 гишүүн хүрэлцэн ирсэн. Өнөөдөр бас энэ тогтоолын төслийг, боловсруулсан тогтоолын төслийг хэлэлцэх явцад Байнгын хорооны гишүүдээс бас нэлээдгүй санал, найруулгын, зарчмын зөрүүтэй саналууд гарч байна. Зарим гишүүд энэ тогтоолын төсөл шаардлагагүй хууль зөрчиж байгаа тухай бас саналуудыг хэлж байна. Тэгээд энэ асуудлуудыг бүгдийг нь нэгтгээд Их Хурлын дэгийн тухай хуульд байгаа хуралдаан даргалагчийн эрхийн дагуу 10.12-т заасны дагуу хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэсэн энэ заалтын дагуу бүх асуудлуудыгаа хэлэлцэж дууссаны дараагаар зарчмын зөрүүтэй саналууд бас манай Байнгын хорооны гишүүд бас нэлээдгүй гаргах юм байна. Энийгээ нэгтгэж санал хураалтаа явуулъя гэдэг ийм асуудал. Ингэж шийдвэрлээ. Ингээд хоёр дахь асуудлыг санал хураалт, зарчмын зөрүүтэй саналуудыг түр хойшлуулъя.

Гурав дахь асуудал руугаа оръё. Ажлын хэсэгт баярлалаа.

13.23 цаг.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсгийг мөн танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийн нэрс байна уу? Ажлын хэсэг Ж.Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цогтнаран Татварын ерөнхий газрын дарга, Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны

Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга, Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга, Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд байна.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Бямбасүрэн, Соронзонболд, Сэддорж нараас Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дэх “5 хувиар” гэснийг “7.5 хувиар” гэж өөрчлөх тухай санал гаргаж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэнийг төсөлд тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд бас хүргүүлсэн байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-д заасны дагуу гишүүд асуулт асуух боломжтой байна. Гишүүд асуулт асуух гишүүн байна уу заалттай холбоотой?

Асуулт асуух гишүүн алга байна.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд уншиж танилцуулна. Дараагийн асуудалд орёе.

13.20 цаг.

Дөрөв. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Ажлын хэсгийн дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Жаргалан, Очирбат нараас 2026 оны 06 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн төсөл буюу Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг 2026 оны 06 сарын 29-ний өдөр хуралдаж, хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу зарчмын зөрүүтэй 1 саналыг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2.1-д заасны дагуу хураалгахаар, мөн 42 дугаар зүйлийн 2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн гэсний дагуу зарчмын зөрүүтэй саналын томьёолол 2-ыг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Заяабал: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Ерөнхий сайдын зөвлөх, Сүхээгийн Тэнгис Ерөнхий сайдын зөвлөх, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Жамбалдоржийн Мягмарсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг төсөлд тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-д заасны дагуу гишүүд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгаас асуулт асуух боломжтой байгаа. Ингээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Ингээд санал хураалт эхлэхээр байгаа. Санал хураалтуудыг өмнөх хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-т заасны дагуу нэгтгэн санал хураалтыг явуулъя. Ингээд гурав дахь асуудлыг хэлэлцэж дууслаа. Хойшлуулъя санал хураалтыг.

13.23 цаг.

Тав дахь асуудал Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдааныг 15 минут завсарлуулъя. Гишүүд бас энэ хооронд танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Ингээд сүүлийн асуудал хэлэлцээд санал хураалт явуулахаар байгаа гэдгийг гишүүдэд хэлье.

13.24 цаг.

Байнгын хорооны хуралдаан 13 цаг 24 минутаас 16 цаг 15 минутад түр завсарлав.

Б.Заяабал: Бүгдээрээ Эдийн засгийн байнгын хорооны хорооны хурлаа үргэлжлүүлье. Хэлэлцэх асуудал 5 дээрээ явж байсан.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 25, 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх хэсэгт заасны дагуу зарчмын зөрүүтэй 4 саналын томьёолол болон тус хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгсөн.

Ажлын хэсэг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж, чуулганы нэгдсэн хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу нийт 4 зарчмын зөрүүтэй санал, томьёолол болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд 4 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулж, Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бэлтгэсэн гүйцээн боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсан баярлалаа.

Б.Заяабал: Жавхлан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Пүрэвжавын Баянбаатар Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга, Мөнхсайханы Энхтулга Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд бас хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг төсөлд тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-д заасны дагуу гишүүд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгаас асуулт асуух боломжтой байгаа. Ингээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Уянгахишиг гишүүнд микрофон нээе.

Г.Уянгахишиг: Ашигт малтмалын тухай хуультай холбоотойгоор бас тодруулах асуулт, бас хэлэх санаа байгаад байна. Юу гэхээр өнөөдөр бид нар гол энэ Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт орж байгаа. АМНАТ-аас бусад зохицуулалтаар бол давуу тал үүсгэж байгаа буюу зайлшгүй батлагдах ёстой гэдэг дээр бол бүгдээрээ санал нэгдэж байгаа гэж харж байгаа. Харин АМНАТ-ын хувьд өсөн нэмэгдэх АМНАТ-ын хувь, хэмжээг бууруулах гэдэг дээр бол эсрэг саналтай гишүүд бас байгаад байгаа. Эсрэг тайлбар хэлж байгаа. Үүн дээр надад ойлгогдохгүй юм байгаад байгаа юм. Юу вэ гэхээр бид нар зөвхөн “Онтрэ”-той холбож тайлбарлаад байдаг Оюу толгойтой холбож тайлбарлаад байдаг. Гэтэл Оюу толгой одоо 5 хувь төлж байгаа. Нөгөө талаас. Оюу толгойтой өрсөлдөж бусад ордууд үйл ажиллагаагаа явуулахын тулд 20 хувийг төлөх болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хоёрын ялгаа өөрөө адилхан 5 хувь болох ёстой юм аа гэж бол би ойлгоод байгаа юм.

Нөгөө талаасаа “Онтрэ” гээд ороод ирлээ гээд. Тэгэхэд бид нар тэнцээ хэлцэл хийгээд явахад 50+1 өгөөж бид нарт байх ёстой. Тэгэхээр өсөн нэмэгдэх АМНАТ бага хэмжээтэй байлаа гэхэд бид нар тусгай АМНАТ-аа өндөр тогтоож явахаас өөр аргагүй болно. Хэрвээ 34 хувь биш зөвхөн АМНАТ-аараа буюу роялтигийн зарчим, “Орано”-той адилхан зарчмаа бариад явна аа гэвэл. Тэгэхээр энэ дээр өнөөдөр юу гэдэг юм 2019, 2029 оноос хэрэгжүүлнэ гээд байгаагийн гол шалтгааныг ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу. Өнөөдөр 2027 оны 01 сарын 01-нээс хэрэгжээд явахад яахаараа тэр хэлцэлд нөлөөтэй болчихоод байдаг юм? 29 он болохоороо яагаад энэ дээр нь нөгөө өөр нөхцөл байдал үүсгээд байдаг юм? Ер нь бол бид нар хэлцэл хийгээд, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад, эсвэл юу гэдэг юм тогтвортой байдлын гэрээ байгуулахад үүний дараа үүссэн татварын таатай нөхцөл бол угаасаа л үйлчилж орж ирдэг. Тэгэхээр бид нар 29 оноос 5 хувь болоод өөрчлөгдөхөд нөгөө гэрээн дээр жишээлбэл 20

хувь байсан байлаа гээд 29 оны 5 хувь үйлчлэхгүй гэдэг юм байхгүй шүү дээ. Тэгэхээр би яг энэ талаар тодруулж асуумаар байгаа байхгүй юу. Яг ингээд 29 он болгох нь яаж энэ хэлцлийн юун дээр шууд нөлөөлөөд байгаа юм бэ тооцоолол дээр? Би бол цэвэр математик утгаар нь л бодож олох гээд учрыг нь олох гээд байгаа гэсэн үг.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан гишүүний микрофон өгье.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Энэ та 29 оны 01 сарын 01 болгосонтой холбогдуулж асуулаа тээ? Яамнаас буюу Засгийн газраас оруулж ирсэн яг суурь үзэл баримтлал нь бол бас арай өөр байсан шүү. Арай хугацаа нь арай наана. Эрдэнэт дээрээ тийм өөр энэ 2 чинь ингээд өөр өөр байсан. 29 оны 01 сарын 01 болгосон нь бол ийм учиртай.

Нэгдүгээрт бол энэ эдийн засгийн гэхээсээ илүүтэй тэр шулуухан хэлье. Энэ улс төрийн ийм шийдвэр гарсан шүү дээ. 29 оны 01 сарын 01 гэдэг маань та өөрөө харж байгаа байх дараагийн Их Хурал, дараагийн Засгийн газар. Энийг шийднэ биз. Хэрвээ наана нь ийм янз бүрийн хардлага сэрдлэг ийм байгаа бол нэг мөсөн ингээд шийдчихье. Гэхдээ АМНАТ-аа бууруулъя, бусад хөрөнгө оруулагч нарыг нааш нь зэс ялангуяа энэ үнэт металлууд дээр уурхайнуудыг хөдөлгөөнд оруулъя гэсэн Засгийн газрын тэр суурь үзэл баримтлалыг бол дэмжсэн. Тэгэхдээ хугацааг нь хойшлуулсан ийм л зүйл болсон.

Нөгөө талаар ийм байгаа тэр Оюу толгойн гэрээн дээр ийм юм байгаа. Хэрвээ ингээд гэрээ хэрэгжих явцад дотор татварын хууль ч юм уу тэр орчинд хэрвээ гарсан өөрчлөлт нь одоо байгаа нөхцөлөө сайжрахаар буюу таатай нөхцөл үүсэх юм бол тэр рүү шилжинэ ээ гэсэн ийм заалт байдаг байхгүй юу. Гэхдээ яамнаас, Засгийн газраас оруулж ирсэн энэ суурь үзэл баримтлалын тэр АМНАТ-ыг бууруулах нь тэднийхээр оруулж ирснээр бууруулсан ч гэсэн Оюу толгойд таатай байдал үүсэхгүй үүсэхгүй. Бас л өндөр байгаа байхгүй юу. Уг нь хардаад байх юм байхгүй юм байгаа юм. Тийм, одоо болдог бол жишээ нь тэр дээр Эрдэнэт бол бас л ингээд чирэгдчихэж байгаа юм. Эрдэнэтийг бол бараг маргааш ч хамаагүй ингээд л бууруулчихмаар л байгаа байхгүй юу. Гэсэн хэдий ч ингээд болохгүй. Энэ чинь хууль маань өөрөө тэр чигээрээ ингээд гацчих гээд байгаа ийм эрсдэл байгаа учраас. Тэгээд энэ хууль чинь өөрөө аягүй хайран хууль байхгүй юу.

Одоо энэ АМНАТ гээд л энийг л улс төржүүлж л өндөр авчихсан авчихсан болохоос биш цаана нь энэ чинь бараг аягүй том зарчмын ийм реформын шинжтэй, энэ салбарыг тэр чигт нь хөдөлгөх, ялангуяа энэ хайгуулын, эрэл хайгуулын түвшинд нь хөдөлгөөнд оруулах ийм суурь зохицуулалтууд ороод ирчихсэн. Тэр нь хойшлох гээд байгаа эрсдэлтэй учраас арга буюу энийг хойшлуулаад ингээд л зохицуулалт хийж байгаа л зүйл юм байгаа юм. Ийм л хариулт. Одоо яамнаас нэмэлт хариулт байвал хариулна биз дээ.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүн нэмэлт тодруулга уу? Нэмэлт тодруулга Уянгахишиг гишүүний микрофон өгье.

Г.Уянгахишиг: Харин тийм. Тэгэхээр яг миний ойлголт нэгдмэл л байна л даа. Тэгэхээр бид нар юу гэдэг юм улс төрийн нөхцөл байдал ч гэдэг юм уу, улс төрийн шийдвэр гэдгээрээ ингээд нөгөө буцаад уул уурхайгаа явуулах, буцаад

шинэ ордууд ашиглалтад орох, дээрээс нь ордуудынхаа юу гэдэг юм ашигт ажиллагаа буюу жишээлэх юм бол Эрдэнэт дээр гэхэд чинь л өртгөө дийлэхгүй байгаа тэр хэсгээ бид нар олборлож эхэлмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү нөгөө математик тооцоолол нь энгийн байгаад байхад энийг ингээд улс төржиж байна, юу гэдэг юм муу хүн болчих гээд байна гэж байгаа юм шиг тэгээд дээрээс нь нөгөө улс төржилт яваад нөгөө хайгуулын лицензүүдийг олон болгох, хайгуулын үйл ажиллагаагаа дэмжих, нөгөө баялгийн сангийнхаа орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайгаа дэмжих гэдэг энэ бүх бодлого чинь зүгээр л улс төржилтийн үр дүн болоод байхгүй болно гэдэг чинь аягүй харамсалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бид нар бас аягүй сайн ухаалаг байх ёстой бол гэж.../минут дуусав./

Б.Заяабал: Санал хэллээ Уянгахишиг гишүүн. Үүрийнтуяа гишүүний микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Ашигт малтмалын хуулийн АМНАТ-тай холбоотой заалт 42.5-ыг хойшлуулсан. Хойшлуулсан үндэслэл юунаас болсон бэ, яагаад хойшлуулах болов оо гэхээр “Онтрэ”-гийн хэлэлцээрийг хийх хүртэл хугацаанд хойшлуулах шаардлагатай гэдэг саналыг Батнайрамдал гишүүн Монгол Ардын намын бүлэг дээр гаргасантай холбоотой энэ асуудал өнөөдрийг хүртэл үргэлжлээд явж байгаа. Үргэлжлээд явж байгаа. Шалтгаан нь юу юм гэж, хойшлуулах ямар шалтгаан юм? “Онтрэ”-гийн хэлцлийг хийх хүртэл гэхээр “Онтрэ” гэж юу юм, “Онтрэ”-той яагаад холбогдоод байгаа юм энэ АМНАТ-ын өсөн нэмэгдэх хувь, хэмжээ. “Онтрэ” бол компани. “Рио Тинто” компанийн үйл ажиллагаа явуулж байгаа Оюу толгой төсөл үндсэндээ 3 бүлэг ордоос бүрдэж байгаа. Херуга, Хюго Оюут. Оюутын орд бол өнөөдөр ил уурхай явуулж байгаа. Хойд Хюго-гийн өмнөд Хюго гээд 2 том ордын хамгийн том нь хойд. Энэ нийт манай нөөцийн, Оюу толгойн нөөцийн Оюу толгойн бүлэг ордын нөөцийн 50-аас илүү хувь нь энд байгаа. Энэ орд бол дэлхийд маш томд тооцогдох цөөхөн ордын нэг. Маш баян агуулгатай, нэлээн гүнд байдаг ийм орд. Энэ ордын хойд хэсэг нь хойд Хюго-гийн хойд талын хэсэг нь, дээр нь Хюгогийн тал нь энэ “Онтрэ” гэдэг компанийн эзэмшиж байгаа 2 лиценз дээр байгаа. 2 лицензийн асуудал. Өнөөдөр. Энэ “Онтрэ”-гийн хэлцлийг хий гэдэг бол “Онтрэ” гэдэг компанитай хэлцэл хийхийг тулгаж АМНАТ-ын хуулийг хойшлуулж байгаа юм л даа. Магадгүй хамаагүй “Онтрэ”-той ч байна уу, “Рио Тинто”-той ч байна уу тэр 2 лицензээ ашиглах хэлцлийг бид хийж болно. Гэхдээ өнөөдөр техник эдийн засгийн үндэслэл нь “Онтрэ” дээр гараагүй байгаа.

“Рио Тинто”-гийн туйлын хүсэл, мөрөөдөл бол өөрийнхөө ТЭЗҮ дотор оруулж бодсон “Рио”-гийн захиалгаар хийлгэсэн ТЭЗҮ дотор байгаа энэ “Онтрэ”-гийн ордыг яг энэ ТЭЗҮ-гийнхээ хүрээнд батлуулж аваад одоо байгаа хөрөнгө оруулалтын гэрээ, одоо байгаа нөхцөл рүүгээ санхүүгийн хөрөнгө оруулалтын нэртэй санхүүгийн луйврын схем рүүгээ оруулах л хүсэлтэй. Туйлын хүсэл мөрөөдөл нь энэ шүү дээ. Хамаагүй бид нар “Онтрэ”-той ч юм уу эсвэл өөр газар хийе. “Рио”-той хийж болно. Тэгвэл Оюу толгой эзэмшиж байгаа, одоо явж байгаа төсөл тусдаа. Дахиад бид энэ “Онтрэ” дээрээ тусад нь ТЭЗҮ хийж энэ асуудлаа гаргах ёстой гэж би үзэж байгаа юм. Хөрөнгө оруулалтын гэрээгээрээ тохирч явах ёстой гэж үзэж байгаа юм. Тэгэхээр манай зарим гишүүд энэ бол АМНАТ-ын өсөн нэмэгдэх хувиа бууруулчихаар “Онтрэ” дээр бага АМНАТ ноогдуулах гээд байна аа гэж буруу ойлголттой ч байна, зарим нь толгой эргүүлчхэж байна. Ард иргэдийн толгойг эргүүлж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 42-ын штрих 2.2 дахь заалтад өсөн нэмэгдэх АМНАТ-ыг хязгаар 5 хувь байсныг нь авчихсан. Өнөөдөр бид нар суурь 5 хувь дээрээ нэмэх боломжтой. Энэ дээр Уул уурхайн яам ямар байр.../минут дуусав./

Б.Заяабал: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамдинням гишүүн хариулъя.

Г.Дамдинням: Би бол өмнө нь өгч байсан тайлбараа л өгье. Хуулийн хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлэг гээд хэлэлцүүлгүүд дээр бол би яг байр сууриа л илэрхийлж байсан. Засгийн газраас орж ирсэн төсөл нь бол хөдлөхгүй байгаа зэсийн 20-иод төслийг хөдөлгөмөөр байна аа л гэж орж ирсэн. Тэгэхдээ тэгээд энэ асуудлыг улс төр болгож явуулсаар байгаад тэгээд л Монгол Ардын намын бүлгийн шийдвэр гарсан. Би Ардын намын гишүүн, төлөөлөл тэгээд тэр бүлгийн шийдвэрээ л дагана шүү дээ. Өөр гарц алга.

Ер нь бол энэ ингээд шийдэгдэхгүй явлаа гэхэд намрын чуулганаар энэ хугацааг наашлуулах тусгайд нь ганц заалттай хууль өргөн барьж болно шүү дээ. Гишүүдэд бас тийм гарц нь байгаа. Одоо бол нэгдүгээр хэлэлцүүлэг өнгөрчихсөн. Эцсийн хэлэлцүүлэг дээр явж байгаа байхгүй юу. Гэхдээ яг тоо баримт тийм юмны хувьд бол Үүрээ гишүүн бол үнэнг л хэлээд байгаа юм. “Онтрэ”-той холбоотой асуудал байна. “Онтрэ”-той холбоотой асуудал дээр Монгол Улсын Засгийн газар “Рио Тинто” компанитай сая хэлэлцээ хийгээд өчигдөр бас та бүхэнд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. “Онтрэ”-той холбоотой асуудал дээр бол энэ “Онтрэ” болон “Рио Тинто”-гийн хооронд өмнө нь тохирчихсон гээд байгаа энэ тохиролцоог Монгол улс хүлээн зөвшөөрөхгүй. Шинээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна. Шинээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна. Нэг.

Хоёрдугаар асуудал бол бид энэ ТЭЗҮ-ийг нь 2024 онд тусад нь салга гэдэг даалгавар өгөөд хүлээж аваагүй. Одоо бол энэ Оюу толгойн бүлэг ордынх нь хэмжээнд ТЭЗҮ хийчихсэн байгаа юм. Тэгэхээр бид бол энэ “Онтрэ” дээр хэлэлцээгээ эхлүүлээд тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т нийцүүлж нийт өгөөжийн 51 хувийг Монгол Улсдаа 50 болон, 51 болон түүнээс дээш хувийг Монгол Улсдаа авах ийм л хэлцэл хийнэ. Хэлэлцээ. Өөр юм бол байхгүй. Энд хэд хэдэн зүйлээс уул уурхайн төслүүдээс орлого, ашиг орж ирдэг. Улсын төсөвт 3 чиглэлээр орж ирж байгаа юм. Нэгдүгээрт татварын орлого. Хоёрдугаарт бусад хураамжууд. Гуравдугаарт энэ ноогдол ашиг, тэгээд АМНАТ явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр АМНАТ буухад бол ноогдол ашиг өснө. АМНАТ буухад бол ашгийн татвар өснө. Тоо харвал ийм л юм байгаа юм. Уг нь бол хамаагүй. Тэгэхдээ нэгэнт улс төрийн шийдвэр гарчихсан учраас би бол одоо эхний хэлэлцүүлгээрээ явчихсан байгаа энэ томъёоллоороо яваад дууссан нь дээр ээ л гэж харж байгаа. Манай яамны байр суурь бол энэ. “Онтрэ”-гийн хэлэлцээр хийгдээд дуусчихвал хугацааг шууд наашлуулах боломжтой. Бүрэн эрх нь Улсын Их Хуралд байгаа. Хуулийг явуулах. Энэ хууль бол өөрөө маш олон шинэчлэлийг хийж байгаа. Зөвхөн энэ дээрээсээ болоод ухарчихмааргүй байгаа байхгүй юу. Тийм учраас хуулиа явуулах хүрээнд бид бол энэ анхны хэлэлцүүлгээр дэмжигдчихсэн байгаа саналаараа л явчихъя гэсэн байр суурьтай байгаа.

Б.Заяабал: Үүрийнтуяа гишүүнд тодруулга өгье.

Д.Үүрийнтуяа: Би бас Монгол Ардын намын гишүүн л дээ. Надад эрх ашгаа эрэмбэлэх сэтгэл бас байна. Хувийн эрх ашгаасаа илүү би намын эрх ашгийг тавина. Намын эрх ашгаас илүү би улс орны эрх ашгийг нэгд тавина. Энэ бол Монгол Улсын эдийн засгийн, тусгаар тогтнолын, аюулгүй байдлын асуудал. Би танаас Засгийн газар “Онтрэ”-гийн, Засгийн газарт сая хэлэлцээр хийсэн. Маш үр дүнтэй хэлэлцээр хийсэн. Өчигдөр зарлалаа. Ийм хардалт явж байна. Энэ хэлэлцээрийг хийхэд “Онтрэ”-г барьцаалж “Онтрэ”-г өгнө өө гээд тохирсон зүйл байгаа юу үгүй юу гэдэг дээр нэгдүгээрт тодорхой хариулт өгөөч.

Хоёрдугаарт зэсийн үнэ өсөхөд АМНАТ-аа бууруулдаг тэнэг орон байхгүй ээ гэж зарим улс, гишүүд яриад байгаа юм. Харин ч би олон улсын судалгааг хараад зэсийн үнэ өсөж байгаа үед, ашигт малтмалын үнэ өсөж байгаа үед АМНАТ-аа бүүр тэглэж бууруулж нөөцөө нэмэгдүүлдэг бодлого байдаг. Энэ бодлогыг Уул уурхайн яам хэрэгжүүлэх боломжгүй юу. Болом.../минут дуусав./

Б.Заяабал: Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: “Рио Тинто” групптэй 2 чиглэлээр хэлэлцээр хийгээд бас маш амжилттай дуусгасан. Ингэхэд Монгол Улсын Засгийн газар “Рио Тинто”-гийн өмнө ямар ч амлалт үүрэг, аваагүй болохыг хариуцлагатайгаар мэдэгдье. Ямар нэг үүрэг, хариуцлага бид нарт байхгүй.

Гэхдээ нэг ийм юмыг бас хэлье. Юу вэ гэхээр одоо энэ ордыг бүлэг ордынх нь хэмжээнд ашиглаж байж бид эдийн засгийн үр өгөөжөө эерэг болгож авах юм. Тийм учраас бид хэлцэл хийнэ. Хийгдсэн хэлэлцээ Их Хуралд танилцуулагдана, олон нийтэд танилцуулагдана. Тэгж байж шийдвэр гарна. Хэлэлцээгээ эхлүүлээд ярилцах ёстой, тооцооллоо гаргах ёстой ийм байгаа. Ордын нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг Засгийн газраас оруулж ирсэн. Дунд нь улс төрийн шийдвэр гарсан. Тийм учраас би улс төрийн шийдвэрийг дагана.

Б.Заяабал: Үүрийнтуяа гишүүн нэмэлт тодруулга, минут.

Д.Үүрийнтуяа: Бүлэг ордын хэмжээнд Оюу толгойг ашиглаж байж үр дүнгээ өгнө өө гэдэг таны үг бол “Онтрэ”-г “Рио”-д өгнө өө гэсэнтэй адилхан сонсогдож байна. Тэгж сонсогдож байна. Бүлэг ордын хэмжээнд газар зүйн тогтцын хувьд, нөөцийн хувьд энэ нэг орд боловчиг эрх зүйн системийн хувьд ялгаатай. Эрх зүйн хувьд 2 компани эзэмшиж байгаа. “Рио Тинто” компани, Засгийн газартай хэлэлцээрт орохын өмнө “Онтрэ”-той тохироод энэ 2 лицензийг “Рио” нэр дээрээ авах гэж хүсэлтээ өгсөн Монгол Улсын Засгийн газарт. Харин манай Засгийн газар эндээс татгалзсан юм байна лээ. Туйлын хүсэл мөрөөдөл энэ 2 лицензийг авах дээр явж байгаа. Энэ 2 лицензийг бид “Рио”-д өгөх юм бол өнөөдөр Оюу толгойн төсөл дээр “Рио”-гийн хийж байгаа хэлэлцээр энэ өнгөрсөн 15, 6-н жилийн хугацаанд ямар байгаад өнөөдрийг хүрсэн яг ийм жишиг рүү бид нар “Онтрэ”-г оруулна.

Б.Заяабал: Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: Яах вэ Үүрийнтуяа гишүүнээ бас улс төр хийхдээ нэгнээ бас бодож хийх ёстой шүү. Хэн ч аль ч ордыг хэнд ч бэлэглэх гээгүй. Энийг бас бодож ярина шүү дээ. Бид нар бас нэг улсын төлөө зүтгэж байгаа хүмүүс шүү дээ. Тийм болохоор би бол өөрт чинь юмыг хэлье Үүрийнтуяа гишүүн ээ. “Онтрэ”-г хэнтэй ч хамтарч хийх байсан Монгол Улс өгөөжийнхөө 51-ээс дээш хувийг авах гэрээ л

хийнэ. Үгүй бол Монгол Улсад оруулж ирэхгүй. Гол асуудал бол, гол асуудал бол бид уул уурхайн орд газруудаасаа өгөөжөө авах Үндсэн хуулийнхаа заалтыг биелүүлэх л үүргээ биелүүлэх ёстой. Түүнээс биш хэн нэгэнд өгөх гээд, бэлэглэх гээд, наагуур, цаагуур ороод байгаа юм байхгүй. Энэ дээр бас үгээ бодож хэлбэл зүгээр байна шүү л гэж хүсье.

Б.Заяабал: Гишүүд. Батнайрамдал гишүүний микрофон өгье.

О.Батнайрамдал: Дамдинням сайдтай ялт ч үгүй мэргэжлийн сайдын хувьд яг даацтай үгээ зөв хэлж байна. Тантай 100 хувь санал нэг байна. Тэгээд Үүрийнтуяа гишүүн ээ та тийм байсан бол тэгээд Хянан шалгах түр хорооны тэр 3 өдрийн сонсголыг сонсоогүй байна шүү дээ. Юу ч ойлгоогүй байна. 3 өдрийн сонсголоо сонсохгүй яасан бэ. 120 дугаар тогтоол батлагдаж байхад эсрэг гарсан хүмүүсийн нэг нь та шүү дээ. Тэгээд тэрийгээ тайлбарлаарай.

Өнөөдөр ингээд “Онтрэ”-г тойроод ярьж байгаад ингээд л яг үнэнийг хэлэхэд маш их баяртай байна. 2024 оны 12 сард Ванкуверийн арбитрын шүүх дээр шийдвэр гараад Оюу толгой руу энэ бид нарын өнөөдөр яриад байгаа “Онтрэ”-гийн 2 лиценз шилжиж байсан байхгүй юу. Монголын татварын албан дээр бодолт яваад ер нь сар хоцорчихсон байсан бол энэ 2 лиценз аль түрүүн шилжчихсэн байх байсан. Тэр үед бид нар энэ Хянан шалгах түр хорооны хэдэн гишүүд чинь дуугарч байгаад түр хороо байгуулаад Улсын Их Хурал маань бүгдээрээ дэмжээд ингээд сонсгол хийгээд 120 дугаар тогтоолыг баталсан юм.

Тэгээд Монгол Улс чинь ингээд гурав дахь том гэрээ нь “Онтрэ” дээр ингээд сая Дамдинням сайдын хэлж байгаа яг ингээд хийгдэх юм байна гээд. Энэ бүх асуудал шийдэгдчихсэн юм. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд хамаарахгүй юм байна гэдгийг сонсголоор дуу нэгтэй Монголчууд нэг талдаа гарчихсан юм. Сонсголоо үзсэн бол энэ дээр ийм юм ярьж байхгүй л байсан байх л даа. Тэгээд ийм “Онтрэ” ийм том үр дагавартай хэдэн тэрбум доллар яригдаж байгаа ийм том гуравдагч гэрээ, гурав дахь гэрээ л дээ Оюу толгой, “Орано”-гийн дараах том гэрээ бол “Онтрэ” дээр байгуулагдах нь. Тэгэхээр энэ гэрээ байгуулагдаж байхад хамгийн чухал зүйл бид нар 34 хувиа авах уу, эсвэл АМНАТ-аар орлуулах уу гээд АМНАТ-аар орлуулах уу гээд л ингээд л ярихад чинь бид нар юу харах вэ гэхээрээ Монгол Улсын хууль дээр байгаа зэсийн АМНАТ-аа л харна шүү дээ.

Тэгэхээр яг энэ яриа хэлэлцээр ямар ч байсан Засгийн газар сая бүүр сайд нь гарч ирээд бүүр зогсооно гэж байгаад ямар ч байсан үр дүн гаргаж авлаа шүү дээ. Энэ үр дүнгээ цаашаагаа үргэлжлүүлээд 120 дугаар тогтоол дээр бид нар чиглэл өгсөн шүү дээ 53 өгөөжтэй хүргэхийн тулд. Тэгэхээр ингэхийн тулд ингээд л ажиллаж байгаа байхгүй юу. Энэ үед нь бид нар тэр зэсийн АМНАТ-ыг нь бууруулчихаар яаж ч манай тал тэрэнд сайн зүйл болохгүй л байхгүй юу даа. Тэгэхээр энэ “Онтрэ”-гийн хэлцлийг бүгдээрээ тэгэхээр өнөөдрийн энэ АМНАТ-аар нь эцэслэхье. “Онтрэ”-гийн хэлэлцээр хийсний дараа тэгээд тэр зэсийн АМНАТ-ыг бууруулах байна уу тэрийгээ хийгээд явж болно шүү дээ.

Тийм учраас бүлэг дээр шийдвэр гараад “Онтрэ”, Ашигт малтмалын тухай хуулийг явуулахдаа зэсийн АМНАТ-ыг нь хойшлуулаг гэдэг агуулга дэмжигдээд явсан юм анхны хэлэлцүүлэг дээр. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүн дийлэнх гишүүд нь дэмжээд ингээд явчихсан юм. Тэгэхээр энэ “Онтрэ”-гийн Засгийн газар бас нэлээн хүнд нөхцөлд хийнэ л дээ тэр “Онтрэ”-гийн хэлэлцээр. Тэгэхээр энэ үед

нь бүх талаар нь Монголчууд нэг талдаа гараад дэмжээд ингээд явуулчихмаар байгаа юм. Энэ бол ингээд түүхэнд үлдэх гурав дахь том хэлэлцээр болох юм. Тэр үед нь зэсийн АМНАТ-ыг нь бууруулж өгөөд сул тал үүсгэчихгүйн тулд л ингэж байгаа юм. Тэгээд “Онтрэ”-гийн гурав дахь том хэлэлцээр хийсний дараа хэрвээ үнэхээр 29 оноос өмнө хийгдчих юм бол тэрийгээ.../минут дуусав./

Б.Заяабал: Батнайрамдал гишүүн үг хэлчихлээ. Очирбат гишүүний микрофон өгье.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Харин яг энэ Ашигт малтмалын тухай хуультай Эдийн засгийн мэргэжлийн байнгын хорооны гишүүд зарчмын зөрүүтэй олон саналтай байгаад байгаа юм. Ойлголтын зөрүүнүүд их байгаад байгаа юм. Нэгдсэн нийлбэр гарахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр яаж байна гэхээр цаана нь ерөөсөө нэг эрх ашиг байна л гэж харж байгаа юм. Хэрвээ бид нар олон хуулийн төслийг Байнгын хороогоороо хэлэлцдэг, асуудлыг хамтарч яриад шийдээд ард иргэдийнхээ талд Үндсэн хуульдаа нийцүүлээд асуудал явдаг. Тэгэхээр яг энэ хуультай холбоотойгоор бол олон талын мэтгэлцээнүүд үүсэж байгаа, ойлгомжгүй байдлууд их үүсэж байгаа юм. Үүрийнтуяа гишүүний хөндөөд байгаа асуудал бол зөв бас. Энэ чинь бүлэг орд гээд Оюу толгойд өгөөд явуулах юм уу энэ чинь бас зөв. Нэг.

Батнайрамдал гишүүн бол энэ дээр бүтэн ажиллаад Их Хурлын тогтоол гаргуулчихсан. Ойлголтын ингээд зөрүү гараад байгаа байхгүй юу. Дамдинням сайд өөрийнхөөрөө, засгаасаа, кабинетаасаа, мэргэжлийн, яамныхантайгаа нийлээд хуулийн төслийг өргөн бариад оруулаад ирчихсэн. Тэгэхээр ийм ойлголтын зөрүүтэй байгаад байгаа болохоор хэдүүлээ энэ дээр бас нэлээн анхаарч энэ хуулийн төсөл дээр цаашаа хэлэлцүүлэг батлах, батлахгүй, зогсоох, хойшлуулах, ойлголцох ийм зөвшилцлийн орон зайгаа гаргаж авсан нь дээр байх гэж нэгд бодож байна.

Хоёрт гэх юм бол хуулийн төсөлтэй холбоотой би урьд нь Эдийн засгийн байнгын хороон дээр бас 3 асуулт асуугаад тодорхой хариулт аваагүй. Мэргэжлийнхэн сууж байгаа болохлоор дахиад асуултаа асууя. 2018 оны Засгийн газрын тогтоолоор 100-аад аж ахуйн нэгжүүдэд ингээд хохирчихсон юм байна лээ. 150-аад лиценз. Тэгээд энэ асуудлаа энэ хуулиараа цэгцэлж шийдэж оруулж ирэх ёстой байсан. Энийг яагаад орхигдуулж байгаа юм. Энийг яаж хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг асуултдаа хариулт авмаар байна.

Хоёрт гэх юм бол энэ хуулийн гол зорилго байгаа юм. Эрэл хайгуулын ажлаа нэмэгдүүлье ээ гээд байгаа юм. Хайгуул хийх боломж, бололцоо байхгүй байна гээд байгаа юм. Энэ жил бол энэ чинь сонгон шалгаруулалтаар бараг 100 гаран тэрбум төгрөгийн орлого орчихсон байгаа юм билээ. Өмнөх жил 158 орчим тэрбум төгрөгийн орлого олчихсон байгаад байгаа юм билээ. Тэгээд нийт Монгол Улсын газар нутгийг сая 500м² талбай дээр хайгуул хийгээд хэдэн төгрөгөөр төсвөөр хайгуул хийх вэ гэхээр 280 орчим тэрбум гээд байгаа юм. Тэгэхээр мэргэжлийн яам өөрсдөө энэ энэ хэмжээний мөнгийг төвлөрүүлчхээд хийгээд хайгуулаа өөрсдөө хийгээд, өөрсдөө бодлогоо зангидаад явах боломж, бололцоо байхгүй байсан юм уу? Яг хайгуул хийх чадвартай хэчнээн компани байгаа юм одоо? Энийг асуумаар байгаа юм. Яг хайгуул хийх чадвартай хэчнээн компани байгаа юм. Нэртэй устай нь хэлээд өгөөрэй.

Гуравдугаарт нь АМНАТ-тай холбоотой асуудал, энэ татвартай холбоотой асуудал. Бид нар бол энэ Их Хурлын гишүүд сүүлийн үед бараг мэргэжил болгоны хүмүүс нь уул уурхай, эдийн засагч болоод байна л даа. Яагаад гэхээр асуудал нь ийм хүнд байгаад байгаа болохоор. Тэгэхээр яагаад заавал яг энэ хуулийн төсөлтэй холбоотой энэ АМНАТ-ыг бууруулах гээд байгаа юм бэ? Өнөөдөр дэлхийн зах зээл дээр хамгийн байж болох өндөр түвшиндээ хүрчихсэн. Цаашдаа дахиад 5-6 жилийн хугацаанд энэ Эй Ай буюу энэ технологийн салбар дата төвүүд чинь хөгжихөд зэсийн үнэ өсөх гээд байгаа юм. Тэгэхэд яагаад заавал энэ үнийг буулгах гээд байгаа юм энэ хуулиар? Тэгэхээр ийм үндсэн 3 асуултдаа хариулт авчхаад тодруулъя.

Б.Заяабал: Дамдинням сайд хариулъя. Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: Нэгдүгээрт сүүлийн асуултаас нь эхлээд хариулаад явъя. Зэсийн АМНАТ-тай холбоотойгоор энэ буулгах саналыг хойшлуулчихсан учраас хариулт бас ойлгомжтой болчихсон байхаа гэж бодож байна Очирбат гишүүн ээ. Өөрөөр хэлбэл, бид нар энэ хуулиар эхний хэлэлцүүлгээр та бүгд маань дэмжээд Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжээд гарчихсан. Одоо эцсийн хэлэлцүүлэг ороод л ингээд болчихно. Дундуур нь асуудал үүсчихсэн учраас энд бодвол зарчмын зөрүүтэй санал гарахгүй бол тэгээд явчих байх.

Хоёрдугаар асуудал тэр юу эрлийн ажил, хайгуулын ажил биш. Суурь эрлийн ажил. Эрэл судалгааны ажил гэж явдаг. Тэр бол зөвхөн ашигт малтмалын зорилготой хийгддэг ажил биш. Энэ бол хот байгуулалт, хөдөө аж ахуй, мал аж ахуй, аялал жуулчлал, аюулгүй байдал тэгээд л гамшиг, осол гээд л, хөрс гээд л бүгдийг нь судалдаг. Тэгэхээр энэ ажлыг бол бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийвэл дараачийн Оюу толгой, Тавантолгойг олтол удна. Яагаад вэ гэвэл намар ингээд улсын төсвөө ярьдаг. Та бүхэн өнгөрсөн жилийн улсын төсвийг харсан. Бид үнэн, Очирбат гишүүндээ бас их баярлалаа яг тоог нь хэлээд өглөө. Бид нар 100 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлчхээд эрэл судалгааны ажил дээрээ, хайгуул дээр биш эрэл судалгааны ажил дээрээ 40 тэрбум тавиулах гэж ёстой бөөн юм болдог. Арай гэж тавиулсан мөнгөө одоо авч чаддаггүй. Бүх мөнгийг нь аваад явчихдаг байхгүй юу. Гуйгаад л гүйдэг юм шүү дээ бид нар. Мөнгө тавиад өгөөч. Хэрвээ улс ингээд энд хангалттай мөнгө тавиад өгдөг бол бид нар хувийн хэвшлийнхний энэ хүчийг татах гэж оролдоод байх шаардлага байхгүй дээ. Харамсалтай нь тавьж өгдөггүй юм.

Тэгэхээр улс болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хийдэг энэ уул уурхай хөгжчихсөн орнуудын туршлагыг хэрэгжүүлье гэж байгаа юм. Канад, Казакстан гээд энэ орнууд, Оросын Холбооны Улс. Тэгэхээр энийг хийе гэж байгаа.

Эхний асуулт. Эхний асуулт бол Ашигт малтмалын тухай хуулиар одоо нөхөн олговор олгох тухай асуудал байхгүй юу. Хөөрхий өмнө нь өгчихсөн байсан лицензийг нь тусгай хамгаалалтад оруулаад тэгээд лицензүүдийг нь хураагаад авчихсан. Тэгээд шүүхээр шийдвэр гаргаж байж олгогдох юм. Тэгээд шүүхийн шийдвэр, 3 шатын шүүхийн шийдвэр нь эцэслээд гарчихсан 22 лицензтэй айл байна. Энэ айлуудтай бол манай Ашигт малтмалын газар хэлцэл хийгээд явж байна. Одоогийн хууль, эрх зүйн орчныхоо хүрээнд бол энэ асуудал шийдэгдэх бололцоотой. Дүйцүүлэлт ... эрхтэй. 9.1.3 дугаар заалтаар явах боломжтой гэж үзэж байгаа гэж үзэж байгаа. 13-аар. 9.1.13.

Б.Заяабал: Ажлын хэсэг индрийн микрофон дээр хариулах уу? Индрийн микрофон дээр гаръя. Индрийн микрофон нээе.

Б.Дашпүрэв: Очирбат гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв, 20 орчим компани үйл ажиллагаа явуулж, улсын төсвийн хөрөнгөөр болон хайгуул судалгааны ажил хийх боломжтой. Нэг ялгаатай зүйлийг нь бас танд тодруулаад хэлэхэд бид бүхэн сонгон шалгаруулалтаар явуулахдаа хуулийн хүрээнд эрдсийн хуримтлалтай талбайд хайгуул, судалгааны ажил хийх ийм боломжийг олгодог. Энэ эрлийн, эрэл, үнэлгээний ажлыг хийхэд холбогдолтой цагаан талбайг буюу ямар нэгэн эрдсийн хуримтлалгүй талбай дээрээ хувийн хөрөнгөөр буюу 280-300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж энэ хувийн хэвшил дээр хайгуул, судалгааныхаа ажлыг, суурь судалгааны ажлыг хийлгэх ийм боломжийг олгож байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Б.Заяабал: Очирбат гишүүн нэмэлт өгье.

Г.Очирбат: Ингээд маш тодорхойгүй байдал үүсгэдэг шүү манайхан. Одоо маш тодорхой хэдүүлээ ажлаа хийх хэрэгтэй. Их Хурлын 126 Их Хурлын гишүүнтэй болсон. Бүх асуудал нээлттэй, шилэн, ил тод байх ёстой. Тодорхой хариулахгүй ерөнхий ингэж хариулж бөөрөнхийлдөг үе өнгөрч байгаа шүү. Тэгэхээр энэ Ашигт малтмалын тухай хууль бол миний түрүүний үндсэн хэлдэг 3 асуудлыг хөндөж байгаа. Тэгээд энэ дээр Их Хурлын гишүүд байр сууриуд нэгтгэгдэхгүй байгаа. Бүгд зарчмын зөрүүтэй, саналуудаа гаргаж ирдэг, үг, үзэл бодлоо илэрхийлдэг, авдаг, авдаггүй юм байдаг, ажлын хэсэг дээр хасдаг, хасдаггүй юм байдаг. Ингээд бодлогоо бариад явна аа гээд юм явсаар байгаад л Засгийн газар орж ирснээрээ шийдүүлэх гэж оролддог.

Тэгээд яг тэрүүгээр нь явъя гэхээр буцаагаад нэг хариулттай болсон. Өөрсдөө хуулийн төслөө бүрэн боловсруулж орж ирж чадаагүй байж байж Их Хурлын гишүүд дээр сүүлийн үед ингээд хууль нухуулдаг болсон. Тэгээд ажлын хэсэг гаргая гээд дунд нь зуураад, тэгээд зуурсан зуурмагаа хоол болго

Б.Заяабал: Хариулт авсны, тодруулга өгнө юу. Тодруулга, Дамдинням гишүүн нэмэлт тодруулга.

Г.Дамдинням: Үгүй ээ Очирбат гишүүнээ юу хуулийг хэрхэн яаж батлах бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал шүү дээ Очирбат гишүүн тэгээд Засгийн газраас хууль орж ирж л байдаг. Харьцангуй бага зарчмын зөрүүтэй саналтай хууль шүү дээ манай хууль. Зарим хууль 280, 300 зарчмын зөрүүтэй саналтай байгааг та бас харж байгаа. Манайх 42-той орж ирсэн. Тэгээд хуулийг хэрхэн гаргах бодлого, бүрэн эрх бол та бүгд бидэнд Их Хуралд байгаа. Засгийн газар бол боловсруулсан хуулиа л оруулж ирж байгаа. Тэгээд зарчмын зөрүүтэй саналыг бид нар ардчилсан улсад амьдарч байгаа. Тэгээд л олонхынхоо саналаар хуваагаад л явдаг. Заавал санал нийлэх албагүй. Саналынхаа тоогоор шийдээд л явдаг ийм л зарчимтай улс шүү дээ хэдүүлээ. Та тэрийг надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа. Тэгэхээр манай хувьд бол 42 саналтай орж ирж байгаа хууль. Одоо хоёрдугаар хэлэлцүүлэг дээр 5-хан санал хураалттай. 5-хан зарчмын саналтай байгаа.

Б.Заяабал: Очирбат гишүүний нэмэлт тодруулга өгье.

Г.Очирбат: Яах вэ тэгээд Ардчилсан намынхан бол Ардчилсан намын гишүүд юу ч хэлээд нэмэргүй болсон. Олуулаа нийлж бүлгээрээ шахаж асуудлыг шийддэг болсон. Тэгээд тэр зарчмаараа явах байлгүй дээ. Нэг юмыг тодруулаад хэлчихье. Та “Оюу толгой”, “Онтрэ”-гийн сайт дээр гарсан мэдээллийг үзсэн байх. Та бол “Онтрэ”-той холбоотой асуудал юу ч яригдаагүй гэж ярьсан. Энэ дээр бол “Онтрэ”-той холбоотой асуудал байгаа. Биччихсэн байгаа шүү орчуулаад уншаад үзчихээрэй. Нээлттэй байгаа юм байна лээ.

Цаашдаа ер нь энэ Ашигт малтмалын тухай хуулийг сайжруулах нь бол зөв. Сайжруулаад явах ёстой бид нар. Тэгэхдээ өнгөрснийгөө, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээгээ хар аа Дамдинням сайд аа би танд хэлээд байгаа шүү дээ. Урдын тэр 100 аж ахуйн нэгж чинь 150 лицензийн асуудлаа шийдээгүй байж байж тэнд баахан хөрөнгө оруулагч нарыг гацаачхаад шинэ хөрөнгө оруулагч, шинэ хайгуул, шинэ эрэл судалгаа гэж ярих бол аягүй тийм өрөөсгөл ойлголт шүү. Мэдээж ирээдүй рүү тэмүүлж байгааг чинь ойлгож байгаа. Тэгэхдээ урдхаа шийдэх ёстой заавал. Тэгж.../минут дуусав./

Б.Заяабал: Гишүүн үг хэллээ. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Засгийн газар олонхын бүлэг энэ Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр ийм явган заль хэрэглээд өдийг хүрчихлээ. Анх Засгийн газраас Ашигт малтмалын тухай хуулийг өргөн барьсны ар дээр Батнайрамдал нарын гишүүд бас шүгэл үлээгээд тодорхой асуудал дэвшүүлсний дараа олонхын бүлэг энэ зэсийн АМНАТ-тай холбоотой асуудлаа татаж аваад хуулиа явуулъя гэж ярьсан. Тэгээд явцын дунд энэ хэлэлцэх эсэхийг нь яг энэ үндсэн дээр дэмжээд ингээд явуулсны ар дээр анхны хэлэлцүүлэг дээрээ болохлоор 3 жилээр хойшлуулах заалт оруулж ирсэн. Тэгээд тэр дэмжигдээд явсан. Гэтэл өнөөдөр олонхын бүлгийн 6 гишүүн нь энэ 3 жилээр зэсийн АМНАТ-ыг хойшлуулах асуудал дээр зарчмын зөрүүтэй санал дахиад оруулаад ирлээ.

Тэгэхээр миний асуулт юу вэ гэхлээр ер нь энэ Засгийн газрын байр суурь энэ зэсийн АМНАТ дээр яг ямар байгаа юм бэ? Та нар яг тодорхой юм хэлээдхээч. Засгийн газар бөгөөд олонхын бүлэг. Тэгээд ингээд бид нарыг ингээд л ийм удаа дараалан ингээд хэлж байгаа, ярьж байгаа юм нь өөрчлөгдөөд тэгээд ингээд хөтлөөд яваад байх юм. Тэгээд нэгдсэн нэг байр суурь тодорхойлж болдоггүй юм уу? Энэ Ашигт малтмалын тухай хууль чинь Монголын эдийн засгийн бас суурь харилцааг зохицуулж байгаа хууль шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар нэгдсэн ойлголттой баймаар байна.

Тэгээд л энэ наадам дөхөж байхад ингээд л ийм ороо бусгаа цагаар, чуулган хаах болчихсон энэ тэр гээд л. Чуулган хуралдаж байх хойгуур манай Байнгын хороо хуралдаж байна шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ.

Хоёрдугаарт өчигдөр Засгийн газар том мэдээлэл хийлээ. Улсын Их Хурал бол ямар ч мэдээлэл байхгүй сууж байлаа. Тэгээд нөгөө хэвлэлийн мэдээллээс ингээд нөгөө ийм Пи Ар хийж байгаа мэдээллээс энэ Оюу толгойтой хийж байгаа хэлэлцээрийг бид нар сонсож байна шүү дээ. Тэгэхээр Улсын Их Хурлын бодлого бол маш тодорхой 120 дугаар тогтоолоороо гарчихсан шүү дээ. 120 дугаар тогтоол батлагдаад хагас жил болчихлоо.

Гэтэл та бүхэн болохлоор Их Хурал дээрээ ирээд ямар ч зүйл ярихгүй хэр нь шууд юу юугүй хэвлэл рүү гарах юм. Тэгээд хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг

бууруулсан гэж байна. Манай 120 дугаар тогтоол дээр энэ асуудал маш тодорхой туссан. Хянан шалгах түр хорооны сонсгол дээр энэ асуудал маш тодорхой яригдсан. Үүнтэй холбоотой хэд хэдэн асуудал байна, асуулт байна. Хянан шалгах түр хорооны сонсгол дээр 24 оны эцсийн байдлаар Оюу толгой ХК-ийн нийт зээлийн үлдэгдэл 18.7 тэрбум ам.доллар гэж зарлагдсан. Үүний 5.2 тэрбум ам.доллар нь хуримтлагдсан зээлийн хүү. Яг одоогийн байдлаар Оюу толгой ХК-ийн зээлийн үлдэгдэл хэд байгаа вэ? Энэ хуримтлагдсан зээлийн хүүгээ ер нь бид нар яахаар болсон бэ та бүхний хэлэлцээрийн үр дүнд?

Хоёрдугаарт энэ хувь нийлүүлэгчдийн гэрээнд, эсвэл хөрөнгө оруулалтын гэрээнд ер нь ямар өөрчлөлтүүд орохоор яригдсан юм бэ? Бид нар нөгөө ийм та нарын хэвлэлийн мэдээтэй л байгаад байна шүү дээ. Тэгээд энэ ер нь өөрчлөлтүүд чинь хэзээ орох юм бэ? Тэгээд сая Очирбат гишүүн ч хэллээ. Ер нь бол та бүхэн өчигдөр зарласан энэ мэдээллээ наадмын өмнө ийм сайн мэдээ дуулгах, наадмын өмнө ийм оноо авахын тулд “Онтрэ”-гийн асуудлыг араар нь наймаацчихсан юм биш үү гэдэг болгоомжлол хүн болгонд байна. Бид нарт ямар ч тийм хэвлэлийн .../минут дуусав./

Б.Заяабал: Жаргалан гишүүний минутыг өгье.

Б.Жаргалан: Бид нарт ямар ч Засгийн газраас албан ёсны ийм бичиг цаасаар юм ирээгүй. Зүгээр ийм хэвлэлээр явсан мэдээг нь л харчихсан байгаа шүү дээ. Гэтэл “Рио Тинто” компани өчигдөр өөрийнхөө веб сайт дээр хэвлэлийн мэдээ тавьчихаж. Хамгийн эхний параграф нь Монгол Улсын Засгийн газартай бид “Онтрэ”-гийн төслийг урагшлуулах талаар тодорхой үр дүнд хүрлээ гээд биччихсэн байх юм. Гэтэл та нар өөр юм яриад байх юм. Тэгээд бид нар хардахаас өөр яах юм бэ? Энэ 120 дугаар тогтоол дээр бид нар “Онтрэ” бол “Оюу толгой”-н хөрөнгө оруулалтын гэрээнд хамаарахгүй ээ. Энд бол тусдаа хэлцэл хийгдэнэ ээ гэдгийг бол маш тодорхой болгочихсон. Монгол Улсын, Монголын талын байр суурь бол маш ойлгомжтой байгаа гэж бодож байгаа. Улсын Их Хурал, Засгийн газар, тэгээд олон нийт, нийгэм тээ? Тэгэхээр бид нар бол уул нь Монголчууд энэ талдаа, нэг талдаа гарчихсан шүү дээ. Гэтэл та нар ингээд ийм нөгөө ойлгомжтой мэдээлэл өгөхгүй байгаад байгаа учраас ийм хардалт, сэрдэлт яах аргагүй байна шүү дээ. Тэгэхээр энэ хардалт сэрдэлтдээ нэг мөр цэг тавихгүй бол бид нар ийм байдлаар энэ хуулийг чинь бол баталж болохгүй гэсэн байр суурьтай байна.

Б.Заяабал: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Жаргалан гишүүн яах вэ хоёр тусдаа юмыг холиод нэгийг нь нөгөөгөөр нь барьцаалах ч ямар утгатай юм бол би мэдэхгүй байна. Ашигт малтмалын хууль энэ гэрээнүүдтэй их хамаатай ч юм алга л байна л даа одоогоор. Зүгээр яах вэ би танд хэлье та бүхэн маань ажиллаад Улсын Их Хурлын 120 дугаар тогтоол гаргаад тэрний урд талд 103 дугаар тогтоол гээд гарчихсан. Засгийн газар энэ тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлаа хийгээд л явж байгаа. Яг хэрэгжүүлээд явж байна. Нэг бүрээр нь. Би таны үгийг давъя. Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээнд “Онтрэ” хамаарахгүй. Энэ бол Монгол Улсын Засгийн газрын байр суурь. Тусдаа гэрээ хийнэ, Тусдаа гэрээ хийнэ. Энийгээ аягүй та бас хийхгүй ч байж болно?. Явуулахгүй ч байж болно. Тэгээд энэ бол цэвэр Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Нэн.

Хоёрдугаарт энэ нууж хаах юм юу ч байхгүй. Яагаад вэ гэвэл бүх юм Их Хурлаар л шийдэгдэнэ шүү дээ. Та бүгдийн шийдвэрээр шийдэгдэнэ. Нуугдах юм

юу ч байхгүй. Хэнд ч амлалт өгөөгүй. Хэлэлцээрээ эхлүүлье ээ л гэсэн. Тэгээд л бол оо өөр юм байхгүй. Хэлэлцээ өөр юм байхгүй. Энийг бас ойлгоорой гэж хүсье.

Юуны хувьд бол АМНАТ-тай холбоотой асуудал дээр бол Засгийн газар энэ олонхын бүлгээс өгсөн шийдвэрийг дагаж байгаа. Олонхын бүлэг бол АМНАТ-ыг, зэсийн АМНАТ-ыг хойшлуул гэдэг чиглэл өгсөн. Бид томъёолоод та бүгдийнхээ санал хураалтаар 3 жилээр хойшлуулаад 2029 оны 01 сарын 01 гэдгээр явахаар шийдсэн байгаа. Их Хурал дээр ч дэмжигдчихсэн нэг дүгээр хэлэлцүүлэг дээр. Тэгэхээр бол байр суурь их тодорхой байхгүй юу. Энэ чинь Ардын намын тэргүүлж байгаа Засгийн газар. Ардын намын тэргүүлж байгаа Засгийн газар Ардын намын бүлгийнхээ шийдвэрийг дагана. Өөр гарцгүй.

Засгийн газрын байр суурь бол энэ шийдвэрээрээ л явна. 2029 оны 01 сарын 01 гэхэд хүртэл зэсийн АМНАТ-ыг хөдөлгөхгүй гэдэг ийм шийдвэртэй байгаа.

Б.Заяабал: Жаргалан гишүүний нэмэлт тодруулга өгье. 17 цагаас нэгдсэн чуулган дээр санал хураалттай гээд зар ирээд байна. Тийм учраас 17 цагаас бүгдээрээ Байнгын хорооныхоо хурлыг бас түр завсарлуулъя гэдгийгээ Байнгын хорооны гишүүдэд мэдэгдье. Жаргалан гишүүний минутыг эхнээс нь өгье.

Б.Жаргалан: Тэгэхээр та болохлоор “Онтрэ”-той бид нар ямар ч ямар ч, “Онтрэ”-той холбоотой ямар ч тийм шийдэлд хүрээгүй гээд байгаа. Гэтэл “Рио Тинто” компани бол веб сайт дээрээ тавьчихсан байна. Хэвлэлийн мэдээ. Дээрээс нь өчигдөр болохлоор энэ нөгөө энэ мэдээний ар дээр чинь “Онтрэ”-гийн хувьцаа бас өсчихсөн гэсэн мэдээллийг хүмүүс өгөөд байгаа. Тэгэхээр ингээд түүгээр их тийм мэдээлэл яваад байдаг. Гэтэл та энд өөр юм яриад байдаг. Тэгэхээр энэ дээр бол бид нарт маш их ойлголтын зөрүүнүүд байна. Бид нар бас ингээд нэг талдаа гарах юмнууд маш их байна. Тэгэхээр бол тэгэхээр бол энэ асуудал дээр хэдүүлээ хөнгөн хуумгай шийдвэр гаргаж огт болохгүй.

Яагаад вэ гэхлээр энэ Ашигт малтмалын тухай хууль энэ Оюу толгойн асуудал дээр чинь бол Монголчууд бүгдээрээ нэг талдаа байх байхгүй юу. Тэгж байж бид үндэснийхээ эрх ашгийг хамгаална. Ойлголт нэг байх ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Б.Заяабал: Асуулт суусан. Үг хэлчихсэн байна. Мөнхсоёл гишүүний микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Ажлын хэсэгт бас байгаа гишүүний хувьд энэ эргэлзээ тээнэгэлзлийг тайлах тал дээр бас тодруулаад маш сайн ийм хариулт өгөөсэй гэж хүсээд энэ үгийг хэлмээр байна. Дамдинням сайд аа энэ гишүүд түрүүнээс хойш асуугаад байна шүү дээ. Одоо анх энэ ажлын хэсэг үүсэхдээ ер нь энэ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа гол санаа нь АМНАТ байсан. Хамгийн гол зорилго нь.

Гэтэл үгүй ээ олон шалтгаануудын нэг нь. Тэгээд явцын дунд ийм хугацаа хойшлуулах ийм асуудал гарчихлаа шүү дээ. Шалтгаан нь ерөөсөө бид нарын бусад гишүүдийн маань итгэл үнэмшлийг авчирч чадахгүй байгаа юм чинь. Энэ дээр МАН-ын бүлгийн шийдвэр гэхээсээ илүү тэгвэл энэ 29 оны 01 сарын 01 хүртэл хойшилж байгаагаас бусад одоо орж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд ямар давуу тал, ямар өгөөж авчрахыг бат нот, ойлгомжтой, товч тодорхой хэлээд өгөөч.

Б.Заяабал: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Би бат нот ойлгомжтой хэлж өгье өө. Энд их та бүхэн маань нэг асуултыг л олон давтаад л хүн болгон асуугаад байна л даа. Тэгээд би бүгдэд чинь л хариулж байна шүү дээ. АМНАТ-ыг бууруулах бодлого бол зогсчихсон байгаа 20 төслөө хөдөлгөх уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээ бас бэхжүүлье гэсэн ийм л зорилготой орж ирсэн юм. Ингээд улс төрийн нөхцөл байдал би шулуухан л хэлье улс төрийн нөхцөл байдал болохгүй. Дээрээс нь бас энэ “Онтрэ”-той хэлэлцээр хийж магадгүй байгаад байгаа учраас, бас хардлага дагуулаад байгаа учраас Засгийн газар энэ бодлогоосоо татгалзсан. Тийм учраас бид зэсийн АМНАТ-ыг 2026 оны 01 дүгээр сарын 01 болтол хөдөлгөхгүй гэдэг шийдвэрээр явж байгаа. Энэ бол Засгийн газрын бодлого.

Өөрчлөгдөж байгаа зүйлс бол энд эрэл судалгааны ажил нэмэгдэнэ ээ. Уул уурхайн хаалт сайжирна. Одоо уул уурхайн хаалтын төлөвлөгөө биелнэ. Байгаль орчны нөхөн сэргээлт сайжирна. Орон нутагтай хамтарч ажиллах ажиллагаа тодорхой болно. Энэ салбарыг гацааж байгаа олон асуудал шийдэгдэнэ. АМНАТ 8, 9-н том шинэчлэлийн зөвхөн нэг нь. Ганцхан энэ асуудлаас болоод энэ бүтэн шинэчлэлийг зогсоочихмооргүй байна гишүүд ээ. Тэгээд хуулийнхаа дагуу хэлэлцээд л яваад л ингээд л хэдүүлээ олонхоороо шийдээд л асуудлаар явна шүү дээ тийм ээ баярлалаа.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүний микрофоны өгье.

С.Эрдэнэбат: Би энэ санал нэгдсэн нэг л шалтгаан байгаад байгаа. Эрдэнэтийн ажилчдаас санал ирсэн. Манай Эрдэнэт 21 хувиар төлдөг. Оюу толгойд 5 хувь төлдөг. Тэгэнгүүт “Оюу толгой”-гийн 5 хувь төлдөг рүү аваачаад АМНАТ-аа бууруулаад Эрдэнэтийн 20 хувийг зөвхөн Эрдэнэтэд зориулаад 29 он болчихсон учраас Эрдэнэт чинь шинэ үйлдвэр барих гээд байгаа юм байна, шинэ орд яах гээд байгаа юм байна, зээл авах гээд байгаа юм байна.

Тийм учраас тэр АМНАТ-ынх нь мөнгөөр Эрдэнэтийн үйл ажиллагааг зээл авахгүйгээр шийдэх энэ боломжийг нь гаргаж өгөөч гэдэг энэ гарцыг харж л энэ дээр зурсан юм. Тэгсэн сүүлдээ “Онтрэ”-гийн лобби хүртэл болоод энэ тэр үү яваад орчих шиг боллоо. Тийм санаа огт байхгүй. Би бүүр харин энэ 5 хувь ер нь яах гэж болох гээд байгаа гэдэг дээр харин эсрэг байр суурьтай байгаа ер нь бол. Ер нь 5 хувь. Нэгэнт 5 хувь болгоё гэж байгаа бол Эрдэнэтэд зориулаад Эрдэнэт та нар 29 он хүртэл 21-ээрээ төл тэр болтол бид нар “Онтрэ”-г ярьж гэсэн чинь “Онтрэ” бол тэртээ тэргүй энэ Ашигт малтмалын хуультай хамаагүйгээр тусдаа цоо шинэ гэрээгээр хийхээр болох юм байна тийм үү? Тийм тийм энийг хэлэхгүй бол бас энэ чинь улс төрийн том асуудал руу бол ингээд байна.

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн үг хэллээ. Бямбасүрэн гишүүний микрофон өгье.

Ш.Бямбасүрэн: Энэ уул уурхай дээр барьж байгаа бодлого дээр уг нь Дамдины сайд уг нь нэлээн зоригтой явж байсан. Тэгээд дундуур нь ингээд л улс төрийн шийдвэр гарчихлаа гээд л ингээд л ухраад л явчхаж байгаа юм шиг санагдаж байна. Уг нь анх ярьж байснаараа бол бид нар Оюу толгойтой жоохон хатуу ярихад хэцүү байна бусад жижгэвтэр төслүүдээ хөдөлгөө гээд л энэ орж ирж байсан шүү дээ. Энэ дээр бол би бол бас ер нь зөв юм болов уу гэж бодож байсан

юм. Гэтэл одоо ингээд ухраад ороод хойшлууллаа, барилаа гээд л явж байна. Тэгээд энэ ер нь энэ нийт энэ зэсийн салбарт байгаа татварын ачаалал бол Монгол улсад бол бусад энэ зэс олборлож байгаа улсууд Чили байна. Перу байна. Австрали байна. Казахстан байна. Хамаагүй өндөр байгаа шүү дээ манайх.

Тэгээд энэ олон улсын зах зээл дээр энэ зэсийн үнэ өндөр байхад энэ салбараа уг нь ингээд жоохон солонгоруулаад ингээд яах юмаа ингээд ухарсанд нь маш их харамсаж байна. Та бол уг нь Засгийн газар, бүлэг дээрээ энийгээ сайхан хамгаалаад аваад гарч ирэх ёстой байсан. Энэ салбар чинь тэгээд энэ Оюу толгой, Эрдэнэт гэдэг хоёроос өөр ярих юмгүй болчихсон. Тэгээд ингээд гишүүд ингээд ярихаар ингээд хууль ярьж байхад төслүүдийн бүр нэр зааж ирээд яриад байгаа байхгүй юу энэ чинь. Энэ чинь салбарын асуудал ярьж байгаа шүү дээ. Тэгээд ингээд ийм салбарын ийм хэдэн төслүүдийн лобби явж байгаа юм шигээр л энэ ч болохгүй, тэр ч болохгүй, энэ давуу тал болох гэж байна гээд л яриад байна.

Тэгэхээр би шүүмжлэлтэй хандах гээд байгаа юм бол Засгийн газар ийм ийм боломжит хэдэн төсөл байсан юм, энэ энэ төслүүд нь ингэх байсан юм, ингэж манай татварын орлого буурах байсан юм, энийгээ бид нар ингэж олох байсан юм гэдэг юм аа ингээд тодорхой яриагүйгээс болоод л ингээд л энэ салбар чинь бас ингээд л унаж байна гэж би бол хувьдаа дүгнэж байна. Тэгэхээр одоо энэ зарчмын зөрүүтэй саналаас чинь болоод бараг би бол хуулийг дэмжихээргүй л болчихсон тийм болчихлоо л гэж бодож байна. Асуулт байхгүй ээ үг хэлж байна.

Б.Заяабал: Үг хэллээ ингээд асуулт асууж дуусаа. Үг хэлж дууслаа. Одоо санал хураалтыг. Үг биш асуулт юм байна шүү. Асуулт, хариулт дууслаа гэж.

Одоо санал хураалтууд байгаа. Санал хураалтуудыг өмнө нь хойшлуулсан санал хураалтаасаа эхлээд арваад 10-аад санал хураалт байгаа. Ингээд эхнээсээ эхлээд явчихъя. Хэлэлцэх асуудлын хоёрт байгаа ажлын хэсэгт баярлалаа. Одоо бол санал хураалт, санал гаргасан гишүүд саналтайгаа холбоотойгоор нэмэлт тайлбар хэлэхээр дэгтэй байгаа. Хариулт байхгүй учраас ажлын хэсэг явж байж болно.

17.01 цаг.

Ингээд хэлэлцэх асуудлын хоёр дахь асуудал болох Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаар Эрчим хүчний сайдын мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан боловсруулсан “Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал хураалт эхэлье.

Горимын санал. Анар гишүүний горимын санал өгье.

Ч.Анар: 2025 оны 12 дугаар сард Их Хурал “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 119 дүгээр тогтоол гарсан. Энэ тогтоол дээр бол илүү давхардсан утга, агуулгатай тогтоол байна. Тэгэхээр одоо бол нөгөө Их Хурлын дарга Бямбацогт даргын бол баримталж байгаа чиглэл бол Их Хурлын Засгийн газар руу өгч байгаа тогтоолуудын хэрэгжилт сул байгаатай холбогдуулаад хэрэгжихүйц, хэмжигдэхүйц Ки Пи Ай-тай хавсралттай тогтоолуудыг баталж байдаг байя гэдэг сайн жишээг

тогтоож байгаа. Тэгэхээр одоо энэ орж ирж байгаа тогтоол маань хавсралт Ки Пи Ай нэгдүгээрт байхгүй байна.

Хоёрдугаарт давхардсан утга агуулгатай 119 дүгээр тогтоолыг хэрэгжилтийн дүгнэлтийг сонсож байгаад ажлын хэсэг байгуулаад энэ тогтоолыг батлах саналтай байна. Тэгэхгүй бол одоо ингээд тогтоолууд гаргаад л байдаг, гаргаад л байдаг хэрэгждэггүй. Урд талынх нь тогтоол нь юу болсон нь мэдэгдэхгүй. Тэгэхээр энэ дээрээ 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тайланг сонсоод ажлын хэсэг гараад дахин хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Мөн ажлын хэсэг байгуулах.

Б.Заяабал: Анар гишүүний гаргасан горимын саналаар дэгийн тухай хуулийн дагуу Анар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Анар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

17.04 цаг.

Хэлэлцэх асуудлын дөрөв дэх асуудал. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг танилцуулга явуулсан байгаа.

Ингээд санал хураалт. эхлүүлъя. Санал хураалт хаана байна.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншъя.

1.Төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл. Ил тод байдал, хяналт

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсэн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.". Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүдийг санал хураалттай бэлдэхийг хүсье.

Сая уншсан томьёоллыг, томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

72 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна.

42.2.3 нь нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. Энэ саналыг бол гуравны хоёроор дэмжиж явах ийм санал байгаа юм байна.

1 дэх санал. Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийн **“ХАРИУЦЛАГА”** гэснийг **“ГОМДОЛ ГАРГАХ,”** гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг 7 дугаар зүйлтэй нэгтгэн, 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

5.1.Бизнес эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх, бизнес эрхлэгчид учирсан хохирлыг хуульд заасны дагуу нөхөн төлөх үүрэгтэй.". Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

76 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “үндэслэлгүй хяналт шалгалт хийх,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

80 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Сүүлийн асуудал Ашигт малтмалын тухай хуулийн мөн биз дээ? Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна.

17.08 цаг.

Сүүлийн асуудал Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Энэ гүйцээн боловсруулах санал авсан 5 санал байгаа. Мөн гуравны хоёроор дэмжигдэх 2 санал байгаа. Нэг нь ажлын хэсгээс гаргасан, нэг нь гишүүдээс гаргасан ийм 7 томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Гүйцээн боловсруулах авсан санал хураалтыг эхэлье.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.38.“маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардлагатай хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэх Монгол Улсын иргэнд олгох эрхийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтдаа гишүүд бэлтгэе. Уг саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

76.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29¹ дүгээр зүйл, 29² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29¹ дүгээр зүйл.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

29¹.1.Ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн олборлож байгаа эсэхэд хяналт тавих, нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг тодорхойлох, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатны төлөвлөлтөд хяналт тавих, уурхайн хажуу болон хаягдал овоолгын чулуулгийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29¹.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

29² дугаар зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа

29².1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

29².1.1.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолгын хэмжээ, уулын ажилд хамрагдсан талбай, ил болон далд уурхайн төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

29².1.2.ашигт малтмалын ордын нөөцийг хэрхэн ашиглаж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргах;

29².1.3.энэ хуулийн 29².1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно;

29².1.4.энэ хуулийн 29².1.1-д заасан хөндлөнгийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцах;

29².1.5.энэ хуулийн 29².1.1-д заасан үйл ажиллагааг хөндлөнгийн хараат бусаар хэрэгжүүлэх.

29².2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах заавар, шаардлагыг төрийн захиргааны төв байгууллага батална.". Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

76.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

76.1 хувийн саналаар. 73.1 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нартай зөвшилцсөнөөр хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.". Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсэг зөвшилцснөөр. Ажлын хэсгийн ахлагч Жавхлан гишүүний микрофон өгье.

Б.Жавхлан: Энэ дээр ингэсэн юм өмнө нь манай Бадамсүрэн. гишүүн, Наранбаатар гишүүн гээд бас орон нутагт олон жил удирдах ажил хийж байсан ийм туршлагатай гишүүдийн саналуудыг бид нар аль болох гүйцэт тусгахаар гүйцээн боловсруулах авсан юм. Тэгээд ажлын хэсэгт орсон гишүүн Наранбаатар гишүүн, Бадамсүрэн гишүүн ч гэсэн бас идэвхтэй энэ дээр саналуудаа өгсөн найруулгуудаа. Тэгээд одоо зарим өнцгүүд нь жоохон зөрөөд байсан. Тэгээд аль аль талаас нь ингээд юунуудыг нь хангаад, үзэл баримтлалуудыг нь хангаад тэгээд зөвшилцсөнөөр гэдэг нь сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга, дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг дарга, орон нутагт бол тэгээд 2 түвшнийх нь Засаг дарга нар нь зөвшилцөөд аль алиных нь хүсэл сонирхол нь ороод, тэгээд нөгөө хөрөнгө оруулагч, нөгөө ашиглалтын лиценз эзэмшиж байгаа хуулийн этгээдтэйгээ бас зөвшилцөөд тэгээд орон нутагт ээлтэй байхаар ингэж хамтарч ажиллана.

Ямар нэг хоёр дахь утга байхгүй. “Ажиллаж болно” эд нар биш шууд “ажиллана” гээд “зөвшилцсөнөөр ажиллана” гээд ингээд оруулж байгаа юм.

Тэгэхээр аль нэгэн нөхөр нь гарч давхиад зөрөөд ингээд байхгүйгээр бүгдээрээ л зөвшилцөөд ингээд баг болоод ингээд явах ёстой гэсэн л ийм л санаа шүү. Тийм. Өмнө нь бол арай жоохон өөрөөр орчихсон байсан юм болно эд нар гээд. Тэгээд нөгөө орон нутгийн, төрийн удирдах байгууллага эд нар гээд яг алийг нь хэлж байгаа нь мэдэгдэхгүй дангаараа сумын засаг дарга нь шийдчих ч юм шиг, дангаараа аймгийн дарга нь шийдчих ч юм шиг иймэрхүү байгаад байсан. Тийм учраас хөдөө орон нутагт бол сумын Засаг дарга, сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга нь нийлээд нийлж зөвшилцсөн байдлаар, мэдээж Улаанбаатарын дүүргүүд дээр бол бас л шат шатных нь 2 дарга нь зөвшилцсөн байдлаар заавал ингэж явна шүү л гэсэн ийм санаа орсон байгаа юм. Ингээд ажлын хэсэг дээр бол дэмжигдээд орж ирсэн саналыг Байнгын хороон дээр дэмжиж өгнө үү. Бас холбогдох гишүүд энэ дээр тайлбар хэлэх байх аа. Тийм та микрофон авч байгаад протоколд үлдээгээд хэлчих ямар санал байна? Өө тийм үү?

Б.Заяабал: Дэгээр ажлын хэсгийн. Санал хураалт явуулъя. Дэгийн тухай хуулиар ажлын хэсгийн гишүүд гаргасан саналтай холбоотой нэмэлт тайлбар хэлэх эрхтэй юм байна. Ингээд ажлын хэсгийн ахлагч санал хэлсэн учраас уг саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя.

69.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал руугаа орёе. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал байгаа. Уг санал бол гуравны хоёроор санал хураалт дэмжигдэх байгаа. Энэ дээр 2 санал байгаа. Ажлын хэсгээс гаргасан 1 санал, гишүүдээс гаргасан 1 санал байгаа. Өөрөөр хэлбэл, анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх ийм санал хураалт гэсэн үг. Ингээд уг саналыг, эхний ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64 штрих дүгээр зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглоно” гэснийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох” гэж өөрчилж, 64¹ дүгээр зүйлийн 64¹.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Уг саналтай холбоотой ажлын хэсгийн ахлагч Жавхлан үг хэлнэ.

Б.Жавхлан: Гишүүд ээ энийг анхаарч өгөөрэй. Энэ нөгөө найруулгын шинжтэй юм байгаа юм шүү. Тэр хар аа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглоно гээд энэ гарчиг нь ингээд өгчихсөн нь нөгөө Зөрчлийн хуультай жоохон зөрчилдөөд байгаа юм. Тэгэхээр Зөрчлийн хуультай нийцүүлж тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно гээд ингээд л өөрчилж өгөөч ээ л гэж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл хуульд нийцүүлж найруулгын шинжтэй ийм өөрчлөлт орсон. Тэгэхдээ энэ бас их чухал байгаа юм.

Б.Заяабал: Гишүүд анхааралтай байхыг хүсье. Уг саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн гаргасан саналыг. Санал хураалт.

80.8 хувийн санал буюу гуравны хоёроор дээш хувиар уг санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Энэ дээр мөн ялгаагүй Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтаар гуравны хоёроор уг санал дэмжигдэх ёстой байгаа. Уг саналыг бас уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Уянга, Соронзонболд, Ундраа, Анар, Эрдэнэбат, Анар, Бат-Эрдэнэ, Уянгахишиг, Мөнхсоёл гэсэн гишүүд байна.

Гаргасан саналтай холбоотой тайлбар хэлэх үү? Санал гаргасан гишүүн Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Өсөн нэмэгдэх АМНАТ-аа бид нар хойшлуулснаар эсвэл Эрдэнэтэд яг 1 хувьтай үлдээснээр тодорхой одоо байгаагаар үлдээснээр Оюу толгой 5 хувь олон улсын жишгийн дагуу, Эрдэнэт үйлдвэр 22 хувь төлдөг хэвээрээ л үлдэнэ ээ л гэсэн үг. Яах вэ Эрдэнэт үйлдвэрийнхээ 10 жилийн насжилтыг богиносгоод 400 сая тонн хүдрийн шороотой буулгах шийдвэр л бид нар гаргачих гээд байгаа юм л даа энд бол.

Дээр нь шинээр орж ирэх олон төслүүдэд хаалт тавьж ,хөрөнгө оруулалтыг буцаах, хөрөнгө оруулалтыг татах боломжгүй нөхцөл байдал руу оруулж байгаа учраас л энэ саналыг гаргасан юм байгаа юм. Яах вэ энэ саналыг хойшлуулаад байгаа тэр “Онтрэ”-гийн асуудал дээр бол ямар ч хамаагүй л асуудал юм байгаа юм. Өсөн нэмэгдэх татварыг хэд ч болголоо гэсэн “Онтрэ” ч байна уу өөр гаднын хөрөнгө оруулагчтай хэлцэл хийлээ гэхэд Ашигт малтмалын хуулийн 47-гийн штрих 2.2-т стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно оо гээд заачихсан юм.

Тэгэхээр үүгээр бол бид нар тусгай АМНАТ-аа тохироод үр ашгаа нийтэд нь тооцоод явчих бүрэн боломж байгаа. Энэ бол “Онтрэ”-гийн шалтгаанаар хойшлуулах ямар ч үндэслэл байсангүй. Юуны өмнө бас энэ зарчмын зөрүүтэй саналыг хамтад нь гаргасан 8 гишүүндээ талархлаа илэрхийлье. Би гишүүдийнхээ саналд хүндэтгэлтэй хандана. Энэ санал дэмжигдэж болно, дэмжигдэхгүй байж болно. Эцсийн дүндээ энэ протоколд үлдэх ёстой. Энэ бол түүх болж үлдэх ёстой. Бид хөгжлөө хурдасгах уу, хойшлуулах уу гэдэг шийдвэрийг бид нар өнөөдөр гаргах гэж байгаа юм. Ажлын хэсэг дээр яригдаагүй энгийн горимоор хэлэлцэж байгаа явцад Байнгын хороон дээр шууд гараад ирсэн ийм зарчмын зөрүүтэй

санал дээр би Улсын Их Хурлын чуулганы өмнө, хэлэлцэхийнх нь өмнө, анхны хэлэлцүүлгийн өмнө тоо баримттай, тооцоо судалгаатай мэдээллийг би 30 минут олон нийтийн хэвлэлээр бид хэлсэн, ярьсан. Санал хураалтаар 2 гишүүний саналын зөрүүтэйгээр унасан. Цаашдаа эрхэм дарга нар маань энэ хэдэн Байнгын хорооныхоо төрийн албан хаагчдыг битгий хууль бус юм руугаа уруу татаарай. Нөхөж баримт бүрдүүлж хийж энэ тэр хүмүүсийг эрсдэлтэй нөхцөл байдал руу оруулж болохгүй. Би өнөөдөр энэ тухай бас анхааруулж хэлье гэж бодож байна.

Нөгөө талдаа би одоо Батнайрамдал гишүүндээ хандаж би таны Оюу толгойн сонсголыг санаачлахад дэмжээд зурсан. Түр хороо байгуулах шийдвэрийг би дэмжээд зурсан. Түр хороонд орох хүсэлтээ хэлсэн. Харамсалтай нь би Түр хороонд орж чадаагүй. Өнөөдрийг хүртэл Оюу толгойн төсөлтэй холбоотой болох, болохгүй асуудлыг ярьж бас нийгэмд дуу хоолой болж яваад чинь, энэ асуудлыг хэлж ярихдаа хоолой чинь зангираад нулимс чинь цийлгэнэж байгаад би эх оронч сэтгэлтэй, бас эрдэм боловсролтой залуу юм даа гэж би өнөөдрийг хүртэл хүндэтгэж явж ирсэн. Тэгэхдээ би эргэлзээ төрсөн. Яагаад? Өнөөдөр энэ хэлэлцээр Оюу толгойн ТЭЗҮ-г баталж, энэ ТЭЗҮ-ний ТЭЗҮ-д орчихсон байгаа “Онтрэ”-гийн асуудлыг хөдөлгөхийн тулд л энэ нөхцөл байдал байсан юм байна. Энэ “Онтрэ” компанийн эзэмшиж байгаа 2 орд бол Монголын ард түмний үүц баялаг. Ирээдүйн хэдэн жилдээ бид нар үр хүүхэдтэйгээ идэх ёстой орд. Энийг бид нар ийм шалтгаанаар Засгийн газарт шахаа, түлхээ, ямар нэгэн дарамт үзүүлж, хууль тогтоомжийг барьцаалж ингэж шийдэж болохгүй л дээ.

Цаашдаа Засгийн газар энэ Эрдэнэтийн асуудал хаягдаад явлаа ч гэсэн ирээдүйн нөөц баялаг болсон “Онтрэ”-гийн асуудалд хэн нэгнээс хараат бусаар шийдэх ёстой шүү гэдгийг би бас энд хэлэхийг хүсэж байгаа юм. Энэ бол Монголчуудын өв хөрөнгө, өвөг дээдсээс ирсэн өв хөрөнгө хэн нэгэн компанийн, тэр тусмаа “Рио Тинто” гэдэг компанийн элдэв лоббигоор дэмжигдэж явах ёстой зүйл биш шүү. Таныг би эх орныхоо төлөө хоолойгоо зангируулаад, нулимсаа гоожуулаад зогсож байгаа болов уу гэж бодсон. Эсрэгээрээ “Рио Тинто”-гийн төлөө зогсож байсанд харамсаж байгаа гэдгээ хэлье.

Б.Заяабал: Байнгын хороон дээр. Гишүүд чимээгүй байна шүү. Гишүүд чимээгүй. Гишүүд чимээгүй байна шүү. Байнгын хороонд ирсэн гишүүдийн санал хугацаандаа хуулийн дагуу бас ирсэн гэдгийг бас энд нэмж тодруулж хэлье. Ингээд уг саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтаа явуулъя. Санал хураалт.

50 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Гүйцээн боловсруулах авсан ийм санал байгаа. Ингээд 1 дэх заалт.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

76.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

80.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

80.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 2, 3 дугаар зүйлийг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрээс “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

76.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулах уу? Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Дуусаж байгааг үүгээр мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

17.27 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР